

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

Онол, арга зүйн сэтгүүл

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрд”

(24 дэх жилдээ)

2025/01

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл
2025/01(65)
Улсын бүртгэлийн дугаар 244
24 дэх жилдээ

Дугаарыг эрхлэн гаргасан:

- Б.Энхболд *Ерөнхий редактор (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Хууль зүйн доктор, дэд профессор)*
- Э.Мөнхзул *Нарийн бичгийн дарга (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн боловсролын хэлтсийн ахлах референт)*

Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь
Хүний эрхийн Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй,
зөвхөн зохиогчийн үзэл бодол болно.

ISSN:2617-927X
ISSN:2617-9288 (цахим)

АГУУЛГА

ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ

Х.Мөнхзул

Ахмад настны эрхийн хэрэгжилт: Монгол Улсад.....5

Эндрю Бернс

Ахмад настны эрхийн олон улсын эрх зүй дэх хоосон зай:
Шинэ конвенц батлах хэрэгцээ шаардлага.....11

Беда Эпрес

Ахмад настны эрх: Олон улсын болон бүсийн стратеги,
хамтын ажиллагаа24

Ц.Батцэрэн, Э.Энхцолмон

Хүний эрхийн мэдрэмжтэй инженер мэргэжилтэнг бэлтгэхэд
зориулсан сургалтын хөтөлбөрийн агуулга.....30

Д.Мөнхцэцэг

Ахлах ангийн сурах бичигт хийсэн дүн шинжилгээ ба хүний
эрхийн боловсрол олгож буй туршлага38

О.Отгонтуяа

Гэрлэлт цуцлалттай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх
ажиллагаа: Харьцуулсан судалгаа50

Р.Очирбал

Ирээдүй хойчийн эрхийг хүлээн зөвшөөрөх онолын зарим асуудал.....63

Б.Пүрэвсүрэн

Доромжлох нь худал мэдээлэл тараах гэмт хэргийн шинжгүй гэж
дүгнэсэн Улсын Дээд Шүүхийн тогтоолд хийсэн дүн шинжилгээ76

МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА

Фернандо Пирие

Эрх зүйн антропологи. Ёс суртахууны дэг жаяг:
Хүсэл эрмэлзэл, үлгэр дуурайл.....88

ЗОЧНЫ ЯРИА

Х.Мөнхзул

Ахмадын эрхийн конвенц батлуулах түүхэн үйл явцыг урагш
ахиулахад Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний
Комисс хувь нэмрээ оруулж чадлаа117

CONTENT

ARTICLES

Munkhzul.Kh

Implementation of the Rights of Older Persons: In Mongolia.....5

Andrew Byrnes

Gaps in the International Human Rights Framework and the
Human Rights of Older Persons: Why We need a New Convention.....11

Hon.Beda A.Epres

Human Rights of Older Persons:International and Regional
Strategies and Cooperation.....24

Batseren.Ts, Enkhtsolmon.E

Curriculum Content Designed to Train Engineers with a
Human Rights-Sensitive Approach.....30

Munkhtsetseg.D

Analysis of High School Textbooks and Experiences in
Delivering Human Rights Education.....38

Otgontuya.O

Resolving Disputes Related to Marriage Dissolution:
Comparative Analysis of Legal Frameworks50

Ochirbal.R

Theoretical Perspectives on Recognizing the Human Rights of
Future Generations.....63

Purevsuren.B

An Analysis of the Supreme Court’s Decision which Ruled that
Insults Do Not Constitute the Criminal Offense of Spreading
False Information.....76

ONLY IN MONGOLIAN

FERNANDA PIRIE

THE ANTHROPOLOGY OF LAW. Moral order: Aspiration and
Emulation.....88

GUEST INTERVIEW

Munkhzul.Kh

The National Human Rights Commission of Mongolia has
contributed to advancing the historic process of adopting the
Convention on the Rights of Older Persons.....117



Х.МӨНХЗУЛ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн

АХМАД НАСТНЫ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ: МОНГОЛ УЛСАД¹

Бидний урилгыг хүлээн авч, хүрэлцэн ирсэн эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга Дашзэгвийн Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүд, ахмадууд, зочид, төлөөлөгчид, төрийн болон олон улсын байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл, хүний эрхийн хамгаалагчид Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгаж, чин сэтгэлийн мэндчилгээг өргөн дэвшүүлье. Мөн энэхүү форумыг зохион байгуулахад үнэтэй дэмжлэг үзүүлсэн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын дэлхийн холбооны Насжилтын асуудлаарх нээлттэй ажлын хэсгийн гишүүд, профессор Эндрю Бернс болон хамтран ажилласан байгууллага, хувь хүн бүрд гүнээ талархаж буйгаа онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Энэхүү илтгэлд та бүхний анхаарлыг хандуулахаар дараах 4 асуудлыг авч үзлээ.

Нэгдүгээрт Монгол Улс дахь ахмадын эрхийн асуудлаар хууль эрх зүйн орчин, хоёрдугаарт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийн мөрөөр ахмадын эрхийн асуудлаар гарсан бодит үр дүн, гуравдугаарт Монгол Улсад нэн тэргүүнд анхаарал хандуулах шаардлагатай ахмад настны эрхийн асуудал, дөрөвдүгээрт ахмадын эрхийн асуудлаар олон улсын гэрээний ач холбогдлыг энд онцолж байна.

¹ ХЭҮК-оос 2025.06.19-20-ны өдөр зохион байгуулсан “Идэвхтэй насжилт: Ахмадад ээлтэй нийгмийг бүтээх нь” Ази Номхон далайн бүсийн форумд хэлэлцүүлсэн илтгэл

Монгол Улсад 2024 оны байдлаар нийт хүн амын 11 хувь буюу 406,3 мянган ахмад настан байгаагаас 55-аас дээш насны эмэгтэй 277,8 мянга, 60-аас дээш насны эрэгтэй 128,5 мянга, нийт ахмад настнуудын 68,3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Монголчууд бид үндэснийхээ өв уламжлал, ёс заншлаа эрхэмлэж, ахмад настан, өтгөс буурлаа хүндэтгэн дээдэлдэг эртний эрхэм сайхан ёс уламжлалтай ард түмэн билээ. Энэ утгаар Монгол Улс нь Үндсэн Хуульдаа насаар ялгаварлан гадуурхахыг хориглож, Эрүүгийн хуульд ялгаварлан гадуурхах гэмт хэрэгт “насыг” авч үзэж, хариуцлага хүлээлгэхээр заасан. Түүнчлэн 2005 онд Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийг баталж, 2017 онд Ахмад настны тухай хуулийг баталснаар ахмад настны талаар бие даасан хуультай цөөхөн орны нэг болсон билээ. Энэхүү хууль нь ахмад настны эрхийг баталгаажуулж, тэдний оролцоог дэмжих, хөгжиж боловсрох нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг урьд өмнө авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрсэн түвшинг сайжруулсан юм.

Сүүлийн жилүүдэд төрөөс тэтгэврийн шинэчлэлийн бодлого хэрэгжүүлж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлж, тэтгэврийн даатгалын нэрийн данс, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, тэтгэврийг өвлүүлэх асуудлыг хуульчилсан. Үүний зэрэгцээ идэвхтэй насжилтыг дэмжих, асаргаа үйлчилгээний шинэлэг хувилбарыг бий болгох, ажлын байрыг нэмэгдүүлэх зэргээр эрхэд суурилсан хандлага, сэтгэлгээний хувьд дэвшил болсон хууль эрх зүйн шинэчлэлийг авч хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих, хяналт тавих өргөн мандат бүхий Парисын зарчимд бүрэн нийцсэн хараат бус, бие даасан үндэсний байгууллага. Хүний эрхийн Үндэсний Комиссын хяналтын нэг чухал чиг үүрэг нь жил бүр Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлдэг, бодлогын баримт бичиг болох Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл гэдгийг та бүхэн мэднэ.

Ахмад настны тухай хуулийн 2024 оны нэмэлт, өөрчлөлт, түүнийг дагаж гарсан хуулиудад Комиссын 2023 оны илтгэлийн (Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл) мөрөөр гарсан 3 гол бодлогын өөрчлөлтийг энд онцлоход таатай байна.

Монгол Улсад ахмадын тоо өсөхийн хэрээр асруулах шаардлагатай ахмадын тоо жилээс жилд өсөж байгаа ч тэдэнд үзүүлж буй тусламж, үйлчилгээний төрөл хэлбэр хангалтгүй, хүртээмжгүй байгаа, ялангуяа ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн,

цогц тогтолцоог бүрдүүлэх бодлогын хэрэгжилт хангалтгүй байгааг Комиссын илтгэлээр хөндсөн. Дээрх хуулийн нэмэлт, өөрчлөлтөд ахмад настны цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудал хуульчлагдаж, ахмад настанд үзүүлэх үйлчилгээний төрөл нэмэгдсэн байгаа нь сайшаалтай байна.

Мөн ахмад настан өөрөө хүсвэл үргэлжлүүлэн ажиллаж хөдөлмөрлөх боломж олгодоггүй, тэтгэврийн насанд хүрмэгц ажлаас чөлөөлж, тэтгэвэрт гарахыг шаарддаг асуудалд хуулийн зохицуулалт шаардлагатай байсныг өөрчилж, “65 насанд хүрээгүй бөгөөд өөрөө хүсэлт гаргаагүй байхад тэтгэвэрт гарахыг шаардах, энэ үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн гэрээ цуцлахыг хориглосон”, “өмчийн хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд ахмад настныг газрын доор болон хөдөлмөрийн хортой халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулах зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлнэ” зэрэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр шинэлэг зохицуулалтууд хуульд тусгагдсан байна.

Түүнчлэн Комиссын судалгаанд (Хүний эрхийн Үндэсний Комисс, “Улаанбаатар хотын гэр хороололд амьдарч буй ахмад настны эрх хамгаалал” судалгаа) оролцогч 4 ахмад тутмын 1 гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, ялангуяа гэр бүлийн хүрээнд үр хүүхэд нь эцэг, эхийнхээ тэтгэвэр, тэтгэмж, эд хөрөнгөд дур мэдэн халдах, дур мэдэн захиран зарцуулах, барьцаалж зээл авах зэргээр эдийн засгийн хүчирхийлэлд өртөх явдал нэлээдгүй гарч буй асуудлыг гаргаж тавьсан бөгөөд уг асуудалд хуулийн хариуцлага хүлээлгэхээр Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиудад тусгагдсан байна.

Эрхэм зочид оо,

Ахмадын асуудлыг зөвхөн нийгмийн халамжийн хүрээнд хардаг байсан үзэл хандлагыг өөрчлөх, насжилтыг хүний эрхийн асуудал гэж үзэж, эрхэд суурилсан хандлага руу шилжих, ахмад настны эрхийн хэрэгжилтэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгаж, үе хоорондын эв нэгдэл, хамтын ажиллагааг дэмжих хэрэгцээ шаардлага дэлхий нийтийн өмнө нэгэнтээ үүсжээ.

Ялангуяа нүүдэлчин соёл иргэншилтэй, цөөн хүн амтай, гэр бүлийн гурван үеийн хэлхээ холбоо нягт, үр хүүхэд нь аав ээж, ахас ихэсээ ачилдаг монгол өрх гэрийн уламжлал нь суурин соёл иргэншил, гэр бүлийн бүтэц өөрчлөгдөж буйтай холбоотойгоор улам бүр өөрчлөгдөж буй нөхцөл байдлыг бодитоор дүгнэж, цаашдын бодлого, зорилтоо тодорхойлох хэрэгцээ бидний өмнө бий болжээ.

Иймд ахмад настны эрхийг бодитоор хэрэгжүүлэх чиглэлээр анхаарах шаардлагатай дараах 6 асуудлыг онцолж байна. Үүнд:

1. Ахмад настны нийгмийн амьдралд оролцох эрхийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд нийгэм, орчны хүчин зүйлүүд ихээхэн нөлөөлж байна. Тухайлбал, ахмад настанд ээлтэй, аюулгүй орчин бүрдээгүй, тэдний онцлогт нийцсэн дэд бүтэц хөгжөөгүйгээс нийгмийн амьдралд оролцоход саад учруулдаг гэж Комиссын судалгаанд оролцогчдын 60 орчим хувь нь үзсэн байна. Ялангуяа өвлийн улиралд халтирч гэмтэж бэртэх, хөгжлийн бэрхшээлтэй болох явдал цөөнгүй гарч байна. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн мэдээлэлд осол гэмтэлд өртөж эмнэлгийн тусламж авсан ахмадуудын 62 хувь нь унаж гэмтсэн байна. Ахмад настнууд нийгмийн амьдралд оролцож чадахгүйн улмаас ганцаардах улмаар сэтгэл зүй, эрүүл мэндэд нөлөөлөх явдал түгээмэл байна. Комиссын судалгаанд оролцогчдын 64 хувь нь ялангуяа эмэгтэйчүүд ганцаарддаг, хэн нэгэнтэй сэтгэлээ хуваалцах хэрэгцээ их байна гэжээ.

Түүнчлэн ахмад настныг үеэ өнгөрөөсөн, хуучны хоцрогдсон, тэтгэврийн хүмүүс гэх зэрэг нийгмийн хандлагаас улбаатай тэднийг насаар ялгаварлах, нийгмээс тусгаарлах, хөгжлийн бэрхшээл, хүйсээр давхар гадуурхагдах явдал түгээмэл байна.

Түүх үе үеийнхэнд ялгаатай, өөр өөр хувь тавилан оногдуулдаг. Тиймээс цаг цагийн ахмадууд өөр өөрийн давтагдашгүй дурсамж замналтай, тухайн туулж өнгөрүүлсэн нийгмийнхээ тусгал нь болж төлөвшдөг гэдгийг та бид мэднэ. Ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, үе хоорондын үнэт зүйлийг эрхэмлэн, бие биеэ үгүйсгэх биш ойлголцох, дэмжих асуудлыг орхигдуулж болохгүй бөгөөд үүнд залуу үе мөн ахмадуудын маань ч оролцоо, манлайлал чухлаар тавигдаж байна.

2. Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлд тэтгэврийг тооцохдоо инфляцын түвшинтэй уялдуулж нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгаж, итгэлцүүр ашиглаж байхаар болсон хэдий ч тэтгэврийн зөрүү бүрэн арилаагүй. Тухайлбал Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолоор Итгэлцүүрийг шинэчлэн тогтоохдоо даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн хугацаанаас хамаарч ялгаатай байхаар тогтоосноос харьцангуй өндөр цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлээ тасралтгүй төлж ирсэн 2013 оноос өмнөх тэтгэвэрт гарсан ахмадууд ялгаварлагдаж, тэтгэврийн шинэчлэлийн бодлогын гадна орхигдсон зэрэг гомдлууд Комисст цөөнгүй ирсэн. Комисс энэ асуудлаар Монгол Улсын Засгийн газарт Комиссын гишүүний зөвлөмж хүргүүлсэн

ч уг зөрүүг арилгахад нийгмийн даатгалын санд 216,7 тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэр шаардагдаж буй гэдэг үндэслэлээр арга хэмжээ авагдаагүй байна.

3. Эрүүл мэндийн яам, Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагатай хамтран 2023 онд хийсэн “Монгол Улсын ахмад настны эрүүл мэндийн байдал ба үйлчилгээний хүртээмж” судалгаанд хамрагдсан ахмадуудын 72,3 хувь нь хоёр ба түүнээс дээш архаг өвчтэй, 41,7 хувь нь хамгийн сүүлд эмнэлгийн тусламж авахдаа ямар нэг бэрхшээлтэй тулгарсан гэж хариулжээ. Үүнээс үзэхэд ахмад настнууд олон төрлийн архаг өвчнөөр өвдөж, эмнэлгийн тусламж авах хэрэгцээ өндөр байдаг ч тэдэнд шаардлагатай оношилгоо, эмчилгээ, эмийн зардал хүртээмжгүй, ар гэрийн дэмжлэггүй, зөвхөн тэтгэврээр амьдардаг ахмад настнуудын хувьд эрүүл мэндийн үнэтэй, чанартай хагалгаанд орох, үйлчилгээ авах боломжгүйд хүрдэг байна. Эрүүл мэндийн салбарын бодлого, хууль эрх зүйн хэрэгжилт сул, бүтэц, тогтолцоо, зохион байгуулалтын асуудалтай, хүний нөөцийн асуудал, цалин хөлс бага, санхүүжилтийн хүрэлцээгүй байдал нь ахмад настанд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.

4. Ахмад настнууд гэр бүлийн хүрээнд сэтгэл санааны, үл хайхрагдах болон эдийн засгийн хүчирхийлэл дарамтад өртөх явдал цөөнгүй байна. 2020 оноос 2024 оны хооронд Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд хандсан нийт 13,8 мянган үйлчлүүлэгчээс нэг мянга орчим нь ахмад настан байна. 2020-2024 оны байдлаар ахмад настны эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг хэлбэрээр нь авч үзвэл хавсарсан байдлаар сэтгэл санааны хүчирхийлэл 71 хувь, эдийн засгийн хүчирхийлэл 37 хувь, бие махбодын хүчирхийлэл 22 хувь, үл хайхрагдах байдал 21 хувь, бэлгийн хүчирхийлэл 0.1 хувийг тус тус эзэлж байна. Эдгээрээс эдийн засгийн болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн ахмад настнууд хаана хандахаа мэддэггүй, гэр бүлийн дарамт шахалтаас айх зэргээр холбогдох байгууллагад мэдээлдэггүй байна.

5. Сүүлийн жилүүдэд төрийн үйлчилгээ цахимжих бодлого хэрэгжүүлж буй хэдий ч энэ нь ахмадын онцлог байдал, хэрэгцээнд тохироогүй, тэдний цахим ур чадварыг дэмжихэд чиглэсэн дорвитой ажил хийгдээгүйгээс цахим хуваагдалд өртөж байна. Комиссын судалгаагаар ахмад настны 69 хувь нь төрийн цахим үйлчилгээг авах хэрэгцээ байдаг ч веб хуудас, аппликейшны харагдах байдал, үсэг томруулах тохиргоогүй, сонгосон текстийг дуу хоолойгоор унших үйлдлийн систем байхгүйн улмаас цахим үйлчилгээг авч чадахгүй байна. 2024 онд нийгмийн халамжийн үйлчилгээнд 36,5 мянган ахмад настан шинээр

хамрагдсаны зөвхөн 775 нь цахимаар үйлчилгээ авчээ.

6. Монгол Улсад хотжилт, шилжилт хөдөлгөөн, хүн ам, өрхийн бүтэц өөрчлөгдөж байгаагаас уламжлалт гэр бүлийн гишүүдийн асран халамжлах үйлчилгээ буурч байна. Гэвч урт хугацааны асрах үйлчилгээг улсын хэмжээнд 12 газарт үзүүлж буй нь асрах шаардлагатай иргэдийн зөвхөн нэг хувьд зориулагдсан байна. Комисс 2024 онд улсын төсвийн болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг 8 асрамжийн газарт хяналт шалгалт хийхэд асрамжийн газрын байр ахмад настанд ээлтэй байдлаар төлөвлөгдөөгүй, хүртээмжгүй, стандартад нийцээгүй, тулгуур эрхтний болон харааны бэрхшээлтэй ахмад настнууд амьдрах таатай нөхцөл бүрдээгүй, сэтгэцийн өвчтэй хүмүүст зориулсан асрамжийн газар байхгүйгээс эрүүл асруулагчтай холилдсон байгаа зэрэг төсөв санхүүжилттэй холбоотой нийтлэг асуудлууд байна. Цаашид зайлшгүй асаргаа шаардлагатайгаас бусад ахмадын хувьд гэр бүл үр хүүхэдтэйгээ хэвийн амьдрах боломжийг аль болох бүрдүүлэх, сонголтыг бий болгох, ахмад настныг асардаг гэр бүлийн гишүүнийг дэмжих асуудал хангалтгүй орхигдсон байгааг хуульчлах, ялангуяа ахмад настан, хүүхэд, байнгын хэвтрийн өвчтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрах үйлчилгээг даатгалын зарчмаар санхүүжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Эцэст нь би та бүхний анхаарлыг ахмад настны эрхийн асуудлаарх олон улсын гэрээний ач холбогдолд хандуулья.

Зөвхөн манай улсын жишээгээр л авч үзэхэд 2010 онд нийт хүн амд 60 ба түүнээс настай ахмад настны эзлэх хувь 5.8 хувь байсан бол 2024 оны байдлаар 11 хувь болж 2 дахин нэмэгдсэн байна. Цаашид 2050 он гэхэд 5 хүний нэг нь ахмад настан болохоор тооцоолол гарсан байна.

Иймд хурдацтай өсөж буй насжилтын асуудал нь нийгэм, эдийн засгийн олон сорилттой тулгарч байгаа бөгөөд насжилтад бэлтгэх, нийгмийн даатгал болон халамж, эрүүл мэндийн үйлчилгээний ачааллыг зохицуулах, насжилттай холбоотой эдийн засгийн алдагдлыг бууруулах, ирээдүйд үүсэх ажиллах хүчний хомсдолыг зохицуулах зэрэг бодлогын шийдлийг дэлхийн хүн төрөлхтөнөөс шаардаж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаанд Монгол Улс зөвхөн эрүүл насжилтын бодлого стратегийг амжилттай хэрэгжүүлж, эрүүл мэндэд багахан өөрчлөлт хийж чадвал тухайлбал 55-69 насны ахмад настны чадвар бууралтын түвшинг таван хувиар багасгахад насжилттай холбоотой эдийн засгийн алдагдлыг нөхөж чадна хэмээн тооцоолсон байна.

Иймээс бид насжилтыг ойлгох, ахмад настны нийгмийн оролцоог оновчтой удирдан зохицуулах, тэдний ялгаатай олон янз байдал, хэрэгцээнд нийцсэн бодлогыг улс орнууд авч хэрэгжүүлэх, дэлхий даяар ахмадууд эрхээ хамгаалах чадавхи, оролцоог нэмэгдүүлэх, ялгаварлан гадуурхалтыг бууруулах, үндэстний хэмжээнд ахмад настны хамгаалал, хяналтыг сайжруулах, ахмад настны эрхийн талаар бие даасан олон улсын гэрээ зайлшгүй шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдрал, нөхцөл байдлыг ил гаргахад чухал нөлөө үзүүлсэнтэй адил ахмадын гэрээ ийм өөрчлөлт бий болгох боломжтой гэж харж байна. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс бүх гишүүн улсыг Засгийн газар хоорондын нээлттэй ажлын хэсгийн үйл явцад идэвхтэй оролцож, гэрээг боловсруулж, батлуулахад хүчин чармайлт гарган хамтран ажиллахыг тус форумаас батлан гаргах Улаанбаатарын уриалгаар дамжуулан уриалж байна.

Энэхүү форумд оролцогч Та бүхэн санал бодлоо нээлттэй илэрхийлж, үр дүнтэй хэлэлцүүлгүүд өрнүүлж, ач холбогдол бүхий шийдлүүд гарна гэдэгт итгэлтэй байна.

Эцэст нь хэлэхэд ахмад хүнийг үеэ өнгөрөөсөн, хоцрогдсон хүмүүс гэж үл ойшоох, тэдний нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн бодлого хэрэгжүүлэхгүйгээр, санал бодлыг нь сонсохгүйгээр 65 дээш насныхан хэмээн хомрогдсон бодлого явуулж, нийтээр нь тэтгэвэрт суулгах зэргээр үнэ цэнэтэй, арвин их туршлагатай капиталыг нь үнэ цэнэгүй болгож байгаа явдлыг халж, ахмад хүн бүрийн боломжийг нь ашиглаж, дэмжиж байж бидний нийгэм илүү сайн хөгжиж урагшлах болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.





ЭНДРЮ БЕРНС

Австралийн Холбооны Улсын Нью Саут Уэлсын их сургуулийн Олон улсын эрх зүй, хүний эрхийн хүндэт профессор

АХМАД НАСТНЫ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ ДЭХ ХООСОН ОРОН ЗАЙ: ШИНЭ КОНВЕНЦ БАТЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА¹

1. Удиртгал

Өнөөдрийн илтгэлдээ би олон улсын хүний эрхийн эрх зүйн хүрээний ерөнхий тоймыг (2-р хэсэг) танилцуулна. Үүний дараа дараах таван үндсэн санааг дэвшүүлнэ²:

Нэгдүгээрт, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцуудад ахмад настнууд болон тэдний эрхийн талаар цөөн тооны тодорхой заалт орсон бөгөөд энэ нь тэдний хүний эрх үл үзэгдэх, гадуурхагдах байдалд хүргэж байгааг дурдана. Хүн бүрийн нэгэн адил ахмад настнууд ч эдгээр баримт бичгүүдээр баталгаажсан эрхийг бүрэн эдлэх ёстой (3-р хэсэг).

Хоёрдугаарт, бодит амьдрал дээр олон улсын хүний эрхийн байгууллагууд болон механизм, журам нь ахмад настны эрхийн асуудлыг хангалттай хэмжээнд хөндөж, шийдвэрлэж чадаагүй бөгөөд энэ нь уг тогтолцооны

¹ ХЭҮК-оос 2025.06.19-20-ны өдөр зохион байгуулсан “Идэвхтэй насжилт: Ахмадад ээлтэй нийгмийг бүтээх нь” Ази Номхон далайн бүсийн форумд хэлэлцүүлсэн илтгэл, албан бус орчуулга

² This paper draws in part upon Andrew Byrnes, ‘The struggle for equality, freedom and visibility: the campaign to achieve a new United Nations treaty on the human rights of older persons’ in Helen Meenan and Christa Tobler (eds), *Realising Protection from Age Discrimination: International, Regional, and National Perspectives* (Edward Elgar, forthcoming 2025)

үзэл баримтлалын гүнзгий хязгаарлалт, мөн насжилттай холбоотой асуудлыг хэрэгжүүлэлтийн түвшинд үл ойшоосны үр дүн болохыг онцолно (4-р хэсэг).

Гуравдугаарт, одоогийн эрх зүйн тогтолцооны эдгээр “хязгаарлалт, дутагдал, цоорхой”³-г хэсэгчлэн өөрчлөх замаар шийдвэрлэх боломжгүй бөгөөд үүний оронд ахмад настны эрхийн талаар шинэ, иж бүрэн, уялдаа холбоотой гэрээ буюу конвенц боловсруулж, үндсэн чиг баримжааг шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэж байна. Энэхүү шинэ конвенц нь ахмад настны эрхийг бүрэн эдлүүлэх, илүү шударга, тэгш нийгэм байгуулахад онцгой бөгөөд чухал хувь нэмэр оруулах боломжтой (5-р хэсэг).

Дөрөвдүгээрт, бид шинэ конвенцын төсөл боловсруулах ажилд оролцож эхэлж буй энэ үед ч одоо байгаа үндэсний болон олон улсын хүний эрхийн баталгаануудыг ашиглан ахмад настнуудын эрхийг илүү үр дүнтэй хамгаалах боломжтой бөгөөд тэгэх ч ёстой. Үүнд, өөр өөр нөхцөл байдал бүхий ахмад настнуудын үзэл бодлыг эрхийн тайлбар ба хэрэгжилтэд тусгахыг уриалах зэрэг олон хүчин зүйл багтана (6-р хэсэг).

Тавдугаарт, Ази болон Номхон далайн бүс нутаг шинэ конвенцын боловсруулалтад үнэтэй хувь нэмэр оруулах бүрэн боломжтой. Иймд улс орнууд, үндэсний хүний эрхийн байгууллагууд, бүс нутгийн болон дэд бүс нутгийн байгууллагууд, иргэний нийгмийн төлөөллүүд хамтран ахмад настнуудын хүний эрхийг бодитой хэрэгжүүлэх, хамгаалах үр нөлөөтэй арга замыг эрэлхийлж, тэдний оролцоо болон хувь нэмрийг конвенцын төсөл боловсруулах үйл явцад уялдуулан нэгтгэх шаардлагатай (7-р хэсэг).

2. Олон улсын хүний эрхийн эрх зүйн хүрээ гэж юу вэ?

Юуны өмнө олон улсын хүний эрхийн эрх зүйн хүрээний талаар товчхон тайлбарлая. Би олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцын тухай ярихдаа, хоёрдугаар дайны дараах 80 жилийн хугацаанд Нэгдсэн Үндэстний Байгууллага (цаашид НҮБ гэх) болон түүний төрөлжсөн байгууллагууд (жишээлбэл, Олон улсын хөдөлмөрийн байгууллага)-ын баталсан, хууль

³ *The Office of the United Nations High Commissioner for Human Rights (OHCHR) employs this phrase in two analyses of the human rights framework in relation to older persons: OHCHR, Update to the 2012 analytical outcome study on the normative standards in international human rights law in relation to older persons, Working paper prepared by OHCHR, March 2021 [OHCHR 2021 Updated Study], and OHCHR, Normative standards and obligations under international law in relation to the promotion and protection of the human rights of older persons [OHCHR 2022 Report], A/HRC/49/70 (2022). In the interests of full disclosure I should note that I acted as a consultant to the OHCHR in the preparation of these studies.*

эрх зүйн хувьд хүчин төгөлдөр олон улсын баримт бичгүүдийг онцлон хэлж байна. Эдгээр хуулиар хүчинтэй баримт бичгүүд нь мөн олон тооны хууль зүйн үүрэг хүлээлгэхгүй боловч хэм хэмжээ тогтоосон баримт бичгүүдээр дэмжигддэг. Тэдгээрийн дотроос хамгийн алдартай, хамгийн чухал нь 1948 онд баталсан Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (UDHR) юм.

НҮБ-ын үндсэн хүний эрхийн олон улсын гэрээнүүд

НҮБ-ын хүний эрхийн 9 гэрээг “үндсэн хүний эрхийн гэрээнүүд” хэмээн нэрлэсэн бөгөөд үүнд дараах гэрээнүүд багтдаг:

- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ICCPR), 1966 он (1974 он)⁴
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ICESCR), 1966 он, (1974 он)
- Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (ICERD), 1965 он (1969 он)
- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW), 1979 он (1981 он)
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (CAT), 1984 он (2002 он)
- Хүүхдийн эрхийн тухай конвенц (CRC), 1989 он (1990 он)
- Цагаач ажилчид тэдгээрийн гэр бүлийг хамгаалах тухай олон улсын конвенц (CMW), 1990
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (CRPD), 2006 он (2009 он)
- Хүчээр сураггүй алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенц (CED), 2006

Эдгээр гэрээ тус бүрийн хүрээнд бие даасан, хараат бус мэргэжилтнүүдээс бүрдсэн хяналтын байгууллага байгуулагдсан байдаг.

Ихэнх гэрээнүүд нэмэлт протоколуудтай. Зарим протокол нь шинэ эрхийг баталгаажуулдаг бол, зарим нь хувь хүн өөрийн улс орноос хүний эрх зөрчигдсөн тухай гомдол гаргах эрх олгодог, эсвэл гэрээг хэрэгжүүлдэг хороодод тухайн улсад хүний эрхийн ноцтой, системтэй зөрчил илэрсэн тохиолдолд шалгалт, мөрдөн байцаалт явуулах эрх олгодог.

Монгол Улс эдгээр есөн үндсэн гэрээний долоод нь нэгдэн орсон бөгөөд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд ч мөн нэгдсэн.

⁴ *Хаалтад байгаа онууд нь тус олон улсын гэрээнд Монгол Улсын нэгдэн орсон он болно.*

Мөн Монгол Улс олон гэрээний хүрээнд хувь хүний гомдол гаргах болон мөрдөн шалгах механизмыг хүлээн зөвшөөрсөн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйл болон Олон улсын гэрээний тухай хуулийн⁵ дагуу Монгол Улс нэгдэн орсон буюу соёрхон баталсан хүний эрхийн гэрээнүүд нь Монгол Улсын Их Хурлаар батлагдсаны дараа үндэсний хууль болох юм.

Хүний эрхийн гэрээнүүд чухал уу?

Анхдагч асуулт нь хүний эрхийн гэрээнүүд үнэхээр чухал уу гэдэг. Эдгээр нь үндэсний түвшинд хууль болон бодлогод сайжруулалт авчрах боломжтой юу, ялангуяа тэдгээрийн ашиг тусыг хүртэх ёстой иргэдийн амьдралд бодит дэвшил авчирч чадаж байна уу гэдэгт чиглэнэ.

Хүний эрхийн гэрээнүүдийн практик нөлөө олон жил маргаантай байсан. Тэд бол бүх асуудлын шийдэл биш боловч хүний эрхийн тогтолцооны үндсэн зарчим бол эдгээр гэрээнүүд нь үндэсний түвшинд өөрчлөлт хийх, иргэдийн амьдралыг сайжруулахад нөлөөлдөг, үүрэг гүйцэтгэдэгт итгэдэг явдал юм. Одоогийн байдлаар, тоон мэдээлэлд суурилсан баталгаатай нотолгоо болон чанарын өгөгдлүүд нь хүний эрхийн гэрээнүүд нь практик ашигтай үр дүн авчирдаг тохиолдол олон байдаг болохыг харуулж байна. Үүнийг үргэлж, хаана ч, бүх асуудал дээр гэж хэлж болохгүй ч гэсэн хангалттай түвшинд үр дүн үзүүлж, хууль, бодлого, өмгөөллийн хэрэгслээр ашиглахыг зөвтгөж байна.⁶

3. Одоогийн олон улсын хүний эрхийн гэрээнүүдэд ахмад нас ба насжилтын талаар туссан байдал

Тэгэхээр олон улсын хүний эрхийн стандарт, хүний эрхийн хэрэгжилт нь насжилт, ахмад настны тухай бидэнд юуг хэлж өгч байна вэ? Товчоор хэлбэл, харьцангуй цөөхөн.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пакт болон бусад ихэнх гэрээнүүдэд насжилт (ахмад нас)-ын тухай тодорхой заагаагүй байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон Цагаач ажилчдын эрхийн тухай конвенц зэрэг зарим гэрээнд насны тухай тодорхой заалт байгаа хэдий ч энэ нь цөөн тооны чухал ишлэлүүд юм.

Олон улсын хүний эрхийн гэрээнд ялгаварлан гадуурхахгүй байх баталгаа нь тодорхой насны бүлгийг шууд хамардаггүй (бусад олон

⁵ <https://legalinfo.mn/mn/edtl/16532054799901> албан бус орчуулга

⁶ Kevin L.Cope, Cosette D.Creamer and Mila Versteeg, 'Empirical Studies of Human Rights Law' (2019) 15 Ann Rev L & Soc Science 155

ангиллыг ч), гэхдээ «бусад үндсэн шалтгаан»-ны хүрээнд ахмад настны ялгаварлан гадуурхалтыг хамруулж болно гэж тайлбарласан байдаг.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пакт болон бусад гэрээнүүд нь нийгмийн хамгааллын эрхийг баталгаажуулдаг бөгөөд үүний нэг салбар нь ахмад настны тэтгэвэртэй холбоотой.

Гэвч үндсэн гэрээнүүдэд насжилт болон ахмад настны эрхийн асуудалд тусгайлан хандсан заалт тун цөөн байдаг. Энэ нь эдгээр баримт бичгүүдийн үндэс 1950, 1960-аад онд тавигдсан бөгөөд тухайн үед ахмад настны эрхийг олон улсын хүний эрхийн төлөвлөгөөнд тэр бүр чухалчилдаггүй байсантай холбоотой.⁷

Гэхдээ ахмад настай хүмүүс хүн төрөлхтний нэг хэсэг учраас Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, пактууд болон бусад гэрээнүүдэд заагдсан хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх бүрэн эрхтэй. Тиймээс эдгээр эрхийг ахмад настай хүмүүст тулгуурлан хэрэгжүүлэхэд ямар ч саад байхгүй. Гэвч бодит амьдрал дээр энэ нь маш хязгаарлагдмал хэмжээнд л явагдсан.

Зарим гэрээний хяналтын байгууллагууд ахмад настнуудад илүү их анхаарал хандуулдаг ч Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын хороодыг⁸ эс тооцвол хүний эрхийн гэрээний системийн хүрээнд ахмад настны эрхэд тогтвортой, өргөн хүрээтэй хандсан ажил хийгдээгүй байна.

Ахмад настай хүмүүсийн эрхийг ихэвчлэн харахгүй, сайн дураар орхигдуулах, эсвэл нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, ахмад настны асаргааны хэрэгцээтэй холбоотой тусламж шаардлагатай гэж ойлгох хандлага давамгайлдаг.⁹

⁷ See Committee on Economic, Social and Cultural Rights, General comment No 6, The economic, social and cultural rights of older persons, E/1996/22 (1996) 20, paras 11–12.

⁸ Each of these committees has adopted General comments on the subject and has regularly referred to aspects of older persons' human rights within the framework of their specific treaty. Committee on Economic, Social and Cultural Rights, General comment No 6, The economic, social and cultural rights of older persons, E/1996/22 (1996) 20; Committee on the Elimination of Discrimination against Women, General recommendation No 27 on older women and protection of their human rights, CEDAW/C/GC/27 (2010).

⁹ The OHCHR 2021 Updated Study concluded that 'overall it cannot be said that there is a coherent approach to the human rights of older persons that is systematically applied across the human rights treaty bodies', OHCHR 2021 Updated Study, above n 2, para 3. It also noted that in relation to the special procedures of the UN Human Rights Council, such interventions as there had been 'have tended to be ad hoc and

Ахмад настнуудыг эрх эдлэх этгээдээр хүлээн зөвшөөрөх

Өнгөрсөн хэдэн арван жилийн өмгөөллийн гол хувь нэмэр

Өнгөрсөн хэдэн арван жилд хүний эрхийн өмгөөлөл нь насжилт болон ахмад настнуудыг хэрхэн ойлгож хүлээж авах хандлагыг өөрчилж, тэдний хөгширч буй үйл явц болон нийгмийн туршлага дээр хүний эрхийн чухал өнцгийг тусгаж ирсэн. Одоо бид насжилт болон ахмад нас нь нийгэмд бий болсон ойлголт гэдгийг тодорхой ойлгож байна. Ахмад настнуудын туршлага олон янз боловч олонх нь аль нэг хэмжээгээр ахмад насны улмаас ялгаварлан гадуурхалт, үнэ цэнийн доройтол, доог тохуу, орхигдох эсвэл эцэг-эхийн байр сууринаас хандсан хандлагатай тулгардаг.

Гэсэн хэдий ч ахмад настнууд болон бусад хүмүүсийн тасралтгүй өмгөөллийн үр дүнд, ахмад настнуудыг хараат, ядуу тарчиг, тусламж хүлээгч гэж харах байр сууринаас тэднийг эрх эдэлдэг, нийгэмдээ оролцож хувь нэмэр оруулдаг иргэд гэж үзэхэд томоохон өөрчлөлт гарсан байна (энэ өөрчлөлтийг заримдаа ‘парадигмын өөрчлөлт’ гэж нэрлэдэг). Гэхдээ энэ ойлголтын өөрчлөлт одоо ч ихээхэн зам туулна.

4. Зөрчил, хязгаарлалт болон дутагдлыг илрүүлж, баримтжуулах

Насжилтын асуудлаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Нээлттэй Ажлын Хороо (OEWGA)-г байгуулсан нь

Ахмад настнуудыг эрх эдэлдэг иргэд гэж ойлгох нь улсууд болон өмгөөлөгчдийг олон улсын хүний эрхийн тогтолцоо хэр үр дүнтэй ажиллаж байгаа эсэх, ахмад настнуудын хүний эрхийг хэр хамгаалж байгаа талаар илүү нягт судлахад хүргэсэн. 2008 оноос хойш мэргэжилтнүүдийн уулзалт болон бусад тайлангуудын үр дүнд 2010 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей нь бүх гишүүн орнууд оролцох боломжтой нээлттэй ажлын хороо байгуулж, ахмад настнуудын эрхийг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэх зорилготойгоор одоогийн олон улсын хүний эрхийн хүрээнд ямар сул тал, хоосон зай байгаа болон түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар судалж, шаардлагатай бол шинэ арга хэмжээ, гэрээний хэрэгжих боломжийг авч үзэхээр шийдвэрлэсэн.¹⁰

Энэ асуудлыг “хоосон зайг олох замаар шинэ хууль тогтоомж хэрэгтэйг батлах” гэсэн хандлага нь шинэ конвенц шаардлагатай эсэх маргааныг төвөгтэй болгож байна. “Хоосон зай”-г төрөлжүүлж ангилах (жишээ нь норматив буюу хууль зүйн, үйл ажиллагааны буюу хэрэгжилтийн,

one-off interventions which, while helpful, have not necessarily been based on a coherent and holistic approach to the human rights of older persons that is more broadly sustained’. Id at para 4.

¹⁰ UNGA Res 65/182, para 28.

ухамсрын буюу мэдлэгийн хоосон зай гэх мэт) нь заримдаа утгагүй мэт боловч тухайн орон улсын байр суурийг илэрхийлдэг. Норматив хоосон зай бол шинэ хууль тогтоомж шаардлагатайг, хэрэгжилтийн хоосон зай бол одоо байгаа хуулиудыг илүү сайн хэрэгжүүлэх шаардлагатайг, ухамсрын хоосон зай бол илүү их мэдлэг, ухамсрыг түгээх шаардлагатайг илэрхийлнэ.

“Боломжит хоосон зай”-ны жишээ

Жишээлбэл, НҮБ-ын үндсэн хүний эрхийн гэрээнд өвчтөнд эмнэлгийн анхаарал, тэтгэвэр, халамжийн үйлчилгээ авах тодорхой эрх байхгүй. Энэ нь “норматив хоосон зай” гэж үзэх үү? Хэрэв хамгийн дээд хэмжээнд бие махбод, сэтгэл санааны эрүүл мэндийн эрхэд эмнэлгийн анхаарал авах эрх багтдаг гэж тайлбарлах боломжтой бол энэ нь “хэрэгжилтийн хоосон зай” болно.

Мөн ахмад настнуудын эсрэг гардаг янз бүрийн хэлбэрийн хүчирхийлэл (бие махбодын, сэтгэл санааны, үл ойшоох зэрэг)-ийг таслан зогсоох, шийтгэх үүрэгтэй гэсэн тусгай заалт үндсэн гэрээнд байхгүй. Энэ нь мөн норматив хоосон зай уу? Тэгвэл одоогийн гэрээний заалтууд болох хүчирхийллийг хориглох, хувийн нууцад халдахгүй байх, хүндлэлтэй хандах эрх зэрэг нь ахмад настны хүчирхийллийн олон хэлбэрийг хамрах боломжтой гэж тайлбарлахад “хэрэгжилт”-ийн хоосон зай гэж үзэж болохоор.

Иймд энэ мэт асуудлуудыг тодорхой ялгаж ангилах нь хэцүү бөгөөд заримдаа утгагүй мэт санагдах бөгөөд энэ мэт ялгаа нь улс орнуудын байр сууринаас ихээхэн шалтгаалдаг.

Ирээдүйд илүү ашигтай асуулт: Шинэ гэрээ ахмад настнуудын хүний эрхийг хамгаалахад онцгой ач холбогдолтой юу?¹¹

Өмнөх сэдвийн хүний эрхийн конвенцуудын зохиогчид ийм чиглэлийн гэрээнүүд нь шинэ, цогц онолын суурьтай, тодорхой хууль, бодлогын зөвлөмжийг төр засаг болон бусдад өгдөг, өмгөөлөл, оролцоог идэвхжүүлдэг гэж үзэж байжээ.

Дипломат баталгаажуулалт: “Хоосон зай” байна гэдэг нь

Олон жилийн туршлагын дараа 2024 онд Насжилтын асуудлаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Нээлттэй Ажлын Хороо нь судалсан хэд хэдэн салбарт “хэрэв хоосон зай байгаа бол” гэж дүгнэж, энэ жагсаалт бүрэн бус болохыг тэмдэглэсэн.¹² Мөн шинэ конвенц нь эдгээр асуудлыг

¹¹ OHCHR Updated Study 2021, above n 2, para 8.

¹² UNGA OEWGA, ‘Decision 14/1’, A/AC.278/2024/2, pp 6-1, para 20 (31 May 2024). The areas identified were: ‘equality and non-discrimination, violence, neglect and

шийдвэрлэх зөв сонголт байж болох ч бусад арга хэмжээ ч шаардлагатай гэж тэмдэглэсэн.

Эдгээр дүгнэлт нь 2025 оны 4 дүгээр сард Хүний Эрхийн Зөвлөлд шинэ нээлттэй олон улсын засгийн газрын хоорондын ажлын бүлгийг байгуулах замыг нээсэн бөгөөд үүний гол зорилго нь шинэ конвенцын төсөл боловсруулах ажил эхлүүлэх юм.¹³¹⁴

5. Хоосон зай нь үзэл баримтлалын хууль эрх зүйн зөрчлийн илрэл

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Нээлттэй Ажлын Хорооны (OEWGA) хүрээнд хоосон зайг тодорхойлох оролдлогууд үргэлжлэхэд, эдгээр хоосон зайг зөвхөн өндөр настнуудын эрхийн асуудлыг дутуу тусгасан хуучин эрхүүдэд жижиг засвар оруулах замаар шийдэх боломжгүй болох нь илэрхий болсон. Зөвхөн олон “боломжит хоосон зай” байгаа төдийгүй эдгээр нь тусгаарлагдсан санамсаргүй асуудлууд бус, харин гэрээнүүдийн үндсэн ойлголтын хязгаарлалтын шинж тэмдэг байж болох нь тодорхой болсон.

Эдгээр хязгаарлалтууд нь өнөөгийн гэрээнүүд голдуу хүний амьдрах хугацаа уртсаж, хүн амын насжилт нэмэгдэхийн хэрээр нийгэм, хувь хүнд нөлөөлөх үр дагавар нэмэгдэж, насжилт (ageism)-ын үзэл, насжилтын нийгмийн бүтцийг анхааралгүйгээр боловсруулагдсан байсныг харуулж байна. Хэрвээ дэлхий дахинаа ахмад настнуудын эсрэг ялгаварлан гадуурхалт, орхигдох хэв маягт үр дүнтэй хариу өгөх хүний эрхийн тогтолцоо боловсруулахыг хүсвэл эдгээр ойлголт, хандлагууд уг тогтолцооны үндэс байх ёстой.

Тиймээс цогц бөгөөд уялдаатай арга барил шаардлагатай болсон. Хүний эрхийн Дээд Комиссарын газрын 2022 оны тайланд дурдсанаар: “Бүх хүн, түүний дотор ахмад настнууд ч мөн адил хүний эрх, үндсэн эрхээ бүрэн эдлэх ёстой гэсэн амлалтаа биелүүлэхийн тулд насжилтын

abuse, autonomy and independence, long-term and palliative care, social protection and social security, education, training, lifelong learning and capacity-building, access to justice, right to work, access to the labour market, economic security, contribution to sustainable development, right to the enjoyment of the highest attainable standard of physical and mental health and access to health services, social inclusion, accessibility, infrastructure and habitat (transport, housing and access), and participation in public life and in decision-making processes.

¹³ UN Human Rights Council, resolution 58/13 (3 April 2025) (<https://docs.un.org/en/A/HRC/58/L.24/Rev.1>, with co-sponsors, including Mongolia).

¹⁴ The Human Rights Council conferred on the OEIGWG the mandate “of elaborating and submitting to the Human Rights Council a draft international legally binding instrument on the human rights of older persons with the objective of promoting, protecting and ensuring the full enjoyment of human rights by older persons”. UN Human Rights Council, resolution 58/13, operative paragraph 1.

нийгмийн бүтцийг илүү гүн гүнзгий ойлгож, насжилтын үзэл ба насаар ялгаварлалтыг тодорхой ойлгож, олон янзын ахмад настнуудын туршлагыг тусгасан нэгэн цогц, нэгдсэн хүний эрхийн тогтолцоог яаралтай боловсруулж батлах шаардлагатай байна.”¹⁵ гэсэн. Түүнчлэн, ахмад настнуудын эрхийн хэрэгжилтийг сайжруулах боломж байгааг хүлээн зөвшөөрсөн ч, зөвхөн тэдгээр сайжруулалт нь шаардлагатай гэж үзэж буй нь “парадигмын өөрчлөлт” буюу “үндсэн өөрчлөлт”-ийг авчирч чадахгүй.¹⁶ Одоогийн НҮБ-ын байгууллагууд болон хүний эрхийн хяналтын механизм¹⁷ нь хязгаарлагдмал нөөц, ачаалалтай хөтөлбөр, хуралдааны хугацаа, дэмжлэгийн хомс байдлаас шалтгаалан ахмад настнуудын хүний эрхийн хэрэгжилтийг гүнзгий үнэлэх боломжгүй байна.

Иймд хүний эрхийн бусад баримт бичигт нэмэлтээр зориулагдсан шинэ, тодорхой хуульчлагдсан хэрэгсэл буюу конвенц хэрэгтэй болж байна.¹⁸

Ингээд бид өнөөдөр ямар алхам хийх ёстойгоо бодох үе дээр ирлээ.

6. Одоогийн гэрээ, процедурыг илүү сайнаар ашиглах нь

Шинэ конвенц боловсруулахыг дэмжигчид ахмад настнуудын эрхийн хүрээнд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хүний эрхийн тогтолцоо ямар ч үүрэг гүйцэтгээгүй гэж хэзээ ч хэлж байгаагүй. Харин ч энэ тогтолцоо тодорхой үүрэгтэй нь илэрхий юм. Гэсэн хэдий ч одоо мөрдөгдөж буй олон улсын гэрээ, бусад олон улсын болон үндэсний стандартыг илүү үр дүнтэй ашиглахын тулд хийгдэх ёстой, хийж болох олон зүйл бий.

Жишээлбэл, 1970-аад оны сүүл үе болон 1980-аад оны эхээр олон улсын хүний эрхийн эрх зүйн талаарх феминист шүүмжлэлүүд анх дэвшигдэж эхлэх үед эрхийн төлөө тэмцэгчид болон идэвхтнүүд хоёр чиглэлт хандлагыг баримталж байв. Энэ нь хүйсэд суурилсан тусгай гэрээ болон хүйсийн онцлогт нийцсэн хэм хэмжээг бий болгохыг зорьсон төдийгүй, мөн тухайн үеийн «үндсэн» байгууллагуудад эмэгтэйчүүдийн үзэл хандлагыг анхаарч үзэхийг шаардан, хүний эрхийн ерөнхий баталгааг эмэгтэйчүүдэд хэт давамгайл байдлаар нөлөөлдөг зөрчлүүдийг багтаасан байдлаар тайлбарлахыг уриалж байжээ. Үүнд гэр бүлийн хүрээнд, олон нийтийн дунд болон улсын зүгээс үйлдэгддэг хүчирхийллийн асуудлууд хамаарч байсан бөгөөд эдгээрийг эрх бүхий байгууллагууд ихэвчлэн мөрдөн шалгаж, хуулийн хариуцлага хүлээлгэдэггүй байсан юм.

¹⁵ OHCHR 2022 HRC Report, above n 2, para 59.

¹⁶ OHCHR 2021 Updated Study, above n 2, para 8.

¹⁷ OHCHR 2021 Updated Study, above n 2, para 7.

¹⁸ OHCHR 2021 Updated Study, above n 2, para 8.

Энэ чиглэлээрх тэмцэл нь 1979 онд батлагдсан эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцод, 1992 онд батлагдсан Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай Тунхаглалд, мөн Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын Хүчирхийлэлтэй холбоотой Ерөнхий Зөвлөмжүүдэд нөлөө үзүүлсэн билээ. Үүний зэрэгцээ Хүний эрхийн хорооны болон Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны үйл ажиллагаанд хүйсийн асуудлыг тусган авч үзэхэд илүү анхаарах нөхцөлийг бүрдүүлсэн юм. Мөн энэ нь улс орнуудын хүний эрхийн гэрээн дэх эерэг үүргийг илүү өргөн хүрээтэй, хамруулах утгаар тайлбарлахад хүргэсэн (эдгээр тайлбарыг ихэвчлэн хяналтын механизмуудад сонгогдон ажилласан эмэгтэй гишүүд, тухайлбал Австралийн Элизабет Эватт (Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хороо, Хүний эрхийн хороо) болон АНУ-ын Фелис Гаэр (Эрүүдэн шүүхийн эсрэг хороо) нар анх санаачлан гаргаж байв).

Бид ахмад настнууд, хүний эрхийн төлөө тэмцэгчид, үндэсний хүний эрхийн байгууллагууд, шүүх, хуульчид, төрийн албан хаагчид, хүний эрхийн одоогийн баталгааг илүү өргөн хүрээтэй, уян хатан сэтгэлгээгээр хандаж, эдгээр заалтыг ахмад настнуудыг илүү үр дүнтэй хамгаалахад хэрхэн ашиглаж болохыг эрэлхийлэх шаардлагатай байна. Жишээлбэл, дараах зүйлийг маргааны үндэс болгох боломжтой:

- Бие даах, хараат бус байх эрх нь яг энэ утгаараа хэрэгжинэ гэсэн үг. Ахмад настай хүн өөрийн амьдралаа хэрхэн авч явахыг шийдэх эрхтэй бөгөөд энэхүү эрх нь тэднийг чадамжгүй хэмээн үзсэн хуулийн заалт, эсхүл практик үйл ажиллагааны улмаас хязгаарлагдах ёсгүй (энэ утгаараа Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн конвенц маш их ач холбогдолтой).
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрийн харгис хэрцгий, хүнлэг бус, доромжилсон харьцаанаас ангид байх эрхийн хүрээнд улс нь ахмад настнуудыг хүчирхийллээс хамгаалах, тэднийг хүчирхийлэлгүй орчинд амьдрах боломжоор хангах эерэг арга хэмжээ авах үүрэгтэй.
- Хувийн амьдралд хүндэтгэлтэй хандах эрх нь төрөөс ахмад настнуудыг гэр бүлийн гишүүд эсвэл нийгмийн бусад хүмүүсийн зүгээс учруулж болзошгүй санхүүгийн хүчирхийллээс хамгаалах эерэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг шаарддаг.
- Эрүүл мэндийн эрх нь амьдралын сүүлчийн шатанд үзүүлэх тусламж, хөнгөвчлөх эмчилгээ (palliative care)-д хүртээмжтэй байх эрхийг ч хамарна.

- Боловсрол эзэмших эрх нь зөвхөн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой боловсролоор хязгаарлагдахгүйгээр, ахмад настнуудын насан туршийн боловсрол эзэмших, ажил хөдөлмөр эрхэлж буй эсэхээс үл хамааран суралцах эрхийг хамарч ойлгогдох ёстой.
- Хангалттай орон байртай байх эрх болон өөрийн орон гэртээ амьдрах, амьдрах орчны эрх нь ахмад настнуудыг өөрийн гэртээ амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай туслалцаа, дэмжлэг авах эрхийг багтаана.
- Хангалттай орон сууцтай байх, хувийн нууц болон гэр орондоо амар тайван амьдрах эрх нь ахмад настнуудын амьдарч буй асрамжийн байгууллагууд хүний эрхэд нийцсэн байх, тэдгээр орчинд амьдарч буй хүмүүсийн хувьд сонголтоо чөлөөтэй хийсэн байх, мөн бүх хүний эрх, эрх чөлөөгөө бүрэн эдэлж байхыг төрөөс хангах ёстой гэсэн үүргийг агуулдаг.

Мэдээж үүнээс гадна авч үзэж болох олон жишээ бий.

7. Дараагийн алхмууд: Үндэсний түвшний ба бүсийн санаачилгууд

Улс орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Одоогоор Азийн Номхон Далайн бүсийн хэдхэн улс л шинэ конвенцыг дэмжиж байгаа бөгөөд олон улс сүүлд болсон Хүний Эрхийн Зөвлөлийн тогтоолыг хамтран дэмжсэн билээ. Харин одоо хэлэхгүй чимээгүй байсан, эсвэл шийдвэр гаргаагүй улс орнууд байр сууриа илэрхийлэх цаг иржээ. Тиймээс бид төр засагтаа уриалъя:

- Ахмад настны хүний эрхийн шинэ олон улсын эрх зүйн үүрэг бүхий баримт бичгийг дэмжиж буйгаа зарлах,
- Женев дэх НҮБ-ын нээлттэй Засгийн Газрын бүлгийн ажлын хэсэгт (цаашид ажлын хэсэг гэх) идэвхтэй, бүтээлч оролцох, тус бүлгийн ажлын хөтөлбөрийг тодорхой хугацаатай боловсруулахад дэмжлэг үзүүлэх,
- Азийн Номхон Далайн бүсээс ирсэн ахмад настнуудыг уг үйл явцад бүрэн оролцуулж, тэдний санал бодлыг сонсож хүндэтгэх,
- Ахмад настны эрхийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд, хүний эрхийн үндэсний байгууллагууд, бусад хүний эрхийн бүлэглэлүүд, мэргэжилтнүүд болон сонирхогч талуудтай зөвлөлдөх үндэсний бүтэц байгуулах, ингэснээр ажлын хэсгийн ажлын үеэр гарч буй асуудлуудад байр сууриа боловсруулахад туслах,
- Ахмад настнуудыг төлөөлдөг байгууллагуудыг ажлын хэсгийн хуралд оролцохыг дэмжих,

- Ажлын хэсгийн ажлыг үр дүнтэй хийхэд шаардлагатай төсвийн саналыг дэмжих (жишээ нь холимог хуралдаан зохион байгуулах боломжийг багтаах), мөн Хүний эрхийн Дээд Комиссарын газрыг шаардлагатай дэмжлэгэр хангах,

Төрийн бус байгууллагуудыг дээрх нээлттэй ажлын хэсэгт өргөнөөр оролцох боломж олгох, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн Зөвлөл (ECOSOC)-ийн статустай биш ч Насжилтын асуудлаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Нээлттэй Ажлын Хороонд бүртгэгдсэн байгууллагуудыг багтаах, холимог оролцоог хөнгөвчлөх.¹⁹

Бүсийн түвшинд процедурын болон агуулгын асуудлыг хэлэлцэх боломжууд

Процедур болон агуулгын асуудлаар бүс нутгийн хэлэлцүүлгийг цаашид өрнүүлэх нь олон талаараа чухал ач холбогдолтой. Ийм хэлэлцүүлэг хийх тодорхой боломжит талбаруудын нэг нь НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн Эдийн засаг, нийгмийн комисс (UNESCAP) бөгөөд тус байгууллага нь Хүний эрхийн Дээд Комиссарын газрын Бангкок¹⁹ дахь бүсийн төлөөлөгчийн газартай хамтран ажиллах боломжтой.²⁰ НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн Эдийн засаг, нийгмийн комисс нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын²¹ анхан шатны хэлэлцүүлгүүдийн үед хэд хэдэн чухал техникийн шинжээчдийн уулзалтыг зохион байгуулж байсан туршлагатай бөгөөд ижил төстэй оролцоог энэхүү шинэ конвенцын төсөл боловсруулах үед ч гаргаж болох юм. Ийм төрлийн уулзалт, хэлэлцүүлгүүд нь бүс нутгийн улс орнууд, хүний эрхийн үндэсний байгууллагууд, ахмад настны байгууллагууд, техникийн шинжээчид болон бусад оролцогч талуудын хувьд бүс нутгийн ахмад настануудын дуу хоолой, үзэл бодлыг илэрхийлэх үнэт боломжийг бий болгоно. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн Эдийн засаг, нийгмийн комисс болон Хүний эрхийн Дээд Комиссарын газарт ийм үүрэг хүлээхийг албан ёсоор хүсэх, мөн энэ чиглэлд тэднийг санхүүгийн хувьд дэмжихэд улс орнууд идэвхтэй оролцох шаардлагатай байна.

¹⁹ See HRC resolution 58/13, para 7.

²⁰ HRC resolution 58/13, para 4.

²¹ See UNESCAP, *Bangkok recommendations on the elaboration of a comprehensive and integral international convention to promote and protect the rights and dignity of persons with disabilities*, A/AC/265/2003/CRP/10 and UNESCAP, *Bangkok Draft: proposed elements of a comprehensive and integral convention to promote and protect the rights of persons with disabilities*, *Regional Workshop towards a comprehensive and integral convention to promote and protect the rights of persons with disabilities*, Bangkok, 14-17 October 2003, www.un.org/esa/socdev/enable/rights/bangkokdraft.htm.

Мөн Зүүн Өмнөд Азийн Улсуудын Холбоо (ASEAN) нь өөрийн Хүний эрхийн Засгийн газар хоорондын комиссуудын хүрээнд үүрэг гүйцэтгэх боломжтой. Гэсэн ч одоогийн байдлаар тус холбооны гурван хүний эрхийн байгууллага ахмад настнуудыг үйл ажиллагааныхаа гол чиглэл болгон авч үзээгүй байна.²²

Хүний эрхийн үндэсний байгууллагууд (ХЭҮБ)

Азийн Номхон Далайн бүсийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын сүлжээ нь Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Дэлхийн холбоо (GANHRI)-той хамтран конвенцын талаарх хэлэлцүүлгийг дэмжиж ирсэн. Сүүлийн жилүүдэд БНСУ, Филиппин, Монгол Улсын хүний эрхийн үндэсний байгууллагууд голлох үүрэг гүйцэтгэсэн. Бусад Азийн Номхон Далайн төрийн бус байгууллагууд ч мөн оролцож, бүсийн хүний эрхийн үндэсний байгууллагын форумын дэмжлэгтэйгээр төр засагтаа нөлөөлөх хэрэгтэй.

8. ДҮГНЭЛТ

2025 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс ахмад настны эрхийн тухай олон улсын хууль зүйн хувьд заавал биелүүлэх шинжтэй шинэ баримт бичгийн боловсруулалтыг эхлүүлэх шийдвэр гаргасан нь ахмад настнуудын эрхийг илүү сайн хамгаалах чиглэлээрх тууштай тэмцлийн нэг чухал үе шатанд ирснийг илтгэж байна. Арав гаруй жил үргэлжилсэн хэлэлцүүлэг, уриалгын үр дүнд бид ахмад настнуудын эрхийг ирэх арван жилүүдэд бодитойгоор хангах цогц, уялдаа холбоотой эрх зүйн тогтолцооны үндэс суурийг боловсруулах хариуцлагатай бөгөөд хүнд сорилт бүхий ажлыг эхлүүлэх гэж байна.

Азийн болон Номхон далайн бүс нутгийн ахмад настнууд болон хүний эрхийн төлөө тэмцэгчид энэхүү конвенцын төсөл боловсруулах үйл явцад чухал хувь нэмэр оруулах боломжтой. Бид харилцан уялдаа холбоотой ажиллаж, Засгийн газрууд, хүний эрхийн үндэсний байгууллагууд, бүс болон дэд бүсийн байгууллагуудыг бидэнтэй хамтран ажиллахыг уриалж, бүс нутгийн ахмад настнуудын амьдралын бодит туршлага, хэрэгцээ, үзэл бодол, байр суурийг тодорхой илэрхийлж, ирээдүйн конвенцод тусгахын төлөө нэгдэн чармайх шаардлагатай байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

²² Andrew Byrnes, 'ASEAN and the human rights of older persons' in ASEM Global Ageing Center, ASEM Partners' Adoption of Human Rights-Based Elements in Elder Law: Five Case Studies (2022) 6-40.



БЕДА ЭПРЕС

Бүгд Найрамдах Филиппин Улсын Хүний эрхийн
Үндэсний Комиссын гишүүн

АХМАД НАСТНЫ ХҮНИЙ ЭРХ: ОЛОН УЛСЫН БОЛОН БҮСИЙН СТРАТЕГИ, ХАМТЫН АЖИЛЛАГАА¹

Эрхэмсэг Хатагтай, Ноёд, Олон Улсын болон бүс нутгийн байгууллагууд, Хүний эрхийн Үндэсний Хорооны төлөөлөгчид, Хүндэт оролцогчид та бүхний өглөөний амар амгаланг айлтгая.

Филиппины Хүний эрхийн комиссыг төлөөлөн та бүхний өмнө үг хэлэх болсон нь нэр төрийн хэрэг юм. Түүнчлэн, энэхүү нэр хүндтэй хэлэлцүүлэгт оролцож, ахмад настай хүмүүсийн аж байдлыг дээшлүүлэх стратегийн талаарх санал бодлоо хуваалцах боломж олгосонд талархаж байна. Өнөөдөр би хамтын ажиллагааг бэхжүүлэхийн чухлыг онцолж, бидний хамтын хүчин чармайлтын үр нөлөөг дээшлүүлэх зөвлөмжүүдийг санал болгож, ахмад настны эрхийг хамгаалах, хангах чиглэлээрх манай Комиссын үйл ажиллагааны зарим тэргүүн туршлагаас хуваалцах болно.

Тус Хороо нь 1987 онд Филиппины Үндсэн Хуулийн дагуу нийгмийн анхаарлын гадна үлдсэн, эмзэг бүлгийнхний эсрэг үйлдэгдсэн хүний эрхийн зөрчлийг шалган байцах бүрэн эрхтэй, бие даасан Хүний Эрхийн Үндэсний Байгууллага болж байгуулагдсан. Үндсэн хуулийн XIII Бүлгийн 18 дугаар Зүйлд тус Комиссын бүрэн эрхийг тунхаглаж, 1) Хамгаалах үйлчилгээ; 2) Хангах, дэмжих үйлчилгээ; 3) Цагдаагийн үйлчилгээ; 4) Урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлэх үндсэн үүргийг тодорхойлсон.

¹ ХЭҮК-оос 2025.06.19-20-ны өдөр зохион байгуулсан “Идэвхтэй насжилт: Ахмадад ээлтэй нийгмийг бүтээх нь” Ази Номхон далайн бүсийн форумд хэлэлцүүлсэн илтгэл, албан бус орчуулга

Эдгээр үйл ажиллагаа нь манай эх оронд амьдарч байгаа бүх хүн ам, мөн гадаад улс оронд амьдарч байгаа Филиппин хүмүүсийн хүний эрхийг хамгаалах, хангах бидний хүсэл зорилгыг илэрхийлж байгаа юм. Филиппинд, ахмад настнууд эрхээ эдлэх хүрээнд олон бэрхшээлүүдтэй тулгарч байна. Тухайлбал:

1. Насаар ялгаварлан гадуурхах
Ахмад настнууд хөдөлмөр эрхлэх, нийгмийн харилцаанд орох, үйлчилгээ хүртэх боломжийг хязгаарладаг ялгаварлан гадуурхалтад өртөж байна. Энэхүү ялгаварлан гадуурхалт нь тэднийг анхаарлын гадна үлдээж, тэдний амьдралын ерөнхий чанарыг бууруулж байна.
2. Нийгмийн Хамгааллын Хүртээмж хангалттай биш
Бүгд Найрамдах Улсын 11916 тоот хуулиар ядуурлын нөхцөлд амьдарч байгаа ахмад настны нийгмийн халамжийн тэтгэвэр хүртэгсдэд сар бүр 1,000 филиппин песо буюу 20 ам долларын тэтгэлэг олгох болсон. Гэхдээ маш олон ахмад хүмүүс хангалттай нийгмийн халамжийн дэмжлэг авахгүй байснаар тэд ядууралд өртөж, санхүүгийн баталгаатай бус байдалд орж байна. Тэтгэврийн тогтолцоо бүх ахмад настнуудад хүртээлтэй биш, мөн олгож байгаа тэтгэвэр амьдралын наад захын хэрэгцээг хангахад хүрэлцээтэй биш байсаар байна.
3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байх
Ахмад настнууд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртэхэд үйлчилгээний өндөр өртөг, унаа тээврийн хэрэгслийн олдоц муу, ахмадын тусламж үйлчилгээгээр мэргэшсэн үйлчилгээ хангалтгүй зэрэг байнгын бэрхшээл саадтай алхам бүртээ тулгарч байна. Хүртээмжийн хязгаарлагдмал байдал нь эрүүл мэндийн асуудлаа эмчлүүлэхгүй байх төдийгүй амьдралын чанар доройтоход нөлөөлж байна.
4. Шийдвэр гаргах түвшинд оролцох боломж, эрх мэдэл хязгаарлагдмал байдал
Ахмад настнууд тэдний эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, санхүү, амьжиргаа зэрэг тэдний амьдралын холбоотой асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох боломж байнга хязгаарлагддаг. Энэ оролцоог хязгаарлаж байгаа нь тэдний өөрийнхөө асуудлыг шийдэх эрхийг хязгаарласнаар ахмад настнуудын хүсэл сонирхол, хэрэгцээг үл харгалзсан шийдвэрүүд гарахад хүргэдэг.
5. Хүчирхийлэл, үл хайхрах, дарамтлахаас хамгаалахаас хамгаалах
Ахмад настнууд бие махбодын, сэтгэл зүйн, санхүүгийн

болон үл хайхрах зэрэг олон хэлбэрийн хүчирхийлэлд өртөх эрсдэлд байдаг. Эдгээр хүчирхийллийн тохиолдлууд ихэвчлэн мэдээлэгддэггүй, шийдвэрлэгддэггүй, хохирогч ихэвчлэн ямар ч дэмжлэг, хамгаалалтгүй байдалд үлддэг. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд бодлогын өргөн хүрээтэй шинэчлэлийг хийх, олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, ахмад настнуудын эрх, нэр төрийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаанд хангалттай нөөцийг хуваарилах шаардлагатай байна.

Саяхнаас ахмад настнуудын эрхийг бүрэн хангах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлд бүс нутаг төдийгүй дэлхийн хэмжээнд илүүтэй анхаарал хандуулж эхэлж байна. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга болон Хүний Эрхийн Дээд Комиссар, Хараат бус экспертын бэлтгэсэн ахмад настнуудын эрхийн хэрэгжилтийн талаарх илтгэлүүдэд хамгааллын чиглэлд оршиж байгаа дутагдалтай талуудыг тодорхойлж, эдгээр асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр хууль эрх зүйн баримт бичгийг боловсруулан, хэрэгжүүлэхийг зөвлөсөн байдаг.

2023 онд НҮБ-ын Насжилттай холбоотой асуудлаарх Нээлттэй ажлын хэсэг бусад оролцогч талуудтай зөвшилцсөний үндсэн дээр энэхүү дутагдалтай талуудыг шийдвэрлэх Засгийн газар хоорондын зөвлөмжийг гаргасан. Уг зөвлөмжүүдийг НҮБ-ын Нээлттэй ажлын хэсгээс 2024 оны 5-р сард болж өндөрлөсөн 14-р чуулганаар хэлэлцэж, НҮБ-ын Ерөнхий Ассамблейд танилцуулсан. Энэхүү үйл явц нь Хүний эрхийн үндэсний байгууллагуудад өөрсдийн сурталчилгааны ажлыг эрчимжүүлж, гишүүн орнуудад ахмад настны эрхэд зориулсан НҮБ-ын шинэ конвенц боловсруулах механизм байгуулахыг уриалах чухал боломжийг бүрдүүлсэн.

Ахмад настны эрхийг хамгаалах болон бүх хүмүүсийн эрхийг хангах, хамгаалах асуудал Хүний эрхийн комиссын анхаарлын төвд байнга байсаар ирсэн. Хүний эрхийн үндэсний байгууллагын хувьд бид, энэхүү амлалтаа хэрэгжүүлэхийн тулд хүний эрхтэй холбоотой тулгамдсан асуудал, бэрхшээлүүдийг тодорхойлж, ахмад настны эрхийг хамгаалах, дэмжих боломж, стратегийг тодорхойлох зорилгоор олон хэлбэрийн хөтөлбөр, хамтын ажиллагаа, зөвлөлдөх уулзалт, ухуулга нөлөөллийн ажлыг удирдан идэвхтэй оролцож байна.

Үндэсний хэмжээнд хууль тогтоох, бодлогын ажилд идэвхтэй оролцох, иргэний нийгэм болон засгийн газарт салбарын асуудлуудыг хэлэлцэх, шийдвэрлэх орон зайг бий болгох, төрийн албан хаагчид болон олон нийтэд ахмад настны эрхийн талаар мэдээлэл өгөх, боловсрол олгох,

хүний эрхийг хангаж байгаа байдалд хяналт тавих замаар ухуулга нөлөөллийн ажилд хувь нэмрээ оруулдаг. Филиппинд Хүний эрхийн комисс Засгийн газрын хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, тус улсын ахмад настнууд хүний эрхээ бүрэн эдлэх боломжийг хангах Засгийн газрын чадавхыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Комиссын зүгээс иргэний нийгмийн төлөөлөл, салбаруудын төлөөлөгчид, засгийн газрын байгууллагууд, хууль тогтоох байгууллагын ажилтнуудад ахмад настнуудын өмнө тулгарч байгаа асуудлуудыг хэлэлцэж зөвлөх боломжийг олгон нээлттэй ажилладаг. Эдгээр хэлэлцүүлгийн үеэр бид ахмад настны эрхийг хангах чиглэлд ахиц гаргах чиглэлээр хийж буй үйл ажиллагаа, хүчин чармайлтуудын талаар харилцан мэдээлэл солилцож, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай алхмуудын талаарх арга замыг эрэлхийлэн хэлэлцдэг. Эдгээр хэлэлцүүлгүүдийн хүрээнд даатгал, тэтгэврийн тогтолцоог бэхжүүлэх арга замыг эрэлхийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилт нь ахмад настны нийгмийн хамгаалал, нийгмийн аюулгүй байдлын эрхийг хангахад хэрхэн нөлөөлж байгаа асуудлууд мөн яригддаг.

Үүний зэрэгцээ бусад хүний эрхийн үндэсний байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд Филиппины Хүний Эрхийн Комисс нь бүс нутгийн болон олон улсын түвшинд Зүүн Өмнөд Азийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын форум, Ази Номхон далайн форум болон Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Дэлхийн холбооны гишүүнээр ажилладаг. Эдгээр байгууллагууд нь хүний эрхийн сэдэвчилсэн асуудлуудаар ажилладаг мэргэжлийн ажлын хэсгүүдтэй. Үүний нэг нь Насжилтын асуудал эрхэлсэн ажлын хэсэг бөгөөд Насжилтын асуудлаарх Нээлттэй ажлын хэсгийн болон гишүүн хүний эрхийн үндэсний байгууллагуудын энэ салбарт хийж буй ажлыг дэмжих, Насжилтын асуудлаарх Нээлттэй ажлын хэсгийн ажилд хувь нэмрээ оруулах, оролцоог хангах зорилгоор байгуулагдсан юм. Филиппины Хүний Эрхийн Комисс нь Насжилтын асуудал эрхэлсэн ажлын хэсэгт Ази Номхон далайн бүсийг төлөөлөн ажилладаг.

2023 оны 8 дугаар сарын 28-29-ны өдөр Филиппины Хүний Эрхийн Комиссоос Ази Номхон далайн форумтай хамтран, Солонгосын Хүний эрхийн үндэсний комисс болон Филиппины Хууль зүй шударга ёсны засаглал хүний эрхийн төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Ахмад настны эрхийг хангах нь” сэдэвт хоёр өдрийн семинарыг Ази Номхон Далайн бүсийн А түвшний хүний эрхийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх зорилгоор зохион байгуулсан.

Энэхүү семинар нь үйл ажиллагаанд уриалан дуудсан дуудлага байсан бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ахмад настны эрхийн тухай конвенцыг гишүүн улс орнууд болон, улс орнуудын удирдагчдад бүс нутгийн улс орнуудын төлөөлөгчид дуу хоолойгоороо нэгдэн уриалсан юм.

Энэхүү хэлэлцүүлэг нь насжилтын асуудлууд, насаар ялгаварлан гадуурхах болон ахмад настнуудад түгээмэл тохиолддог бусад хүний эрхийн зөрчил зэрэг бүс нутгийн хүрээнд ахмад настнуудад тулгарч байгаа асуудлуудын талаарх мэдээлэл дээр тулгуурласан.

Семинарын үеэр бид хүний эрхийн хэм хэмжээ тогтоох чиглэлээрх олон улсын механизмууд, тэдгээрийн хүчин чармайлтуудын талаар олон мэдээллүүдтэй танилцаж, Нью-Йорк дахь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Насжилттай холбоотой Нээлттэй ажлын хэсэг, Женев дэх Хүний эрхийн зөвлөл, Мадридын Насжилтын асуудлаарх олон улсын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дэх үнэлгээний зөвлөмжүүдийн Ази, Номхон далайн бүс нутаг дахь хэрэгжилт, мөн НҮБ-ын Тусгай Журмын механизмын Бие даасан шинжээчийн ажлын талаар хэлэлцсэн.

Түүнчлэн ахмад настны хүний эрхийг хангах, хамгаалахтай холбоотой олон улсын эрх зүйн хэм хэмжээ, үүрэг хариуцлагын талаар, одоогийн тогтолцоонд оршиж байгаа дутагдалтай асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэхийн тулд НҮБ-ын хүний эрхийн шинэ конвенц боловсруулах шаардлагатай болох талаар шинжээчдийн хэлэлцүүлэг болсон. Энэхүү хэлэлцүүлэг нь насжилтын асуудлууд, насаар ялгаварлан гадуурхах болон ахмад настнуудад түгээмэл тохиолддог бусад хүний эрхийн зөрчил зэрэг бүс хүрээнд нутгийн ахмад настнуудад тулгарч байгаа асуудлуудын талаарх мэдээлэл дээр тулгуурласан. Хүний эрхийн үндэсний байгууллагууд (ХЭҮБ) болон шинжээчид хэрхэн өөрийн орны засгийн газрууд болон бүсийн хэмжээний болон олон улсын байгууллагуудад НҮБ-ын шинэ конвенцыг дэмжих ухуулга нөлөөллийн ажлыг хийх талаар зөвлөлдсөн.

Түүнчлэн, семинарын хүрээнд ахмад настны хүний эрхийн тухай НҮБ-ын шинэ конвенцод ямар асуудлуудыг тусгах талаар өргөн хүрээнд хэлэлцсэн. Оролцогчид ахмад настныг хүчирхийлэл, дарангуйлал, үл тоомсорлох хүчирхийллээс хамгаалах хуулийн өмнө тэгш эрхтэй байх, урт хугацааны болон хөнгөвчлөх эмчилгээ, үйлчилгээ авах эрх, нийгмийн болон хувийн амьдралд үр дүнтэй оролцох эрх, ахмад насандаа бие даасан байдал, хараат бус байдлаа хадгалах эрх, насаар ялгаварлан гадуурхалтаас хамгаалуулах эрх зэрэг хэм хэмжээний стандартыг бий болгох шаардлагатай гэж үзсэн. Солонгосын Хүний эрхийн үндэсний комисс нь өнгөрсөн жил боловсруулсан конвенцын анхны төслийн

хувилбарыг хэлэлцэх хэлэлцүүлгүүдийг удирдан явуулсан.

Бага хурлын төгсгөлд бид ахмад настны бүх эрхийг хүлээн зөвшөөрч, хамгаалах, ахмад настны асуудлыг хүний эрхийн асуудал болгон өргөн хүрээнд авч үзэх хууль эрх зүйн хүчин төгөлдөр олон улсын баримт зайлшгүй шаардлагатайг онцолсон баримт бичгийг баталсан.

2024 он хүртэл олон жилийн турш хүний эрхийн өмгөөлөгчид Насжилтын асуудлаарх Нээлттэй ажлын хэсгээр дамжуулан энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэхийн төлөө ажилласан. Үүний үр дүнд 2025 оны 4 дүгээр сард болсон НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 58 дахь чуулганаар ахмад настны эрхийн тухай A/HRC/RES/58/13 тогтоолыг санал нэгтгэйгээр баталсан. Энэхүү тогтоол нь ахмад настны хүний эрхийг дэмжих, хамгаалах, бүрэн хангах зорилготой, ахмад настны хүний эрхийн тухай олон улсын хууль эрх зүйн хүчин төгөлдөр баримт бичгийн төслийг боловсруулж, Хүний эрхийн зөвлөлд танилцуулах бүрэн эрхтэй, нээлттэй Засгийн газар хоорондын ажлын хэсгийг байгуулсан.

Энэхүү тогтоол нь эдгээр хүчин чармайлтад хувь нэмэр оруулсан төдийгүй Хүний эрхийн зөвлөл, Хүний эрхийн үндэсний байгууллагууд энэ саналыг хүргэхийг зорьсон бүх хүмүүсийн хувьд чухал ахиц дэвшил, амжилт байлаа. Хэдийгээр тодорхой ахиц дэвшил гарсан ч хийх шаардлагатай ажил их байна. Хүний эрхийн үндэсний байгууллагын хувьд бид ахмад настны эрхийг хангах шинэ конвенцыг дэмжих хэлэлцүүлгийг манлайлан, түүнийг дэмжихийг өөрийн улс орны засгийн газруудад нөлөөлж чадна.

Энэ бол Хүний эрхийн үндэсний байгууллагуудын хувьд чухал, гүйцэтгэх ёстой стратегийн үүрэг юм. Уулзалтууд ихэвчлэн онлайнээр хийгдэх боломжтой дижитал эриний үед бидний оролцоо, нөлөөлөл, хамтын ажиллагаа хүчирхэг байх болно. Хүний эрхийн үндэсний байгууллагууд бид өөрийн улс орны засгийн газруудынхаа ухамсар, мэдлэгийн түүчээ болдгийнхоо хувьд бидний байр суурь онцгой байдаг. Бид төрийн хариуцлагатай байдал, ард түмний хүсэл тэмүүллийн уулзвар дээр зогсдог. Бүс нутгийн болон олон улсын форумуудад оролцооноор бид арвин баялаг туршлага, хөтөлбөр, шилдэг санаачилгуудаас суралцдаг.

Бид улс орнуудад насжилт нь зөвхөн нийгмийн асуудал биш, харин хүний эрхийн асуудал гэдгийг байнга сануулж байх ёстой.

Анхаарал тавьсанд баярлалаа.



Ц.БАТЦЭРЭН

ШУТИС, Нийгэм Хүмүүнлэгийн
Сургуулийн багш (Ph.D, дэд профессор)



Э.ЭНХЦОЛМОН

ШУТИС, Нийгэм Хүмүүнлэгийн
Сургуулийн багш (Магистр)

ХҮНИЙ ЭРХИЙН МЭДРЭМЖТЭЙ ИНЖЕНЕР МЭРГЭЖИЛТЭНГ БЭЛТГЭХЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА¹

Хураангуй: Монгол Улсад иргэдийн үндсэн эрх болох эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдсөөр байгаа нь инженерийн боловсролд ёс зүй, хүний эрхийн талаар мэдлэг, хяналт дутмаг байдлаас үүдэлтэй. Инженер мэргэжилтэнг бэлтгэж ирсэн ШУТИС нь 2016 оны хөтөлбөрийн шинэчлэлтээр “Инженерийн ёс зүй” хичээлийг 3 кредиттэй сонгоноор төлөвлөгөөнд тусгасан байдаг. Үүнээс хойш уг хичээлийн төгсгөлд, хувь хүнд гарсан мэдлэг чадварын ахиц, дэвшлийн талаар хэлэлцүүлгийн өрнүүлж, хөтөлбөрийн агуулгад шинэчлэлтийг хийж ирсэн.

Энэ удаад “Инженерийн ёс зүй” хичээлийн агуулга, хөтөлбөрт хүний эрхийн агуулгыг хэрхэн тусгасан, мөн ач холбогдлын талаар хүргэж байна. Сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа үр дүнд суурилсан боловсрол (CDIO)-ын чиг хандлагын дагуу арга зүй, суралцахуйн үр дүн, сургалтын үнэлгээний аргуудыг ашигласан. Оюутан онолоор олж авсан мэдлэгээ практикт хэрэглэх, асуудлыг олон талаас шүүн тунгаааж, шийдвэр гаргахдаа мэргэжлийн ёс зүй хүний эрхийн мэдрэмжтэй мэргэжилтэн болгоход анхаарч хөтөлбөрийг боловсруулж, бие даалтын ажлыг уялдуулан хийсэн туршлагаас хүргэж байна.

¹ ХЭҮК, Монголын Эмнести Интернэшнлтэй хамтран зохион байгуулсан “Хүний эрхийн боловсролын симпозиум-2025” арга хэмжээнд тавигдсан илтгэл

Түлхүүр үг: боловсрол, хөтөлбөр, хүний эрх, агуулга, бие даалт, үр дүн

2024-2025 оны хичээлийн жилд “Инженерийн ёс зүй” хичээлийг судалсан оюутнуудад Монголын Эмнести интернэйшлэтэй хамтран Монгол инженерийн бүтээсэн аппликейшнүүд нь хүний эрх, хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж буйг судлах судалгааны ажлыг хийлгэсэн. Уг судалгааг хийсэн оюутнууд олон улсын стандарт, холбогдох хууль эрх зүйн мэдлэгтэй болж, судалгаа хийх арга зүйд суралцаж, технологи хэрхэн хүний эрхийн асуудалтай холбогдох, хувь хүн эрхээ хэрхэн хамгаалах, цаашид бүтээгдэхүүн хөгжүүлэхдээ бусдын эрхийг дээдэлсэн инженер байх ёстой гэдгийг ухамсарласан бодит ажил болсон. Дээрхтэй адил практик даалгавар нь оюутны өөрийгөө болон бусдын эрхийг хамгаалах чадварт дорвитой хувь нэмэр болж байдаг.

Инженерийн үйл ажиллагааны гол зарчим нь олон нийтийн сайн сайхан байдал, амьдралын чанарыг сайжруулахад оршино. Мэргэжилтний алдаатай тооцоо тооцоолол, буруу дизайн үйлдвэрлэл, хяналтгүй байдал нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль экологи, хүний аюулгүй амьдрах эрхийг зөрчих үндэс болно.

Инженер нь мэргэжлийн мэдлэгтэй байхаас гадна, хамт олонтойгоо нийцтэй байж хамтран ажиллах, өөрийнхөө үзэл бодлыг илэрхийлэх, мэргэжлийн итгэл үнэмшилтэй байхаас гадна хүний эрхэд нийцтэй шийдвэр гаргагч байх шаардлагатай юм. Өнөө үед бидний амьдрал бүхэлдээ инженерийн технологийн үйлтэй холбоотой болсоор байна. Иймд техник, технологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж буй сургуулиуд хөтөлбөртөө шинэчлэл хийн, байгальд ээлтэй, хүний эрхэд нийцэхүйц технологийн сонголтыг хийх мэдлэг чадвар, итгэл үнэмшилтэй мэргэжилтнийг бэлтгэхэд анхаарах цаг иржээ.

2004 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей бүх салбарт хүний эрхийн боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилго бүхий “Хүний эрхийн боловсролын Дэлхийн Хөтөлбөр”-ийг баталсан. Уг баримт бичиг нь хүний эрхийн зарчмуудад суурилсан хамтын үйл ажиллагааны цогц хүрээг тунхагласан бөгөөд урьд өмнөх ололт амжилтыг баталгаажуулах, бүх түвшний хамтын ажиллагааг өргөтгөх, чанаржуулах зорилготойгоор хэд хэдэн үе шаттай арга хэмжээг явуулсан. Үүнд:

Нэгдүгээр үе 2005-2009: Бага болон дунд боловсролын тогтолцоо руу чиглэсэн “боловсролоор хүний эрхийг”, “боловсрол дахь хүний эрх” гэсэн хоёр хандлагыг нэгтгэсэн.

Хоёрдугаар үе 2010-2014: Дээд боловсрол дахь хүний эрхийн боловсрол болон бүх шатны төрийн албан хаагчид, хууль сахиулагчид болон

цэргийн албан хаагчдад хүний эрхийн сургалтыг түгээхэд голлон чиглэж үйл ажиллагаагаа явуулсан байдаг.

Гуравдугаар үе 2015-2019: Энэ үед өмнөх хоёр үе шатны хэрэгжилтийг батжуулах, хэвлэл мэдээллийнхэнд хүний эрхийн сургалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн.

Дөрөвдүгээр үе 2020-2024: Хүний эрхийн боловсролыг Тогтвортой хөгжил 2030-тай уялдуулан боловсруулсан ба залуучуудыг чадавхжуулахад голлон анхаарч ажилласан.

Тавдугаар үе 2025-2029: Хүний эрх болон цахим технологи, байгаль орчин болон уур амьсгалын өөрчлөлт, жендэрийн тэгш байдлыг хангахад анхаарч үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөсөн. (НҮБ-ын Боловсрол, 2025)

НҮБ-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга: “Нээлттэй, аюулгүй, найдвартай цахим ирээдүйн гол үндэс суурь нь хүний эрх болохын чухал”-ыг онцлон тэмдэглэсэн байдаг. Хүний эрхийн боловсрол дэлхийн хөтөлбөрөөр дамжуулж Хүний эрхийн боловсролыг олгохдоо мэдлэг чадвар, үнэт зүйл болон хандлага, оролцоо үйл ажиллагаа гэсэн цогц байдлаар олгох хэрэгтэй гэж тунхагласан бол олон улсад хүний эрхийн боловсролыг их сургуульд олгохдоо “Мэргэжлийн ёс зүй”-н хичээлээр дамжуулан олгож байна. Тухайлбал: Харвардын их сургууль (Harvard, 2025), Стэнфордын их сургууль (Stanford, 2025), Оксфордын их сургуулиудад (Oxford, 2021) мэргэжлийн ёс зүйн хичээлээрээ хүний эрхийн боловсролыг олгохдоо дараах 3 хэсэгтэйгээр хүний эрхийн зарчмуудыг мэргэжлийн үүрэгтэй уялдуулан хөтөлбөртөө тусгасан байдаг. Үүнд:

- Ёс зүй ба хүний эрх (мэргэжлийн ёс зүй, ёс зүйн суурь ойлголтууд)
- Хүний эрх ба тусгайлсан мэргэжлийн эрх (анагаахын ёс зүй, хуульчийн ёс зүй, байгууллагын нийгмийн хариуцлага, хүмүүнлэгийн салбар дахь ёс зүйн дилемма болсон асуудлуудыг кейс хэлбэрээр)
- Ёс зүйн шийдвэр гаргалт (мэргэжлийн хүрээн дэх шийдвэр гаргалт нь хүний эрхийн ямар зөрчилтэй холбогдох, тэгш эрх, ялгаварлан гадуурхалт, хувийн нууцын хамгаалалт) гэсэн хэсгүүдээс бүрдэж байна.

Монгол улс ардчилсан тогтолцоонд шилжсэнээр ШУТИС нь философи, ёс зүйн хичээлийг хүний эрх, ардчилал, олон ургалч үзэл санаа бүхий агуулгаар шинэчлэн орох болсон. 2014 оны хөтөлбөрийн шинэчлэлтээр

инженер суурьтай мэргэжлийн оюутнуудад “Инженерийн ёс зүй” хичээлийг 3 кредиттэй сонгон хэлбэрээр мэргэжлийн ёс зүйн хичээлийг баяжуулсаар ирсэн.

“ИНЖЕНЕРИЙН ЁС ЗҮЙ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

1. Хөтөлбөрийн ерөнхий мэдээлэл (ШУТИС, 2025)

Хичээлийн нэр: <i>Инженерийн ёс зүй</i>		Хичээлийн код: <i>S.EEM102</i>
Хичээл орох улирал: <i>Дурын</i>	Хичээл орох хугацаа: <i>IA IB улирал</i>	Хичээлийн кредит: 3 <i>Хичээлийн задаргаа: 2:2:0:5</i>
<p>Хичээлийн товч тодорхойлолт: <i>Инженерийн ёс зүй хичээлээр ёс зүйн онол, үзэл баримтлалууд, мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм, шинжлэх ухаан технологийн салбарт хүний эрхийн асуудал хэрхэн хөндөгдөж байгаад дүн шинжилгээ хийн, нийгэм-экологи-техникийн харилцаанд инженерийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагын талаар мэдлэг олгоно.</i></p>		
<p>Хичээлийн зорилго:</p> <ol style="list-style-type: none"> <i>Ёс зүйн үндсэн ойлголт, агуулгатай танилцан, нийгмийн харилцаанд орохдоо баримтлах зарчмуудтай танилцах</i> <i>Инженерийн үйл ажиллагаа дахь хүний эрхийн зөрчилтэй кейсүүд дээр анализ хийх</i> <i>Инженерийн ёс зүйн хэм хэмжээ, хариуцлагын талаарх ойлголтыг тайлбарлах</i> <i>Багаар хамтран ажиллах – бусдаас суралцах, хамтран ажиллах, хуваалцах</i> <i>Ирээдүйд хүний эрхийн мэдрэмжтэй бүтээгч, хөгжүүлэгч, үйлдвэрлэгч инженерийг төлөвшүүлэх</i> 		

2. Хичээлийн суралцахуйн үр дүн (CLO). Энэ хичээлийг амжилттай судалсан оюутан:

- Харилцааны ур чадвар: Даалгаварт ажлуудыг багаар цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх, ажлыг зохистой хуваарилан үнэлэлт дүгнэлт өгөх, бусадтай хамтран ажиллахад суралцана.
- Асуудал шийдвэрлэх чадвар: Нийгмийн амьдралд гарч буй бодит ёс зүйн дилемма асуудлыг эерэг болон сөрөг байр сууринаас тунгаан, логик дараалалтай үндэслэгээ дэвшүүлж сурна.
- Тунгаан цэгнэх чадвар: Шинжлэх ухаан, техник технологи, нийгэм эдийн засгийн үйл явцыг дүгнэхдээ мэдээллийн эх сурвалжид анхаарч системээр дүгнэлт хийнэ.
- Мэргэжлийн ур чадвар: Инженерийн ёс зүйн үйл ажиллагаа хүний эрхтэй хэрхэн холбогдож буйд анхаарч хүний эрхийн мэдрэмжтэй мэргэжилтэн гарна.

3. Сургалт явуулах хэлбэр: Лекц, семинар, бие даалтаас бүрдэнэ.

- Лекц: Оюутны оролцоо бүхий интерактив лекцийн хэлбэрээр явагдана.
- Семинар: Лекцийн хичээлээр олж авсан онолын мэдлэгээ баталгаажуулах, харилцан ярих, багаар ажиллах, кейс жишээн дээр ажиллаж, хэлэлцүүлэх хэлбэрээр явагдана.
- Бие даалт: 2 даалгавартай багаар хийж гүйцэтгэнэ.

Хүний эрхийн боловсролыг “Инженерийн ёс зүй” хичээлээр олгохдоо:

- онол мэдлэгийг лекцийн хичээлээр,
- хандлага үнэт зүйлийг семинар,
- оролцоо үйл ажиллагааг бие даалтын хичээлээр олгохоор сургалтын хөтөлбөрийг боловсруулж оролцоог дэмжих зорилгоор хичээлийн бие даалтын ажлыг шинэчилж байна.

4. “Инженерийн ёс зүй” Хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө (сэдэв өөрчлөгдөж болно)

Долоо хоног	Хичээлийн сэдвийн агуулга
1	Ёс зүйн шинжлэх ухааны судлах зүйл, ач холбогдол
2	Ёс зүйн үндсэн зарчим, хэм хэмжээ, шалтгаан үр дагаврын хамаарал
3	Ухамсрын хөгжил, төлөвшил, шийдвэр гаргах үйл явц
4	Ёс суртахууны үнэлэмж, үнэт зүйл ба эрхэмлэх зүйлс
5	Хувь хүний эрх ба нийтийн эрх ашгийн зөрчил
6	Нийтийн эрх ашиг, утилитаризмын хэлбэрүүд
7	Шударга ёсны ойлголт, тэгш эрх
8	Мэргэжлүүдийн ёс зүйн хүрээ, онцлог
9	Инженерийн ёс зүйн дүрэм, мэргэжлийн холбооны нийгэм дэх үүрэг
10	Инженерийн мэргэжлийн үүрэг хариуцлага, бие даасан байдал
11	Нийгмийн хариуцлага, “Тогтвортой хөгжил-2030”
12	Инженерийн хариуцлага ба хүний эрхийн асуудал
13	Авлига, хүний эрхтэй холбогдох нь
14	Эрсдэл, түүний төрлүүд, эрсдэлийг тооцох
15	ХАБЭА-Хөдөлмөрийн орчин дох хүний эрхийн асуудал
16	Шинжлэх ухаанд тулгарч буй инженерийн ёс зүйн дилемма

5. Бие даалтын удирдамж /2024-2025 оны хичээлийн жилийн хаврын улирал/

Оюутанд дээрх мэдлэг, чадваруудыг олгох үүднээс гурван бие даалтын ажлыг хийлгэнэ. Үүнд:

- Бие даалт 1: Шинжлэх ухаан, нийгэм эдийн засгийн сэдэв бүхий эх зохиолыг уншиж, семинарын хичээл дээр хэлэлцүүлэг хийн, асуудлуудыг ёс зүйн онол, хүний эрхтэй холбон тайлбарлаж, багуудаар даалгаварт ажил хийлгэж, дүгнэсэн. (унших номын жагсаалт дундаас сонгон багаар ажилласан)
- Бие даалт 2: Монгол инженерийн бүтээсэн цахим орчин дахь гар утасны аппликейшнуудыг шүүж, олон улсын стандарт, хууль эрх зүйн орчны нийцлийг гарган хүний эрхийн зөрчил байгааг эсэхэд дүн шинжилгээ хийсэн болно. (багаар ажилласан)

Уг бие даалтуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн оюутан:

Бие даалт 1: Эх зохиол уншиж, хэлэлцүүлэх

1. Ёс зүйн дилемма асуудлыг илрүүлэн, эерэг болон сөрөг байр сууринаас тунгаан, онолын үүднээс дүгнэлт хийсэн.
2. Хүний эрх, мэргэжлийн үүрэг, хариуцлагын талаар мэдлэг авч, багаар ажиллаж, өөрийнхөө үзэл санааг чөлөөтэй илэрхийлдэг болсон.

Бие даалт 2: Аппликейшн (цаашид АПП гэх) ба хувийн мэдээллийн аюулгүй байдалд анализ хийх Монгол инженерүүд бүтээж, иргэдийн нийтлэг ашиглаж буй гар утасны АПП-ууд дээр оюутнуудын тандалт судалгааг хийж гүйцэтгэсэн. Уг судалгааны хүрээнд нийт 79 АПП-ыг илрүүлж нэгтгэн, үүнээс иргэдийн дунд өргөн ашиглагддаг 15 төрлийн 44 АПП-ыг сонгон авч Олон Улсын стандартууд болон Монгол Улсын хууль эрх зүйн шаардлага бүхий 9 үзүүлэлтийг үнэлсэн. Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд ашиглахад зориулсан вэб контентийн хүртээмжийн удирдамж (WCAG) стандартыг судлан, АПП-ны нийцлийг гаргасан. Оюутнууд нь:

1. Судалгааны ажил хийх арга, аргачлал, чанарын судалгааны талаарх ойлголт, мэдлэгтэй болсон.
2. АПП-хүний эрхтэй хэрхэн уялдаж буй, цаашид технологийн шийдлийг хүнд ээлтэй байдлаар бүтээх, хянах, ашиглах шаардлагатайг мэдсэн.
3. Олон Улсын стандарт, Монгол Улсын хууль эрх зүйн боловсролтой болж, мэргэжлийн түвшинд шийдвэр гаргахдаа хүний эрхийг хүндэтгэх чадвар дадлыг эзэмшсэн болно.

ДУГНЭЛТ

Инженер нь бусад мэргэжилтэй харьцуулахад нэг хүн, нэг гэр бүл бус магадгүй улс үндэстэн, энэ дэлхийн хувь тавиланг шийдэх чадвартай байдгаараа бусад мэргэжлээс илүү үүрэг, хариуцлага, хяналтыг шаарддаг.

ШУТИС-ийн “Инженерийн ёс зүй” хичээлийн хөтөлбөр нь хүнд ээлтэй, хүний эрхийн мэдрэмжтэй, хариуцлагатай боловсон хүчнийг бэлтгэх үүднээс хичээлийн хөтөлбөрийг онол, практик хосолмол хэлбэрээр боловсруулахад илүүтэй анхаарч байна.

- Ёс зүйн онол болон холбогдох хууль, стандарт, Хүний эрхийн бодлогын баримт бичгүүдийн агуулгын талаар мэдлэг олгох,
- Технологийн хөгжил ба хүний эрхтэй холбоотой эх зохиолтой танилцах,
- Мэргэжлийн шийдвэр гаргалт нь хүний эрхтэй холбоотой кейс ажилбар, хэлэлцүүлэг хийх
- Бие даалтын ажлаар бодитой практик даалгаврыг хийлгэхийг зорин ажиллаж байна.

Санал: Ирээдүйн инженерийг бэлтгэгч боловсролын байгууллагууд нь хүнд ээлтэй, хүний эрхийн мэдрэмжтэй боловсон хүчнийг бэлтгэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна. Иймээс:

1. Хичээлийн хөтөлбөрийг онол, практик хосолмол хэлбэрээр боловсруулах
2. Их сургуулийн хөтөлбөрт “Мэргэжлийн ёс зүй” хичээлийг заавал суралцах хичээлээр оруулах,
3. Мэргэжлийн ёс зүйн хичээлийн хөтөлбөрийг хүний эрхийн асуудалтай уялдуулах
4. Мэргэжлийн холбоо нийгэмлэгүүд, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж хэлэлцүүлгийг тогтмол хийж байхыг санал болгож байна.

УИИ.МН
СУДАЛГААНЫ САН

НОМ ЗҮЙ

1. Бидний хамтын ирээдүй бодлогын товхимол №5: “Дэлхийн дижитал гэрээ – бүхний төлөө нээлттэй, чөлөөтэй, аюулгүй дижитал ирээдүй”. УБ. 2023.05
2. Дэлхийн иргэний боловсрол. Бодлогын нөлөөллийн баримт бичиг. УБ.,2025
3. Монгол дахь ёс зүйн сургалт, судалгааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал. УБ.,2012
4. НҮБ-ийн Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага. ЮНЕСКО. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр. Дөрөв, тав дахь үе шатны төлөвлөгөө. eISBN:978-92-1-005708-0
5. НҮБ-ын Боловсрол, ш. у. (2025). Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр, 51-55.
6. Н.Эрдэнэхүү, П.Нямсүрэн. ҮДСБ-ын CDIO загварын дагуу хичээлийн хөтөлбөр боловсруулах асуудалд. Мэдээлэл, холбооны технологи боловсролд. ММТ 2017. 21х. <http://mmt.edu.mn/static/upload/template/template2.pdf>
7. Ц.Батцэрэн, Б.Наранбаатар. Инженерийн ёс зүй. УБ.,2019.
8. Ёс зүй: цар тахлаас үүдэх сургамж ба алсын хараа. УБ.,2021.
9. Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр. <https://www.meds.gov.mn/post/65854> 2018.07.04
10. ШУТИС. Явцын болон улирлын шалгалтын материал боловсруулах удирдамж. УБ.2024
11. ШУТИС. БАС. Сургалтын хөтөлбөрийг дотоодын болон гадаадын магадлан итгэмжлэлд бэлтгэх арга зүйн зөвлөмж. УБ.2022
12. Proceedings of the International Joint Conference on Science and Engineering 2022 (IJCSE 2022) 2023, ISBN:9789464631005, 9464631007
13. Connexity and Coherence Analysis of Text and Discourse. 2012 ISBN:9783110854831, 311085483XBibliography
14. Harvard. (2025). Harvard Law School. Retrieved from 2025-2026 Legal Profession Courses: <https://hls.harvard.edu/academics/curriculum/registration-information/professional-responsibility-courses/>
15. Oxford. (2021). Faculty of Philosophy. Retrieved from Ethics in AI Seminar: AI, Ethics, and War: <https://www.philosophy.ox.ac.uk/>
16. Stanford. (2025). Academic calendar, 2025. Retrieved from Ethical Issues in Engineering: <https://bulletin.stanford.edu/courses/1055511>
17. ШУТИС. (2025). ШУТИС. Retrieved from Хичээлийн хөтөлбөр: <http://www.must.edu.mn>



Д.МӨНХЦЭЦЭГ

Түүх, нийгэм судлалын багш, боловсролын удирдлагын магистр

АХЛАХ АНГИЙН СУРАХ БИЧИГТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ОЛГОЖ БУЙ ТУРШЛАГА¹

A QUICK ANALYSIS OF THE CONTENT OF THE LAW SUBJECT IN THE HIGH SCHOOL TEXTBOOK AND SELF-EXPERIENCE IN PROVIDING HUMAN RIGHTS EDUCATION

Abstract

Nowadays, we are required to apply our knowledge effectively. We are exploring various ways to access legal education beyond the traditional classroom setting. We are presenting the idea that there are numerous opportunities to provide human rights education through extracurricular activities. If students can be provided with sound legal knowledge, they can become citizens who respect human rights. Students actively participate in extracurricular activities to have a positive impact on their peers.

Үндэслэл

Орчин үеийн боловсролын чиг хандлага бүтээлч байдал руу тэмүүлж буй энэ үед уламжлалт аргаар орчин үеийн суралцагчдад, сурах бичгийн агуулгыг эзэмшүүлэх хандлагыг алхам алхмаар өөрчлөх хэрэгцээ бидэнд тулгарч байна. Боловсрол гэдэг зүйл хүнд мэдлэг олгохын зэрэгцээ мэдлэгээ хэрэглээ болгож сургахыг шаардаж буй нь үнэн. Бид онолын

¹ ХЭҮК, Монголын Эмнести Интернэшнлтэй хамтран зохион байгуулсан “Хүний эрхийн боловсролын симпозиум-2025” арга хэмжээнд тавигдсан илтгэл

ойлголтыг эзэмшсэн бол танхимын бус аргаар эрх зүйн боловсролыг олж авах олон арга замыг туршиж, хэрэглээ, дадал болгохоор ажиллаж байна. Сурах бичгийн эрх зүйн ойлголтыг тохиолдол шинжлэх аргаар тайлбарладаг хэдий ч энэ нь төдийлөн үр дүнтэй байдаггүй. Тохиолдол шинжлэх аргаас гадна танхимын бус аргуудаар эрх зүйн мэдлэг, мэдээллээ өөрсдийн амьдралд хэрэглээ болгох шаардлага байна.

Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хүний эрхийн боловсрол олгох хэрэгцээг жагсаавал:

- Өөрт тулгамдсан асуудлаа эрх зүйн үүднээс шийдвэрлэх гарц, гаргалгаанд суралцах
- Хүүхдийн эрх, үүрэгтэй холбоотой одоо мөрдөгдөж буй хуулийн зүйл, заалтуудыг мэдэх
- Ялгаварлан гадуурхах хандлага зөвхөн бие физиологид бус бусад хэлбэрээр илрэх тохиолдолд ямар арга хэмжээ авч болох тухай мэдэх.

ЕБС-ийн ахлах ангийн “Нийгэм судлал” сурах бичгийн агуулгад тусгагдсан хүний эрхийн боловсролын мэдлэг, ойлголтын байдал

Сурах бичиг, түүний үүрэг. Орчин үеийн соёл, шинжлэх ухааны тодорхой салбарын мэдлэгийг сурагчдад зориулж оновчтой тогтолцоогоор илтгэн бичсэн боловсролын хэвлэлийн үндсэн гол төрөл болох номыг сурах бичиг гэнэ.²

Сурах бичиг нь товч, тодорхой илүү нуршсан зүйлгүй, материалын гол санааг илэрхийлсэн байх ёстой байдаг. Сурах бичгийн үүрэг нь:

- Сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон байх
- Мэдлэг олгох гол тулгуур нь байх
- Сурах бичгийн онол нь цаг үеэ даган мэдээлэл нь өөрчлөгдөж шинэчлэгдэж байх
- Сурах бичгийн онол, мэдээлэл нь үнэн зөв байх гэсэн үүрэгтэй байна.

Хүснэгт 1. Ахлах ангийн нийгэм судлал хичээлийн эрх зүй бүлгийн агуулга


10 дугаар ангийн сурах бичгийн “Эрх зүй” бүлэг сэдвийн агуулга	11 дүгээр ангийн сурах бичгийн “Эрх зүй” бүлэг сэдвийн агуулга
Хүний эрхэм чанар ба Хүний эрх	Хүний эрх ба Үндсэн хууль
Үндсэн хуулийн суурь зарчим ба эрх зүй захирагдах ёс	Өмчлөх эрхийг хуулиар хамгаалах нь
Иргэний эрх зүйн харилцаа	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь

² Н.Цэдэвсүрэн. Сурах бичгийн тухай. УБ., 2003

Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа	Захиргаа, иргэдийн хоорондын маргааныг хянан шийдвэрлэх нь
Иргэн ба захиргаа хоорондын харилцаа	Хүний эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын механизм
Нийгмийн хамгааллын эрх зүйн харилцаа	Бүлгийн дүгнэлт
Бүлгийн дүгнэлт	


Нэг. Сурагчдын эрх зүйн мэдлэг ойлголтын судалгаа. Судалгаанд 69-р сургуулийн ахлах ангийн сурагчид болох 10-12 ангийн нийт 200 гаруй сурагчид оролцсон. Энэхүү судалгааны эхний 5 асуулт нь өсвөр насны сурагчдад тохиолддог сурах бичгийн агуулгад багтаагүй эрх зүйн харилцааны тухай асуулт. Харин сүүлийн 3 асуулт нь ахлах ангийн сурагчдын “Эрх зүй” бүлэг сэдвийн хүрээнд дэх асуулт юм.

Бүдүүвч 1. Сурагчдын эрх зүйн тухай ойлголт




Эрх зүй гэж юу вэ? гэсэн асуултад нийт 200 сурагчаас 110 буюу 55 хувь нь хууль дүрэм гэж хариулсан байна.

Бүдүүвч 2. Сурагчдын эрх зүйн мэдлэгийг олж авч буй мэдээллийн эх сурвалж



10 сурагч тутмын 4 нь эрх зүйн мэдлэгийг хичээлээс авч байна. Үлдсэн сурагчид нь эцэг эх, цахим орчноос мэдээлэл авдаг гэжээ.

Бүдүүвч 3. Маргаан гарахад оролцох ёстой тал болон хэнд хандах талаарх сурагчдын байр суурь.




Ямар нэгэн маргаан гарвал хамгийн түрүүнд хэнд хандах вэ? Маргааныг шийдвэрлэхэд хэн оролцох ёстой вэ? гэсэн асуултад 10 хүүхдийн 8 нь найз нөхөд хэмээн хариулжээ.

Бүдүүвч 4. Аливаа маргаан гарахад мэргэжлийн хүнд хандах хэрэгтэй тухай сурагчдын байр суурь.




Нийт сурагчдын 79 хувь нь ямар нэгэн маргаан гарахад мэргэжлийн хүн дуудах шаардлагагүй гэж үзэж байна.

Бүдүүвч 5. Хөрш гэмт хэрэг гарсныг мэдсэн даруйд хаана, хэнд хандах тухай сурагчдын мэдлэг




Нийт сурагчдын 78 хувь нь хөрш айлд гэмт хэрэг зөрчил гарвал цагдаа дуудахыг мэдэж байна.

Бүдүүвч 6. Сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн тухай сурагчдын мэдлэг



Нийт сурагчдын 86 буюу 10 сурагч тутмын 9 нь сэтгэл санааны хохирлыг мөнгөөр үнэлж хохироогч этгээдээс гаргуулан авч болно хэмээн үзэж байна.

Бүдүүвч 7. Иргэдийн эрх зүйн бүрэн чадамжтай болох насны талаарх сурагчдын мэдлэг



Нийт сурагчдын 66 хувь нь 18 хүрээд эрх зүйн бүрэн чадамжтай болно гэж үзсэн бол 17 хувь нь 17 нас, 17 хувь нь 21 наснаас эрх зүйн бүрэн чадамжтай болно гэж үзжээ.

Дүгнэлт:

Судалгаанд оролцсон нийт хүүхдүүд Эрх зүй гэж юу вэ? гэх асуултад 55 хувь нь хууль дүрэм, та эрх зүйн мэдлэгийг хаанаас олж авдаг вэ? асуултад 40 хувь нь хичээлээс, үе тэнгийн сурагчдын дунд маргаан үүсэхэд хамгийн эхэд хэнд хандах вэ? гэсэн асуултад 64% нь найз нөхдөдөө хандаж зөвлөгөө авна гэсэн байгааг харахад маргааныг хэрхэн зөв шийдвэрлэх арга замаа мэдэхгүй байгаа харагдаж байна. Аливаа маргааныг шийдвэрлэхэд хэн хэн оролцох ёстой вэ? гэсэн асуултад сургууль, хамт олон оролцоно гэж 73% нь хариулсан байгааг харахад

сурагчдад зөрчилдөгч талууд болон, гэрчийн тухай ойлголт бага байгааг харуулж байна. Сурагчдын дунд үүссэн зөрчил маргааныг шийдвэрлэхэд мэргэжлийн хүний зөвлөгөө хэрэгтэй юу гэсэн асуултад нийт сурагчдын 79% хэрэггүй гэж хариулсныг харахад хуульч, болон хуулийн зөвлөгөө авах ойлголт байхгүй байгаа нь харагдаж байна. Ингээд сурагчдын дунд тэр дундаа сургуулийн орчинд тохиолддог үе тэнгийн дээрлэхэлт ба зөрчил маргааныг шийдвэрлэх тухай болон тэдний нас сэтгэхүйн онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн эрх зүйн онол болон агуулгыг оруулж өгөх нь чухал байна.

Харин сурах бичгийн агуулгын хүрээнд авсан судалгааг харахад Хөрш айлд хулгай орсныг мэдсэн даруйдаа хэнд, хаана хандах вэ? гэдэг асуултад нийт сурагчдын 78% цагдаагийн байгууллагад хандана гэж хариулсан байна. Сурагчид дээрх асуултын хүрээнд 11-р ангийн “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдвээр дамжуулан гэмт хэргийг харсан болон мэдсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандах ёстой ба мэдэгдээгүй тохиолдолд “Эс үйлдэл” болно гэсэн эрх зүйн ойлголтыг авч чадсан байна. Сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөөр үнэлж болох уу? гэсэн асуултад нийт сурагчдын 86% болно гэж хариулсан байна. Дээрх асуултын хүрээнд 11-р ангийн “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх” гэсэн сэдвийн агуулгын хүрээнд Эд хөрөнгө болон, Сэтгэл санаа, Эрүүл мэндэд учруулсан хохирлоо мөнгөөр үнэлүүлж хохирлоо барагдуулж болно гэсэн ойлголтын авсан байна. Мөн иргэн хэдэн наснаас эхлэн эрх зүйн бүрэн чадамжтай гэж үздэг вэ? асуултад нийт сурагчдын 66% нь 18 наснаас эхлэн гэж хариулсан байна. Энэхүү асуултын дагуу 10-р ангийн “Иргэний эрх зүй” сэдэвт багтсан иргэний эрх зүйн бүрэн болон бүрэн бус заримдаг чадамжийн тухай ойлголт мөн өөрийгөө төлөөлөн хэдэн наснаас эрх зүйн харилцаанд орох болон хариуцлага хүлээх талаар ойлголтыг авсан байгаа нь харагдаж байна.

Хоёр. Сурах бичгийн эрх зүйн агуулга, онолын ойлголт. Жишээ 1. Ахлах ангийн сурах бичгийн агуулгад хүүхдийн эрхийн талаарх ойлголт бараг байхгүй. Зөвхөн ганцхан өгүүлбэр байгаа нь мэдээллийн шинжтэй. 11 дүгээр ангийн сурах бичгийн “Хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо” сэдвийн хүрээнд “Хүүхдийн эрхийн конвенцын III нэмэлт протокол хэзээ батлагдсан тухай (102-р хуудаст) дурдсан байдаг.³

³ БСШУСЯ, Нийгэм судлал XI, УБ 2018, хуудас 102

Хүүхдийн эрхийн конвенцийн III нэмэлт протокол “Мэдээлэл хүргүүлэх журмын тухай” 2015 онд батлагдан гарснаар хүүхдийн эрхийн хороонд хүүхэд өөрийнхөө болон бусад хүүхдүүдийн эрхийг зөрчсөн хүний эрхийн зөрчлийн талаар гомдол гаргах механизм бий болсон.

Уг эх сурвалж дээрх өгүүлбэр нь зөвхөн мэдээллийн шинжтэй. Харин сурах бичгийн агуулгад өсвөр насанд тулгамдаж буй асуудлуудыг баримт, судалгаатай мэдээлэл болгон оруулж, зохих хуулийн хариуцлагын хүрээнд хэрхэн шийдвэрлэж буйг тусгах нь чухал юм.

Хүүхэд өсвөр насан дээрээ өөрт тулгамдсан асуудлаа эрх зүйн үүднээс хэрхэн шийдвэрлэж, тулгарч болох асуудлуудыг яаж шийдвэрлэх тухай мэдлэгийг сурах бичгийн агуулгаар мэдээд, өөрийнхөө асуудлыг шийдвэрлэж сурах нь чухал юм.

Хүснэгт 2. Хүүхдийн найз нөхөд, гэр бүлийн хүрээнд тулгардаг асуудал

Хүүхэд өөрт нь тулгарч буй асуудал	Сургууль, гэр бүлийн орчны асуудал	Үе тэнгийн, найз нөхдийн асуудал
Хүүхэд өөрийн эрх, үүргээ хуулийн хүрээнд хэрхэн хамгаалах вэ?	Эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг гэр бүлийн тухай хуульд хэрхэн тусгагдсан вэ? Гэр бүлийн маргаантай асуудлаас болж өөрт ирж буй сэтгэл зүйн асуудлыг хэрхэн даван туулах вэ?	Үе тэнгийн дээрэлхэлтийг ямар хуулиар шийдвэрлэх вэ? Ялгаварлан гадуурхалтын үед хэнээс, хаанаас туслалцаа авч болох тухай.

Дээрх асуудлуудыг хэрхэн эрх зүйн хүрээнд шийдэх гаргалгааг сурах бичигт тусгаснаар үр дүнд нь эрх зүйн мэдлэгтээ тулгуурлан өөрийн болон бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ойлгох, хүлээн зөвшөөрөх хандлагатай иргэн болж төлөвшинө.

Жишээ 2. Сурах бичгийн агуулга тохиолдлыг шинжлэн судлах замаар асуудал шийдвэрлэх чадвартай болгоход чиглэдэг. Харин тохирох жишээ оруулах байдал хангалтгүй байна. Жишээ нь: Доорх оюуны өмчийг хамгаалах эрхийн тухай мэдээлэл.⁴

Эх сурвалжийн мэдээллийн дагуу оюуны өмчийг хамгаалах хууль байдаг тухай мэдэж авсан боловч, оюуны өмчийн зөрчилтэй тулгарсан тохиолдолд хаана хандах, хэрхэн шийдэх механизмыг мэдэхгүй үлддэг.

⁴ Эх сурвалж 2: БСШУСЯ, Нийгэм судлал XI., УБ 2018, хуудас 77

Зохиогчийн эрхийг зөрчих	Зохиогчийн болон түүнд хамаарах эрхийн тухай хууль зөрчих
<p>Зохиогчийн эрхийг зөрчиж бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, худалдсан, түгээсэн, улсын хилээр нэвтрүүлсний улмаас зохиогч, эрх эзэмшигчид их хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг болно. Энэ үйлдэлд дөрвөн зуун тавин нэгжээс 450.000-5.400.000 төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэдэг.</p>	<p>Хэрэв зохиогчийн эрх зөрчсөн үйлдэл нь эрүүгийн гэмт хэргийн шинж агуулаагүй бол зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэдэг. Тухайлбал, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйлс, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, үйл ажиллагааг нь зогсоож, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 500.000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 5.000.000 төгрөгөөр торгоно.</p>

Эх сурвалж дээр Эрүүгийн хууль нь Гэмт хэргийн, зөрчлийн тухай хууль нь гэмт хэргийн бус зөрчлийг хуульд хэрхэн шийдвэрлэдэг тухай тусгасан байна. Харин сурах бичгийн агуулгад оюуны өмчийн ямар маргаантай асуудал үүсдэг, хэрхэн шийдвэрлэдэг тухай мэдээлэл хомс байна.

Хүснэгт 3. Багш, сурагчид түгээмэл тулгамддаг оюуны өмчийг тойрсон асуудал

	Сурагч	Багш	Хуулийн зохицуулалт
<p>2900-4000 төгрөгөөр хэвлэгдсэн сурах бичгийг 20000 төгрөгөөр зарж борлуулж буй үйлдэлд</p>	<p>Сурах бичгээр хангагдах эрх бий юу? Сурах бичгийг үнэтэй худалдаж авах нь зөв үү.</p>	<p>Үнэгүй сурах бичгээр хангах эрхийг шаардах нь зөв үү.</p>	<p>Сурах бичиг хэний өмч вэ? Ямар хуулийн зохицуулалт явагддаг вэ?</p>
<p>Багшийнхаа бэлтгэсэн сорил, тестийг 1000-3000 төгрөгөөр зарж борлуулж буй сурагчдын үйлдэл</p>	<p>Бусдын оюуны өмчид халдаж буйгаа мэддэг эсэх Ямар хариуцлага хүлээх талаар мэдэх үү.</p>	<p>Оюуны өмчийн талаарх бодит жишээ тохиолдолд ямар хариуцлага оногдуулж байгааг мэдэх?</p>	<p>Сошиал орчинд хэрхэн хяналт тавих вэ? Хариуцлага тооцвол ямар арга хэмжээ авах вэ?</p>

⁵ Эх сурвалж 3: БСШУСЯ, Нийгэм судлал XI., УБ 2018, хуудас 83

⁶ Эх сурвалж 3: БСШУСЯ, Нийгэм судлал XI., УБ 2018, хуудас 83

Сурах бичгийн агуулгад тохиолдол шинжлэн, хэрхэн шийдвэрлэж болох тухай мэдээлэл оруулснаар гарах үр дүн нь шинэ зууны, шинэ соёлын тээгч, бүтээгч болж буй өсвөр насныхан оюуны өмчийн тухай ойлголт, мэдэгдэхүүн, хуулийн хариуцлагын тухай мэдлэгтэй болсноор, бусдын оюуны өмчид халдаж буй өөрийн үйлдэлдээ хяналт тавьж, улмаар бусдын үйлдэлд хяналт тавигч иргэн байхад суралцана.

Дэвшүүлж буй санаа

Ерөнхий боловсролын сургуульд сэтгэл зүйч ажиллаж эхэлсэн шиг, эрх зүйч мэргэжилтэн бас байх шаардлага тулгараад байна. Өөрөөр хэлбэл суралцагчид маргаантай асуудлаа шийдвэрлэхдээ хууль, эрх зүйн мэдлэггүйн улмаас хохирч байна.

Үндэслэл: Суралцагчдын хооронд үүссэн маргаантай асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй мэргэжлийн хүнээс хууль зүйн мэдлэг, мэдээлэл олж авснаар учирч болох олон эрсдэлээс өөрсдийгөө хамгаалж болно.

Гурав. Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хүний эрхийн боловсрол олгож буй туршлага

Ирээдүйд иргэн бүр хуульч, өмгөөлөгч болохгүй ч бид бүгдээрээ эрх зүйт нийгэмд амьдарна. Харин хүүхэд ахуй цагаасаа эхлэн эрх зүйн мэдлэг, мэдээллээ ашиглан өөрт тулгарсан асуудлаа шийдэж чаддаг иргэн болж төлөвших нь чухал юм. Миний бие 2016 оноос хойш Нийгэм судлалын хичээлийн агуулгад танхимын бус дараах аргуудыг туршиж, хэрэгжүүлж байна. Үүнд:

Анхан шатны шүүх хуралдаан үзэх.

Зорилго: Шүүх хуралдааны үйл явц, дэг журам хэрхэн явагддаг тухай судлах.

Үйл ажиллагаа нь: Анхан шатны шүүх хуралдааны үйл явцыг хөндлөнгийн ажиглалтын аргаар үзэх.

Хамрагдах сурагчдын тоо: 5-6

Үр дүн: Хууль хэрхэн хэрэгждэг, шүүх хуралдааны үйл явц, иргэний хэргийн шүүх болон захиргааны хэргийн шүүх хуралдаанд оролцогчдын эрх, үүргийн тухай таньж мэдсэн.

Сэргээн санах мэдлэг: 9 дүгээр ангийн сурах бичгийн Нийтийн удирдлага бүлэг дотор Шүүх хэрхэн ажилладаг вэ? сэдвийн хүрээнд Шүүх хурлын зохион байгуулалтын тухай судалдаг.

Хуулийн фермийн үйл ажиллагаатай танилцах.

Зорилго: Ирээдүйд хуульч, өмгөөлөгч, эрх зүйч мэргэжилтэй болох сонирхолтой суралцагчдад эрх зүйн боловсрол олгох.

Үйл ажиллагаа нь: Хэлэлцүүлэг хийх

Хамрагдах сурагчдын тоо: 10-12

Үр дүн: Эзэмшсэн мэргэжлээрээ төрийн болон төрийн бус байгууллагад ажиллахын зэрэгцээ хувиараа хуулийн ферм байгуулж, тодорхой чиглэлийн хүрээнд дагнан ажиллах боломжтой талаар хэлэлцүүлэг өрнөсөн.

Хүний эрхийг хамгаалах чиглэлийн клуб байгуулж ажиллах

Зорилго: Хүний эрхийн боловсролыг түгээн, өсвөр үеийнхэндээ нөлөөлөх компани т ажил зохион байгуулах.

Уриа нь: Хүний эрхийн төлөө Мини Юнисеф

Миний бие 2021-2022 оны хичээлийн жилд Мини Юнисеф хэмээх клубыг Улаанбаатар эмпати сургуулийн 11 дүгээр ангийн 12 сурагчийн хамт байгуулан, ахлах багшаар ажиллаж байна.

Үйл ажиллагаа нь:

2021-2022 оны хичээлийн жилд:

- Хүний эрхэд ээлтэй сар буюу SWEET SEPTEMBER олон нийтийн үйл ажиллагаа.
- Олон улсын хүний эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хүний эрхийг дээдлэх уриалгыг хэвшүүлэх “Ярьдаг футболк” аян.
- “Найрсаг эмпатичууд” сайн үйлсийн аян.
- Жендерийн тэгш байдал”-ын талаарх подкастыг бэлтгэн нийтэд хүргэсэн.
- Хүний эрхийн өдөрлөгт зориулсан өртөөчилсөн тэмцээн зохион байгуулсан.

Үр дүн: Шинэ үеийн сурагчдын манлайллын хандлагыг зөвхөн онц сурахад бус, бие биедээ ээргээр нөлөөлөх сэтгэлгээтэй болгон төлөвшүүлэх. Мөн хүн эрхийнхээ төлөө үг хэлэх, үйлдэл хийх чадварт суралцаж, бусдыг уриалан дуудах, оролцоот иргэн болж төлөвшихөд чухал үүрэгтэй.

Төрийн бус байгууллагын сургагч багшаар ажиллах.

Ахлах ангийн 11-12 дугаар ангийн суралцагчдыг Монголын Эмнести Интернэшнл, Лантуун дохио төрийн бус байгууллагуудад өсвөрийн сургагч багшаар ажиллуулсан.

Зорилго нь: Ялгаварлан гадуурхалт, Үе тэнгийн дээрэлхэлт сэдвийн

хүрээнд өсвөр насныханд эергээр нөлөөлөх.

Үйл ажиллагаа нь:

- Төрийн бус байгууллагын сургалтад хамрагдах
- Өсвөр үеийнхэнд нөлөөлөх нөлөөллийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах.

Сургагч багшаар ажиллах сурагчдын тоо: 5-8

Сургалтанд хамрагдах сурагчдын тоо: Анги нийтээрээ

Үр дүн: Өсвөрийн сургагч багшаар ажилласан суралцагчид тодорхой модуль сургалтын мэдлэгийг бүтээж, багшлах арга зүй, харилцааны ур чадваруудыг эзэмшдэг.

Дүгнэлт:

Эрх зүйт нийгэмд өөрийн үйлдэлдээ хариуцлага хүлээх чадвартай иргэдийг төлөвшүүлэх нь сургууль, багш, эцэг эхийн хамтын үүрэг юм.

Эрх зүй бүлэг агуулгаар танхимын бус сургалтын аргуудыг хэрэглэхэд ихээхэн тохиромжтой байдаг. Ялангуяа хуулийн чиглэлээр сурах хүсэл эрмэлзэлтэй суралцагчдад сонирхолтой байдаг. Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хүний эрхийн боловсрол олгосноор:

- Уламжлалт сургалтын арга барилыг өөрчлөн, хичээлийн агуулгыг энгийн, хялбар аргаар ойлгуулах боломжийг бүрдүүлдэг.
- Олон нийтийн оролцоонд түшиглэн хүний эрхийн боловсролын үнэ цэнийг ойлгуулах хандлага бүрддэг.
- Багш төвтэй сургалтаас шавь төвтэй сургалт руу шилжиж, сурагчдын өөрийн оролцоог нэмэгдүүлснээр сургалтын чанарт мэдлэг нэмэгддэг.
- Онолын мэдлэгийг практикт хэрхэн хэрэглэх аргыг эзэмшин, улмаар мэдлэг хэрэглээ болдог.

Хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд бүх судлагдахууны багш нарын оролцоо маш чухал юм.

Цаашид бид юу хийх вэ?

1. ЕБС-д эрх зүйч мэргэжилтэн ажиллуулах.
2. Хамтын оролцоотой хөгжих алхам судлах. Жишээ нь:
 - Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах
 - Сургалт, семинар хийх
 - Хэлэлцүүлэг хийх гэх мэт.
3. Олон нийтийн оролцоонд түшиглэн хөгжих. Жишээ нь:
 - Хуулийн фермийн үйл ажиллагаатай танилцах
 - Нээлттэй шүүх хуралд оролцох

4. Туршлага судлан “Нээлттэй өдөрлөг” зохион байгуулах. Жишээ нь:
 - Бүтээлч багшийн нэрийн хуудас сэдэвт өдөрлөг зохион байгуулж, сургууль дээрээ урих
5. Төрийн болон Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.
 - Монголын карл попперын мэтгэлцээний нийгэмлэг
 - Монголын Эмнести Интернэшнл

НОМ ЗҮЙ

1. Боловсролын ерөнхий хууль. *Legalinfo.mn*
2. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль. *Legalinfo.mn*
3. Д.Баярсайхан “Эрх зүйн онол. УБ., 1996
4. Н.Цэдэвсүрэн. Сурах бичгийн тухай. УБ., 2003
5. МУБИС “Лавай” сэтгүүл. 2019 он №22
6. БСШУСЯ, Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр. УБ., 2019

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



О.ОТГОНТУЯА

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, хууль зүйн доктор (Ph.D),
цагдаагийн хошууч

ГЭРЛЭЛТ ЦУЦЛАЛТАЙ ХОЛБООТОЙ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

RESOLVING DISPUTES RELATED TO MARRIAGE DISSOLUTION: COMPARATIVE ANALYSIS OF LEGAL FRAMEWORKS

Хураангуй: Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1989 онд баталсан Хүүхдийн эрхийн тухай конвенцод 1990 онд нэгдэн орсон бөгөөд тус конвенц болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Хүүхэд онцгой халамж, хамгаалалт, туслалцаа авах эрхтэй гэж тунхаглаад, хүүхэд бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн учир онцгой халамж, эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай” гэж заасан. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ үндэс болгон, үндэсний хэмжээнд хүүхдийн хөгжил, халамж, хамгаалалтыг тусгасан хууль тогтоомжуудыг батлан хэрэгжүүлж байна.

Манай улсад хүүхдийн эрхийг хамгаалах талаар Гэр бүлийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэгжиж эрх зүйн үндэс бүрдсэн ч шүүхийн хамгаалалт тусгайлан бий болоогүй байсныг Улсын их хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуулиар Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх, Нийслэл дэх Гэр бүл хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийг 2026 оны 01 дүгээр

сарын 01-ний өдрөөс байгуулахаар шийдвэрлэсэн нь хүүхэд эрх зүйн онцгой хамгаалалттай байх үндэстний хэмжээний тогтолцоотой болох эрх зүйн үндэс бүрдээд байна.

Тиймээс Гэр бүлийн шүүхийн харьяалан шийдвэрлэж байгаа гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх маргаанд ямар төрлийн маргаан харьяалагдаж байгаа, эрх зүйн маргаанд харьяалагдаж байгаа маргаанаас гэрлэлт цуцлах маргааныг Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон Улс, Холбооны Бүгд Найрамдах Германы Улсууд хэрхэн зохицуулсан талаар харьцуулан судалж эрх зүйн зохицуулалтаас өөрийн оронд нутагшуулах боломжтой эсэх талаар дүгнэлт, санал гаргах замаар дүн шинжилгээ хийлээ.

Түлхүүр үг: Гэр бүлийн шүүх, гэр бүлийн маргаан, хууль ёсны ашиг сонирхол, шүүхийн хамгаалалт.

Abstract: Mongolia acceded to the Convention on the Rights of the Child, adopted by the United Nations in 1989, in 1990. The Convention and the Universal Declaration of Human Rights of the United Nations state that “the child is entitled to special care, protection and assistance and that, by reason of his physical and mental immaturity, the child needs special care and appropriate legal safeguards.” Mongolia has adopted and implemented national legislation that addresses the development, care and protection of children, based on its obligations under international treaties.

In our country, the Law on Family, Child Protection, Children’s Rights, and Combating Domestic Violence have been implemented and a legal basis has been established for the protection of children’s rights, but no specific judicial protection has been established. The Law on the Establishment of Courts, approved by the State Duma on June 5, 2024, decided to establish the Family and Children’s Court of Appeal and the First Instance Circuit Court for Family and Children’s Cases in the Capital City from January 1, 2026, which has laid the legal basis for a national system of special legal protection for children.

Comparative legal analysis of family law disputes under the jurisdiction of family courts, with particular emphasis on divorce proceedings as a type of legal dispute. The research examines how divorce-related disputes are regulated in the Republic of Korea, Japan, and the Federal Republic of Germany. Based on the comparative findings, the study evaluates the potential for adapting and integrating effective legal frameworks from these jurisdictions into the national legal system, and offers conclusions and recommendations for possible localization.

Keyword: Family Courts, family Disputes, legitimate interests, judicial Protection.

ҮНДСЭН ХЭСЭГ

Гэр бүл, хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтыг эрх зүйн аймаг, эрх зүйн зохицуулалтын онцлогийг харгалзан харьцуулсан судалгааг Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын зохицуулалтыг

- Эдийн ба эдийн бус эрхийг хамгаалах
- Гэр бүлийн шүүхэд харьяалах маргаан
- Эрх зүйн маргааны онцлог (Шүүхийн харьяалан шийдвэрлэж буй маргаанаас гэрлэлт цуцлалттай холбоотой маргааныг тусгайлан авч өөрийн орны зохицуулалттай харьцуулах) гэсэн чиглэлээр харьцуулан судаллаа.

Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид БНСУ гэх)-ын эрх зүйн зохицуулалт:

БНСУ-ын Шүүхийн тухай хуульд зааснаар дараах төрлийн маргааныг Гэр бүлийн шүүх шийдвэрлэнэ¹. Үүнд:

- Гэрлэлтийг хүчингүйд тооцох;
- Гэрлэлт цуцлах;
- Гэр бүл цуцлалтыг хүчингүйд тооцох;
- Гэр бүл цуцлалтыг хүчингүй болгох;
- Шүүхээр гэрлэлт цуцлах;
- Үрчлэлт хүчингүй байх;
- Үрчлэлтийг буцаах;
- Үрчлэлт буцаахыг хүчингүй болгох;
- Шүүхээр үрчлэлтийг буцаах;
- Эцэг тогтоох;
- Хамтран амьдарсан гэр бүлийн харилцааг тогтоох;
- Төрсөн хүүхдээс татгалзах;
- Сүй болон хамтран амьдрах гэр бүлийн харилцааг цуцалсны улмаас учирсан хохирол нэхэмжлэх;
- Гэрлэлт хүчингүй байх, гэрлэлт цуцлах, гэр бүл цуцлалт хүчингүй байх, гэр бүл цуцлалт хүчингүй болгосонтой холбоотой хохирол нэхэмжлэх;
- Үрчлэлт хүчингүй байх, үрчлэлтийг буцаах, үрчлэлтийг хүчингүй болгох, үрчлэлт буцаахыг хүчингүй болгосонтой холбоотой хохирол нэхэмжлэх;
- Эд хөрөнгө хуваахыг шаардахад саад хийх зорилгоор хөрөнгөд өөрчлөлт хийсэнтэй холбоотой нэхэмжлэх.

¹ 가사소송법. БНСУ-ын Гэр бүлийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.
<https://www.law.go.kr/LSW>.

Гэрлэлтийг манай орны зохицуулалтын нэгэн адил² харилцан тохиролцох журмаар (захиргааны журмаар)³, шүүхийн журмаар⁴ цуцална.

Захиргааны журмаар гэрлэлт цуцлах:

Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулахаар харилцан тохиролцсон бол оршин сууж байгаа газрын харьяа Гэр бүлийн шүүхэд гэрлэлтээ цуцлуулах тухай хүсэлтийг хамтдаа гарган шийдвэр гаргуулах бөгөөд гадаадад оршин сууж байгаа тохиолдолд Сөүл хотын Гэр бүлийн шүүхэд хүсэлт гарган шийдвэр гаргуулна⁵.

Захиргааны гэрлэлтээ цуцлуулах тухай хүсэлт гаргасан гэрлэгчид нь Гэр бүлийн шүүхийн гэрлэлт цуцлуулахтай холбоотой зөвлөгөөг авах ёстой ба шүүх шаардлагатай гэж үзвэл тусгай мэдлэгтэй мэргэжлийн туршлагатай хүнээс зөвлөгөө авахыг санал болгож болно⁶.

Гэр бүлийн шүүх нь гэрлэгчид харилцан тохиролцож гэрлэлтээ цуцлуулахаар хүсэлт гаргаж шүүхийн зөвлөгөөг авч эхэлсэн өдрөөс зөвшилцөх хугацаа олгох бөгөөд тухайн хугацаа өнгөрснөөс хойш гэрлэлт цуцалсан тухай шийдвэр гаргах⁷ ба тэжээн тэтгэх хүүхэд байгаа эсвэл жирэмсэн бол 3 сар, тэжээн тэтгэх хүүхэд байхгүй бол 1 сарын хугацаагаар зөвшилцөх хугацааг олгоно. Харин гэрлэлтийг цуцлуулах шалтгаан нь хүчирхийлэлтэй холбоотой нөхцөл байдал байвал уг хугацааг богиносгох эсвэл тогтоохгүй байж болно⁸.

Гэрлэгчид харилцан тохиролцож гэрлэлтээ цуцлуулахаар хүсэлт гаргаж шүүхийн зөвлөгөөг авч эхэлснээс хойш зөвшилцөх хугацаа дууссан тохиолдолд шүүхэд хамт ирж мэдүүлэг өгөх ба хүүхдийн хууль ёсны асран хамгаалалт, түүнийг тэжээн тэтгэх тухай тохиролцоог баталгаажуулсан шийдвэрийг хүлээн авна⁹.

² Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль. 1999. Төрийн мэдээлэл. №30. 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг. www.legalinfo.mn

³ БНСУ-ын Иргэний хууль. 834 дүгээр зүйл. Гэрлэгчид нь харилцан тохиролцох журмаар гэрлэлтээ цуцлуулж болно. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁴ БНСУ-ын Иргэний хууль. 840 дүгээр зүйл. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁵ БНСУ-ын Гэр бүлийн бүртгэлийн тухай хууль. 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

⁶ БНСУ-ын Иргэний хууль. 836.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁷ БНСУ-ын Иргэний хууль. 836.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁸ БНСУ-ын Иргэний хууль. 836.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁹ БНСУ-ын Гэр бүлийн улсын бүртгэлийн журам 74 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=261573&efYd=20240719#0000>

Шүүхээс харилцан тохиролцож гэрлэлтээ цуцлуулах хүсэлтийг шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах, насанд хүрээгүй хүүхдийн асран хамгаалалт, тэжээн тэтгэхтэй холбоотой тодорхойлолт гаргах¹⁰ ба хүүхдийн хууль ёсны асран хамгаалалт, тэжээн тэтгэхтэй холбоотой талуудын тохиролцоо хүүхдэд хохиролтой гэж үзвэл дахин зөвшилцөн тохиролцохыг даалгаж болно, харин гэрлэгчид хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Гэр бүлийн шүүх нь тэжээн тэтгэхтэй холбоотой тэтгэлгийн тохиролцоог баталгаажуулсан тодорхойлолтыг үйлдэхгүй байх эрхтэй¹¹ гэсэн хүүхэд хамгааллын зохицуулалтыг нарийвчлан зохицуулсан байна.

Шүүхийн журмаар гэрлэлт цуцлах:

Шүүхийн журмаар гэрлэлтээ цуцлуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргахаас өмнө эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хүсэлт гаргах ёстой бөгөөд энэхүү хүсэлтийг гаргаагүй бол шүүх эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахаар шилжүүлэх ба манай улсын хувьд эвлэрүүлэн зуучлалд хандаагүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3 дах¹² хэсэгт зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалздаг.

Шүүх гэрлэлт цуцлах маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах бөгөөд зарим онцгой тохиолдолд уг ажиллагааг явуулахгүйгээр гэрлэлтийг цуцалж болох¹³ бөгөөд шүүх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахаас өмнө шаардлагатай нөхцөл байдалд цагдаагийн байгууллага, захиргааны байгууллага, бусад байгууллага, хувь хүнээс гэрлэгчдийн дансны мэдээлэл, хөрөнгийн байдал, орлого, боловсролын байдал болон тухайн маргаанд ач холбогдол бүхий үйл баримтыг тогтооход шаардлагатай мэдээллийг нягтлан шалгах зорилгоор шалгах ажиллагааг явуулж болдог хүний жам ёсны эрхийг хангахад чиглэсэн онцлог зохицуулалттай байна¹⁴.

¹⁰ БНСУ-ын Гэр бүлийн улсын бүртгэлийн журам 78 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=261573&efYd=20240719#0000>

¹¹ БНСУ-ын Гэр бүлийн улсын бүртгэлийн журам 78 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=261573&efYd=20240719#0000>

¹² Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2002. Төрийн мэдээлэл. №28.

¹³ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль. 22, 50, 51, 56, 57 дугаар зүйл. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#0000>

¹⁴ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль. 8 дугаар зүйл. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#>
БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны журам. 3 дугаар зүйл. (Дээд шүүхийн журам). <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=210085&efYd=20190802#0000>

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахгүй байхаар шийдвэрлэсэн¹⁵ эвлэрүүлэн зуучлал хүчин төгөлдөр болоогүй¹⁶ эвлэрүүлэн зуучлах ажиллагааны шийдвэртэй холбогдуулан талуудын гаргасан гомдлыг хүлээн авсан шийдвэр хүчин төгөлдөр бус болсон¹⁷ бол эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусгавар болсон гэж хариуцагчид шүүх хуралд өөрийн биеэр, хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан оролцож нэхэмжлэлийн шаардлагаа танилцуулж, хариу тайлбар гаргахаас гадна шүүхийн шалгах ажиллагаа, нотлох баримтын талаар мэдүүлэг өгч холбогдох тайлбарыг гарган¹⁸ хэргийг шийдвэрлэх ба хариуцагч шүүх хуралд ирэх үүргийг хүлээн оролцдоогоороо манай улсын эрх зүйн зохицуулалттай адил байна.

Япон Улсын эрх зүйн зохицуулалт:

Япон Улсын Гэр бүлийн шүүх нь (Family court, 家庭裁判所法) нь 1949 онд байгуулагдсан бөгөөд одоо аймаг муж бүрт нэг, Хоккайдод дөрвөн шүүх, нийт 49 гэр бүлийн шүүх шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж байна. Тус шүүх нь дараах хэргийг харьяалан шийдвэрлэдэг. Үүнд:

1. Иргэний хуульд заасан гэрлэгч, хүүхдийн эрхтэй холбоотой гэр бүлийн асуудал;
2. Хүүхдийн тухай хуульд заасан насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэрэг;
3. Хүүхдийн тухай хуульд заасан хүүхдийн эрх, эрх чөлөөний эсрэг насанд хүрэгчдийн үйлддэг гэмт хэргүүдийг харьяалуулан шийдвэрлэдэг.

Гэр бүлийн шүүх дараах гэр бүлийн харилцаанаас үүссэн эрх зүйн маргааныг шийдвэрлэж байна. Үүнд,

1. Гэрлэлт цуцлалт
2. Гэрлэлт цуцлахтай холбоотой гэм хорын шаардлага
3. Гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох
4. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тооцох болон тус шийдвэрийг хүчингүйд тооцох
5. Эцэг, эх тогтоох, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх,

¹⁵ БНСУ-ын Иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалын тухай хууль. 26 дугаар зүйл. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=213779&efYd=20200305#0000>

¹⁶ БНСУ-ын Иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалын тухай хууль. 27 дугаар зүйл. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=213779&efYd=20200305#0000>

¹⁷ БНСУ-ын Иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалын тухай хууль. 34 дүгээр зүйл. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=213779&efYd=20200305#0000>

¹⁸ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль. 7 дугаар зүйл, 17 дугаар зүйл. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#> БНСУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 287 дугаар зүйл. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249995&efYd=20231019#0000>

- эцэг, эх байх эрх, үүргээ хэрэгжүүлэхэд саад болсонтой холбоотой
6. Дундын өмчийн хөрөнгө
 7. Хүүхдийн хуваарьт хөрөнгийг зориулалтын бусаар ашиглахтай холбоотой

Гэрлэлтийг БНСУ-ын зохицуулалтын адил харилцан тохиролцох журмаар (захиргааны), шүүхийн журмаар цуцална¹⁹.

Захиргааны журмаар гэрлэлт цуцлах:

Япон Улс захиргааны журмаар гэрлэлтийг цуцлах ажиллагааг Гэр бүлийн бүртгэлийн тухай хуульд²⁰ заасан дараах шаардлагыг хангасан хүсэлтийн дагуу хянан шийдвэрлэх ажиллагаа явагдана. Үүнд²¹,

1. Гэрлэлт цуцлах тухай хүсэлтийг гэрлэгчид хамтдаа гаргах
2. Насанд хүрээгүй хүүхдийн хууль ёсны асран хамгаалагчийн талаар харилцан тохиролцсон тухайгаа хүсэлтэд дурдах
3. Талууд харилцан тохиролцоогүй бол гэрлэлт цуцлах хүсэлтийг хүлээн авахгүй²²

Шүүхийн журмаар гэрлэлт цуцлах:

Шүүхийн журмаар гэрлэлт цуцлуулах үндэслэлийг Иргэний хуульд тусгайлан тогтоож өгсөн²³ ба буруутай этгээд нь шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй байгаа нь гэр бүлийн харилцааны үнэт зүйлсийг хамгаалсан онцлог зохицуулалт гэж дүгнэж болохоор байна. Дараах нөхцөл тогтоогдсон бол шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй байхаар байна.

1. Гэрлэгсдийн хэн нэг нь зүй бус үйлдэл хийсэн бол
2. Гэрлэгсэд нь хэн нэгийгээ санаатайгаар үл тоомсорлон орхисон бол
3. Гэрлэгсдийн хэн нэг нь 3-аас дээш жилийн хугацаагаар ор сураггүй болсон бол
4. Гэрлэгсдийн хэн нэг нь сэтгэцийн хүнд өвчин тусаж эдгэрэх найдваргүй болсон
5. Гэр бүлийн харилцааг үргэлжлүүлэх боломжгүй бусад хүндэтгэн

¹⁹ Япон Улсын Иргэний хууль. 763 дугаар зүйл. <https://www.britannica.com/topic/Japanese-Civil-Code>

²⁰ Япон Улсын Гэр бүлийн бүртгэлийн тухай хууль. <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4409>, <https://laws.e-gov.go.jp/law/322AC0000000224/>

²¹ Япон Улсын Гэр бүлийн бүртгэлийн тухай хууль. 76-78 дугаар зүйл. <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4409>, <https://laws.e-gov.go.jp/law/322AC0000000224/>

²² Япон Улсын Гэр бүлийн бүртгэлийн тухай хууль. 77 дугаар зүйл. <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4409>, <https://laws.e-gov.go.jp/law/322AC0000000224/>

²³ Япон Улсын Иргэний хууль. 770 дугаар зүйл. <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>.

үзэх шалтгаан байгаа бол²⁴

- Хүчирхийлэл;
- Ноцтой доромжлох;
- Ажил эрхлэхгүй байх, хэт их зардал гаргах, өр тавих;
- Гэмт хэрэг үйлдэх;
- Гэрлэгсэд хэн нэгнийхээ эсрэг шүүхэд гомдол гаргах;
- Гэр бүлийн гишүүдийн үл ойлголцол;
- Шашин шүтэх эрхийн зөрчил;
- Бэлгийн амьдралын үл ойлголцол;
- Өвчин, хөгжлийн бэрхшээл;
- Зан байдлын зөрчилдөөн;
- Эвлэрсэн боловч эвлэрлийг баталгаажуулах ажиллагаанд саад учруулах.

Гэрлэлт цуцлахтай холбоотой нэхэмжлэлийг Шүүхийн харьяаллын тухай хуулийн 257 дугаар зүйлийн 257.1 дэх хэсэгт зааснаар манай улстай адил хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

Гэрлэлт цуцлахтай холбоотой маргаанд насанд хүрээгүй хүүхэдтэй бол Гэрлэлт, гэр бүлийн харилцааны тухай хуульд²⁵ зааснаар эвлүүлэн зуучлах ажиллагаа явуулах бөгөөд гэр бүлийн шүүхийн эвлэрүүлэн зуучлах зөвлөл эвлэрүүлэн зуучлалыг явуулах боловч шүүхээс зайлшгүй шаардлагатай гэж үзвэл шүүхэд явуулж болно²⁶.

Япон Улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны тухай хуульд зааснаар гэрлэлтийн харилцаанаас үүссэн гэм хорын нэхэмжлэлийг харьяалах Гэр бүлийн шүүхэд дангаар гаргаж болно²⁷ гэж заасан манай улсын эрх зүйн зохицуулалтаас ялгаатай буюу манай улс гэм хорын асуудлыг гэр бүлийн дундын эд хөрөнгө хуваах, гэр бүлийн харилцаанаас үүссэн гэм хорыг арилгахтай холбоотой асуудлыг ерөнхий байдлаар зохицуулсан билээ.

Гэрлэгчдийн хэн алины зүй бус үйлдэл, хүчирхийлэл зэрэг буруутай үйлдлийн улмаас гэрлэлт цуцлуулах энэхүү буруутай үйлдлээс бий болсон эдийн бус гэм хорыг (сэтгэл санааны хохирол) арилгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болох бөгөөд гэм хорыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг өөрөө болон хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан гэм

²⁴ Япон Улсын Иргэний хуульд тухайлсан нөхцлийг заагаагүй хэдий ч Дээд шүүхээс тайлбарласан байна. 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 542면.

²⁵ Япон Улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны тухай хууль. 6, 7 дугаар зүйл. <https://laws.e-gov.go.jp/law/415AC0000000109/>, <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4178>.

²⁶ Япон Улсын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль. 247-250 дугаар зүйл. <https://laws.e-gov.go.jp/law/423AC0000000052/>,

²⁷ Япон Улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны тухай хууль. 17 дугаар зүйл. <https://laws.e-gov.go.jp/law/415AC0000000109/>, <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4178>.

учирсныг мэдсэн өдрөөс, зүй бус үйлдлийг мэдсэн өдрөөс хойш гурван жилийн дотор, хөөн хэлэлцэх хугацаатай байх хууль бус үйлдлээс хойш хорин жил өнгөрсөн бол хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болно²⁸ гэж гэрлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан хамгаалалтыг тогтоосон нь ач холбогдолтой байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид ХБНГУ гэх)-ын эрх зүйн зохицуулалт:

Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуульд гэр бүлийн хэрэг маргаан болон бусад гэж ангилсан бөгөөд тус хуулийн 111 дүгээр зүйлд заасан дараах маргааныг харьяалан шийдвэрлэж байна²⁹.

Үүнд;

1. Гэрлэлт
2. Эцэг тогтоох
3. Цусан төрөл тогтоох
4. Үрчлэлт
5. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх
6. Тэтгэвэр
7. Тэжээн тэтгэх
8. Гэр бүлийн хөрөнгө
9. Хамтран амьдрагч
10. Бусад

Гэрлэлттэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах маргаан хамаарна³⁰. Үүнд,

1. Гэрлэлт цуцлалт
2. Гэрлэлтийг хүчингүй болгох
3. Талуудын гэр бүлийн харилцааг тогтоох

Гэрлэлттэй холбоотой маргааны хэргийн харьяаллыг өргөн хүрээнд тогтоон хуульчилсан нь гэр бүлийн харилцаанд оролцогч бүрийн эрхийг хангахад ач холбогдолтой гэж дүгнэж болохоор байна. Үүнд³¹,

1. Насанд хүрээгүй хүүхдүүдтэй хамт оршин сууж байгаа газрын харьяа шүүх
2. Гэрлэгсдийн хэн нэг нь насанд хүрээгүй хүүхэдтэй хамт амьдарч байгаа бол тухайн гэрлэгчийн оршин сууж байгаа газрын харьяа шүүх

²⁸ Япон Улсын Иргэний хууль. 724 дүгээр зүйл. <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4314>.

²⁹ ХБНГУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль. https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/

³⁰ ХБНГУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль. 121 дүгээр зүйл. https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/

³¹ ХБНГУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль. 122 дугаар зүйл. https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/

3. Гэрлэгсдийн хамгийн сүүлд хамт оршин байсан газрын харьяа шүүх
4. Хариуцагчийн байнга оршин суугаа газрын харьяа шүүх
5. Нэхэмжлэгчийн байнга оршин суугаа газрын харьяа шүүх
6. Гэрлэх үед 16 насанд хүрсэн боловч 18 насанд хүрээгүй гэрлэгчийн байнга оршин суугаа газрын харьяа шүүх
7. Берлин хотын Шёнебергийн шүүх (Schöneberg in Berlin)

Шүүх шийдвэр гаргах үндэслэл болох нөхцөл байдлыг тогтоох зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зарим шаардлагатай шалгах ажиллагааг явуулах ёстой бөгөөд гэрлэлт цуцлахтай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох этгээд мэдүүлээгүй баримтууд нь гэрлэлтийн харилцааг хадгалахад хүчин төгөлдөр бус байна. Харин хүсэлт гаргагч энэ талаар эсэргүүцээгүй бол харгалзан үзэх боломжийг шүүхэд олгохоор хуульчлан тогтоосон³².

Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийн агуулгад ХБНГУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлд зааснаар дараах зүйлийг заавал тусгаж байгаа нь манай улсын зохицуулалтад заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг илүү дэлгэрэнгүй зааж өгсөн нь шүүх мэдүүлэх эрхийг хангахад ач холбогдолтой байна.

1. Насанд хүрээгүй хүүхдийн нэр, төрсөн он сар өдөр, оршин суугаа газрын хаяг
2. Гэрлэгсэд насанд хүрээгүй хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч, хүүхэдтэй уулзах болон тэжээн тэтгэх асуудал, гэр бүлийн орон сууц, бусад эд хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бусад асуудлыг тохирсон эсэх
3. Гэрлэгсэд гэр бүлийн бусад асуудлаар маргаан хянан хэлэлцүүлж байгаа эсэх
4. Гэрлэлтийн гэрчилгээ, насанд хүрээгүй хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбарыг хавсаргах

Шүүх гэрлэгсэд цаашид гэрлэлтийн харилцааг үргэлжлүүлэх боломжтой гэж үзвэл энэ талаар шийдвэр гаргаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.

Гэрлэгсэд 1 жилээс дээш хугацаагаар тусдаа амьдарсан бөгөөд талууд татгалзвал шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно. Мөн талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай хүсэлт гаргасан тохиолдолд шүүх ажиллагааг түдгэлзүүлэлгүйгээр гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргахыг хориглоно³³. Түдгэлзүүлэх

³² ХБНГУ-ын Иргэний хууль. 1568 дугаар зүйл. https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/

³³ ХБНГУ-ын ХБНГУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль. 136 дугаар зүйл. ХБНГУ-ын Гэр бүлийн болон харьяалалгүй хэрэг шүүхэд

шийдвэрийг нэг удаа дахин гаргаж болох бөгөөд хугацаа нь 1 жилээс хэтэрч болохгүй төдийгүй 3 жилээс дээш хугацаагаар тусдаа амьдарсан тохиолдолд хугацаа нь 6 хүртэл сарын хугацаатайгаар тогтоосон гэр бүлийн харилцаан дах хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангахад чухал зохицуулалт гэж дүгнэж байна.

Гэрлэлт цуцлуулах тухай болон гэр бүлийн бусад маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг хамт явуулах бөгөөд гэр бүлийн бусад маргаанд тэтгэвэр хуваах, насанд хүрээгүй хүүхдийн тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой асуудал, тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой маргаан, гэр бүлийн хөрөнгийн маргаан, гэр бүлийн оршин суух газрын талаарх маргаан зэргийг зааж өгсөн нь хууль зүйн үр дагаврын хувьд ач холбогдолтой байна.

ДУГНЭЛТ:

Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг өөрийн орны онцлог, иргэдийн эрх зүйн ухамсар, олон улсын чиг хандлагад нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төслийн хамт боловсруулах нийгэм эдийн засаг, эрх зүйн шаардлагатай байна.

Бүгд Найрамдах Солонгос Улсын эрх зүйн зохицуулалтад шүүх гэрлэлт цуцлах маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахаас өмнө шаардлагатай нөхцөл байдалд цагдаагийн байгууллага, захиргааны байгууллага, бусад байгууллага, хувь хүнээс гэрлэгчдийн дансны мэдээлэл, хөрөнгийн байдал, орлого, боловсролын байдал болон тухайн маргаанд ач холбогдол бүхий үйл баримтыг тогтооход шаардлагатай мэдээллийг нягтлан шалгах зорилгоор шалгах ажиллагааг явуулж болдог хүний жам ёсны эрхийг хангахад чиглэсэн онцлог зохицуулалттай байна.

Япон Улсын эрх зүйн зохицуулалтад шүүхийн журмаар гэрлэлт цуцлуулах үндэслэлийг Иргэний хуульд тогтоож, дээд шүүхээс буруутай үйлдэлд хамаарах нөхцөлийг зааж, буруутай этгээд нь шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй, гэрлэлтийн харилцаанаас үүссэн гэм хорын нэхэмжлэлийг гаргах хууль зүйн үндэслэлийг харьяалан тогтоосон нь гэр бүлийн харилцааны үнэт зүйлсийг хамгаалсан онцлог зохицуулалт гэж дүгнэж болохоор байна.

Бүгд Найрамдах Герман Улсын эрх зүйн зохицуулалтад гэрлэлт цуцлалтай холбоотой маргааны хэргийн харьяаллыг өргөн хүрээнд тодорхойлсон нь гэр бүлийн харилцаанд оролцогчийн шүүхээр хамгаалуулах эрхийг хангах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд эерэг байна. Мөн гэрлэлт цуцлуулах

хянан шийдвэрлэх тухай хууль.

нэхэмжлэлийн агуулгыг дэлгэрэнгүй хуульчилсан нь шүүх мэдүүлэх эрхийг хангахад ач холбогдолтой гэж дүгнэж байна.

ДЭВШҮҮЛСЭН САНАЛ:

1. Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг өөрийн орны эрх зүйн онцлог, нутагших боломжид тулгуурлан гэр бүлийн харилцааг de facto зарчимд тулгуурлан боловсруулах
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг гэр бүлийн маргаан тус бүрт тусгайлан зааж өгөх
3. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Монгол хүний үнэт зүйлс, удмын сангийн аюулгүй байдлыг гэр бүлийн судлалын хүрээнд тодорхойлон зохицуулах

НОМ ЗҮЙ:

Хууль тогтоомж:

1. *Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль. 1999.*
2. *Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2002.*
3. *한국민법. БНСУ-ын Иргэний хууль (1958. 2021)*
4. *가족관계의 등록 등에 관한 법률. БНСУ-ын Гэр бүлийн бүртгэлийн тухай хууль (2021)*
5. *가사소송법. БНСУ-ын Гэр бүлийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2021)*
6. *БНСУ-ын Иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалын тухай хууль.*
7. *БНСУ-ын Гэр бүлийн улсын бүртгэлийн журам.*
8. *БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны журам.*
9. *日本の民法. Япон Улсын Иргэний хууль (1896. 2020)*
10. *日本の家族登録法. Япон Улсын Гэр бүлийн бүртгэлийн тухай хууль (2020)*
11. *Япон Улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны тухай хууль.*
12. *Япон Улсын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль.*
13. *ХБНГУ-ын Иргэний хууль.*
14. *ХБНГУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль.*

15. ХБНГУ-ын Гэр бүлийн болон харьяалалгүй хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.

Цахим эх сурвалж:

1. <https://www.law.go.kr/LSW/>.
2. <https://www.law.go.kr/>
3. www.legalinfo.mn
4. <https://www.britannica.com/topic/Japanese-Civil-Code>
5. <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>.
6. https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Р.ОЧИРБАЛ

Отгонтэнгэр их сургуулийн багш

ИРЭЭДҮЙ ХОЙЧИЙН ЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ОНОЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

THEORETICAL PERSPECTIVES ON RECOGNIZING THE HUMAN RIGHTS OF FUTURE GENERATIONS

Хураангуй

Өнөө үеийнхний ирээдүй хойчийн өмнө хүлээх хууль зүйн болон ёс суртахууны үүргийн асуудал нь шинжлэх ухааны олон салбарын чухал судлагдахуун болж байна. Уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдал, зэвсэгт мөргөлдөөн зэрэг дэлхийн тулгамдсан сорилтуудыг шийдвэрлэхийн тулд ирээдүй хойч үеийн эрхийг хүлээн зөвшөөрч, өнөө үеийнхний үүрэг хариуцлагыг тодорхойлох шаардлага чухлаар хөндөгдөж байна. Энэхүү өгүүлэлд үе хоорондын шударга ёсны асуудал, тэр дундаа ирээдүй хойчийн эрхийг хүлээн зөвшөөрөх эсэх талаарх онолын зарим асуудал, ирээдүй хойчийн эрхийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэхэд чиглэсэн зарим санаачилгуудыг авч үзэх болно.

Abstract

The legal and moral obligations of present generations towards future generations - those not yet born - pose an interdisciplinary concern across the world. Addressing pressing global challenges such as climate change, biodiversity loss, and armed conflict requires clarifying whether the human rights of future generations receive legal recognition and delineating the responsibilities of present generations. This article examines intergenerational justice by analyzing core theoretical debates on the recognition of human rights of future generations.

Түлхүүр үгс: *Үе хоорондын шударга ёс, ирээдүй хойчийн эрх*

Key words: Intergenerational justice, Intragenerational Justice, Rights of future generations

I. Удиртгал

Хүн төрөлхтний ирээдүй хойчийн өмнө хүлээх хууль зүй, ёс суртахууны үүргийн асуудлыг шинжлэх ухааны үүднээс харьцангуй хожуу буюу 1970-аад оноос эхлэн судлах болсон. Байгаль орчин, байгалийн баялгийн ашиглалттай холбогдон бий болсон энэхүү асуудал эдүгээ нийгэм, эдийн засаг, технологи зэрэг шинжлэх ухааны олон салбарын чухал судлагдахуун болжээ. Дайн, зэвсэгт мөргөлдөөн, уур амьсгалын хямрал, биологийн олон янз байдлын хомсдол зэрэг аж үйлдвэржилт, хүний хүчин зүйлээс үүдсэн энх тайвны болон байгаль орчны тулгамдсан олон асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх үндэсний болон олон улсын хүчин чармайлт нь ирээдүй хойчийн эрхийг хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрөх, өнөө үеийнхний ирээдүй хойчийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох талаарх институтийн механизмыг боловсронгуй болгохыг шаардсаар байна.

Ирээдүй хойчийн өмнө хүлээх өнөө үеийнхний үүрэг, хариуцлагын асуудлыг авч үзэхийн тулд юуны өмнө “ирээдүй хойч”, эсхүл “ирээдүй үеийнхэн” буюу “future generations” гэх ойлголтыг тодруулах шаардлагатай. Хэдийгээр дээрх ойлголтын талаар нэг мөр тодорхойлолт байхгүй хэдий ч (1) хүн болж мэндлээгүй байгаа хүн төрөлхтний хойч болсон дараа дараагийн олон үе; (2) хүн болж мэндэлсэн ч хараахан иргэн болж чадаагүй байгаа үеийнхэн; (3) хүүхэд, залуучууд буюу насны ангиллын хувьд тухайн нийгмийн харьцангуй залуу үеийнхэн¹ хэмээн ялгаатай тодорхойлох хандлага ажиглагдаж байна.

Сүүлийн 2 ойлголтын тухайд өнөө үеийнхэн ирээдүй хойчийн өмнө хууль зүйн болон ёс суртахууны үүрэг, хариуцлага хүлээх нь тодорхой байдаг. Бодитой оршин байгаа үе хоорондын шударга ёс, тэгш эрхийн асуудлыг “нэг үе хоорондын шударга ёс” буюу “Intragenerational Justice/ intragenerational equity/Justice within a Generation”-ын хүрээнд судалж байна.

Энэ нь 1992 онд батлагдсан Байгаль орчин болон Хөгжлийн талаарх Риогийн тунхаглалын 6 дугаар зарчимд тусгасан өнөө үед амьдарч байгаа хүмүүсийн хооронд шударга ёсыг хангах зорилготой холбоотой. Ингэхдээ чинээлэг болон ядуу иргэд хоорондын шударга ёс

¹ *Simon Caney, Justice and Future Generations, Annual Review of Political Science, 2018.*

/social justice/, улс орнуудын хоорондох шударга ёс /international justice/, жөндөр хоорондын шударга ёс /justice between genders/ болон өөр бусад хэлбэрийн² шударга ёсны асуудлыг хөнддөг. Нэг үе хоорондын шударга ёсны асуудлыг өнөөгийн нөхцөл байдлын хүрээнд авч үздэг хэдий ч хүрэх зорилго нь ойрын ирээдүйд чиглэдэг.

Харин хүн болж хараахан мэндлээгүй байгаа ирээдүй үеийнхний эрхийг хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрөх талаарх онолын маргаан нь тэдний өмнө хүлээх өнөө үеийнхний үүргийг хууль зүйн агуулгаар тодорхойлоход хүндрэлтэй болгодог. Цаг хугацаа, орон зайн хувьд шууд харилцаанд оролцох боломжгүй өнгөрсөн, одоо, ирээдүй хойч гэсэн үе хоорондын шударга ёсны асуудлыг “Intergenerational Justice” гэсэн хүрээнд судалдаг. Хэдийгээр зарим эрдэмтэд хүн болж хараахан мэндлээгүй байгаа ирээдүй хойчийн эрхийг хүлээн зөвшөөрч хууль зүйн үүднээс хамгаалах шаардлагатай хэмээн үздэг ч дээрх үзлийг эрдэмтэд хэд хэдэн үндэслэлээр шүүмжилдэг.

II. Үндсэн хэсэг

Ирээдүй хойчийн хүний эрхийг хүлээн зөвшөөрөх эсэх талаарх онолын асуудал

Хүн болж хараахан төрөөгүй байгаа (futurity problem) нь ирээдүй хойчийн хүний эрхийг хүлээн зөвшөөрөхгүй байх томоохон үндэслэлийн нэг юм.³ Үүнийг нийгмийн гэрээний талууд буюу субъектын шаардлагатай холбон тайлбарлах нь нийтлэг бөгөөд нэгэнт нийгмийн гэрээний бодитой тал болж чадахгүй учир ирээдүй хойчийн хувьд “эрх”-ийн асуудлыг ярих боломжгүй⁴ хэмээн үздэг. Тухайлбал, Английн эдийн засгийн нэрт эрдэмтэн Филфрэд Бекерман өөрийн бүтээлдээ:

“ ... Байгалийн баялагтай холбоотой “эрх”-үүд нь ямар нэгэн зүйлтэй байх, эсхүл олж авах, тодорхой үйлдэл хийх зэрэг шаардах эрхийн агуулгыг илэрхийлдэг. Энэ нь өөр этгээд түүний шаардсан зүйлийг өгөх, зөвшөөрөх үүрэгтэй гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл эрх оршин байгаа нь үүрэг бий болох урьдач нөхцөл юм.⁵ Харин ирээдүй үеийнхэн буюу

² Хүүхэдтэй болон хүүхэдгүй гэр бүл, эрүүл болон өвчинтэй хүн, хөдөлмөр эрхэлдэг болон эрхэлдэггүй хүн хоорондын шударга ёс, шашны үзэл болон бэлгийн чиг хандлагын ялгаатай байдлаас үүдсэн шударга ёс гэх мэт.

³ Jens Saugstad, *Moral responsibility towards future generations of people; Utilitarian and Kantian ethics compared*, <http://folk.uio.no/jenssa/Future%20Generations.htm>

⁴ De George, Richard, 1981, “The Environment, Rights, and Future Generations”: 157–166.

⁵ Wilfred Beckerman, *The Impossibility of a theory of intergenerational Justice*, *Handbook of Intergenerational Justice*, 2006, 56-57.

төрөөгүй байгаа хүмүүсийг эрхтэй хэмээн үзэж болохгүй. Шударга ёсны ямар ч онол хүмүүст эрхийг (ёс суртахууны эрх) бий болгоход чиглэдэг. Иймд ирээдүй үеийнхний ашиг сонирхлыг шударга ёсны аливаа онолын хүрээнд хамгаалах, дэмжих боломжгүй”.⁶ Өнөө үеийнхэн ирээдүй хойч үеийнхэнд ундны цэвэр ус, амьсгалах агаар, эсхүл орлуулах боломжгүй бусад анхдагч нөөцийн хомсдолд хүргэхгүй байх ёс суртахууны үүрэгтэй хэдий ч энэ нь тодорхой хөрөнгийг өвлүүлэн үлдээх үүргийн агуулгыг илэрхийлэхгүй. Тэгвэл урт хугацааны байгаль орчны асуудалд дээрх ойлголт ямар үр дагавартай вэ? Хэн нэгэн хоёр зуун жилийн дараа хор аюул учруулах тэсрэх бөмбөг, эсхүл цацраг идэвхт цөмийн хаягдлыг аюултай газарт булсан гэж төсөөлье. Энэ нь одоо төрөөгүй байгаа хэдий ч ирээдүйд оршин байх олон хүнд хохирол учруулж, тэдний хор аюулаас ангид байх эрхийг ирээдүйд зөрчих нь гарцаагүй. Гэвч энэ нь тэсрэх бөмбөг, эсхүл цацрагт идэвхт хаягдлыг газарт булсны улмаас 200 жилийн дараа хохирох хүмүүсийг эрхтэй хэмээн үзэх үндэслэл болохгүй.”⁷ гэжээ.

Гэхдээ ирээдүй үеийнхэн өөр өөрсдийн бодит үедээ “эрх”-тэй байх нь гарцаагүй⁸ бөгөөд тухайн үеийн нөхцөл байдлаас хамааран тэдний ашиг сонирхол тодорхойлогддог хэмээн үзэх нь бий. Харин өнөө үеийнхний хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаа тэдний ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж болзошгүй тохиолдолд тэдний өмнө хүлээх өнөө үеийнхний ёс суртахууны үүрэг, хариуцлагыг хэрхэн тодорхойлох асуудал үүсдэг. Гэвч Филфрэд Бекерман ирээдүй хойч үеийнхэнд тодорхой ашиг сонирхол байдаг тул тэдэнд эрх байх ёстой гэсэн үзлийг дараах хоёр үндэслэлээр үгүйсгэжээ.

“Нэгдүгээрт, ашиг сонирхолтой байна гэдэг нь эрхтэй байх ойлголттой зарим талаараа холбоотой хэдий ч эрхтэй гэж үзэх хангалттай нөхцөл болж чадахгүй. Тухайлбал, олон хүн өөрсдийн хурдан морийг уралдаанд түрүүлэхийг харах ашиг сонирхолтой хэдий ч энэ тэднийг уралдааны үр дүнгийн хувьд аливаа эрхтэй гэж үзэх үндэслэл болохгүй. Хоёрдугаарт, ирээдүй хойч үеийнхэн ирээдүйд ашиг сонирхолтой байх, эсхүл ирээдүйд эрх эдэлж магадгүй гэж үзэх нь тэднийг төрөхөөс өмнө буюу өнөөдрийн хувьд тодорхой ашиг сонирхолтой гэж үзэх үндэслэл болохгүй.⁹ Түүнчлэн ирээдүй хойч үеийнхэн өөрсдийн ашиг сонирхлыг хамгаалах ажлыг хэн нэгэнд даатгах, төлөөлүүлэх нь логикийн болон

⁶ *Wilfred Beckerman, 51.*

⁷ *Wilfred Beckerman, 57.*

⁸ *Meyer, Lukas, “Intergenerational Justice”, The Stanford Encyclopedia of Philosophy (Summer 2021 Edition), <https://plato.stanford.edu/entries/justice-intergenerational/#HowInteRelaDiffRelaAmonCont>*

⁹ *Wilfred Beckerman, 59-60.*

бодит байдлын хувьд боломжгүй. Ирээдүй хойчийн ашиг сонирхлыг төлөөлнө гэж хэн ч ярьж болно. Харамсалтай нь ирээдүй хойч үеийнхэн өөрсдийн гэгдэх төлөөлөгчдийг сонгох, ямар бодлого баримтлахыг тодорхойлоход ямар ч үүрэг, оролцоотой байж чадахгүй”¹⁰ гэжээ.

Хэдийгээр ирээдүй хойчийн “эрх”, “ашиг сонирхол”-ыг хүлээн зөвшөөрөх нь онол, үзэл баримтлалын хувьд маргаантай хэдий ч өнөө үеийнхний бодлого, үйл ажиллагаа нь ирээдүй хойчийн хүсэл эрмэлзэл, нөхцөл байдал, зан үйл, оршин тогтнолд¹¹ нөлөөлөх боломжтой болохыг харгалзан өнөө үеийнхэн ирээдүй хойчийн өмнө ёс суртахууны үүрэг, хариуцлага хүлээх ёстой гэсэн үзэл давамгайлж байна.

Английн эрдэмтэн Парфит өөрийн бүтээлдээ “Хэрэв бид газар дор хагархай шил булах аваас 100 жилийн дараа бидний дээрх үйлдлийн улмаас хойч үеийнхэн бэртэх болно”¹² гэсэн бол Филфрэд Бекерман “би ирээдүй хойч үеийнхний “эрх”-ийг үгүйсгэж байгаа нь бид тэдэнд нөлөөлж болох үйлдлийнхээ үр дагаварт санаа зовних ёс суртахууны үүрэг хүлээхгүй гэсэн үг биш”¹³ гэжээ. Гэвч ирээдүй хойчийн ашиг сонирхол нь өнөө үеийнхний ашиг сонирхлоос давамгай үнэ цэнтэй / *trumping value*/ гэж үзэж боломжгүй¹⁴ бөгөөд алс ирээдүй хойч үеийн ашиг сонирхлын төлөө өнөө үеийнхэн өөрсдийгөө золиослох чадварт хүний төрөлх чанар байнга нөлөөлдөг¹⁵ хэмээн Филфрэд үзжээ.

Өнөө үеийнхний гаргасан шийдвэр ирээдүй хойч үеийнхэнд эерэг, сөрөг байдлаар шууд болон шууд бусаар нөлөөлөх боломжтой. Өнөө үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх олон хувилбараас ямар арга замыг сонгох нь ирээдүй хойч үеийнхэнд нөлөөлөх боломжтой. Харин ирээдүйн хойч үеийнхэн өнөө үеийнхний сайн сайхан байдлын төлөө ямар нэгэн үүрэг, хариуцлага хүлээх, эсхүл тэдэнд хор хохирол учруулах бодит боломжгүй байдаг нь үе хоорондын шударга ёсны үндсэн асуудал юм.

Ирээдүй хойчийн өмнө хүлээх ёс суртахууны үүргийн асуудлыг тодорхойлоход дээрх үүргийн хамрах цаг хугацааны хүрээ; чухам хэний төлөө хариуцлага хүлээх эсэх, тухайлбал, нэгж хүн, эсхүл ирээдүйн хойч үе гэсэн хамтын этгээдийн өмнө үүрэг хүлээх эсэх; хүлээх үүрэг, хариуцлагын агуулга буюу чухам юуны төлөө хариуцлага хүлээж байгаа

¹⁰ *Wilfred Beckerman, 60.*

¹¹ *Meyer, Lukas, “Intergenerational Justice”, The Stanford Encyclopedia of Philosophy (Summer 2021 Edition), Edward N. Zalta (ed.), <https://plato.stanford.edu/cgi-bin/encyclopedia/archinfo.cgi?entry=justice-intergenerational>*

¹² *Parfit, Derek (1984), Reasons and Persons, Oxford: Clarendon Press, p.356*

¹³ *Wilfred Beckerman, 64*

¹⁴ *Wilfred Beckerman, 65.*

¹⁵ *Wilfred Beckerman, 64.*

эсэх; өнөөгийн хариуцлагатай харьцуулахад ирээдүйн төлөө хүлээх хариуцлагын ач холбогдол; өнөө үеийнхэн ирээдүй хойчийн өмнө хүлээх үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрч бодитоор биелүүлэхэд хэрхэн түлхэц үзүүлэх¹⁶ зэрэг олон асуудал урган гардаг хэдий ч өнөө үеийнхэн ирээдүй хойчийн хэрэгцээ, ашиг сонирхлыг урьдчилан таамаглаж, ёс суртахууны үүргийг тэрхүү агуулгад нийцүүлэн тодорхойлж чадах уу гэсэн үндсэн асуудал тулгардаг.

Хэдийгээр байгаль орчны бохирдол, байгалийн баялгийн хэт ашиглалт, уур амьсгалын өөрчлөлт, түүнээс үүдэх хор уршиг зэрэг нь алс ирээдүй хойч үеийнхэнд шийдвэрлэхэд хүндрэлтэй тулгамдсан асуудлыг бий болгож байгаа хэдий ч бидний ирээдүйн талаарх мэдлэгийн хязгаарлагдмал байдал нь өнөө үеийнхний ирээдүй хойчийн өмнө хүлээх ёс суртахууны үүргийн агуулгыг тодорхойлох, урт хугацааны хувилбарт бодлогын үр дагаврыг бүрэн таамаглах боломжийг алдагдуулдаг. Гэвч ирээдүй хойчийн үндсэн хэрэгцээг ерөнхийлөн мадаглаж тэдний өмнө хүлээх ёс суртахууны үүргийг агуулга, зарчмыг тодорхойлох гэсэн онол, үзэл баримтлал тасралтгүй хийгдсээр байна.

АНУ-ын хуульч, философич Жон Роулс шударга ёсны онолын гол элемент болох ирээдүйн хүмүүсийн өмнө хүлээх өнөө үеийнхний ёс суртахууны үүргийн асуудлыг анх удаа системтэйгээр хөндсөн нь үе хоорондын шударга ёсны талаарх судалгааны үндсэн эх сурвалж болжээ. Тэрээр “Шударга ёсны онол” /A Theory of Justice/ хэмээн бүтээлдээ нийгмийн үндсэн бүтэц хэрхэн ажилладаг, нийгмийн институт шударга ёсны асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар тухайлан судалсан бөгөөд өнөө үеийнхний ирээдүй хойчийн өмнө хүлээх гол үүрэг бол шударга үндсэн бүтэц /just basic structure/¹⁷-ийг хадгалах явдал хэмээн үзсэн. Шударга ёсны зарчмуудыг логик дараалалд оруулснаар нийгмийг хэрхэн зохион байгуулах, хувь хүний эрх, үүргийг тодорхойлох, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нийт гишүүдэд хэрхэн шударгаар хуваарилах боломжтой болохыг тэрээр тайлбарласан.

Түүний боловсруулсан дээрх онол нь шударга ёсыг тогтоох дараах 4 зарчимд суурилдаг. Үүнд, (1) шударга үндсэн бүтэц, түүний институт, (2) нийгмийн бүх гишүүдийн эрүүл, сайн сайхан амьдрах тогтвортой

¹⁶ Dieter Birnbacher, *Responsibility for future generations – scope and limits*, *Handbook of Intergenerational Justice*, 2006, 29.

¹⁷ Түүнийхээр “шударга үндсэн бүтэц” гэдэг нь иргэдийн эрх чөлөө, бие даасан байдлыг баталгаажуулж, тэгш бус байдалд хүргэх нөхцөл байдлыг улам бүр багасгах бүтэц юм. Laura Leigh Birdwell, *Environment, future Generations, and John Rawls*, *Philosophy Honors Thesis* (2003).12.

амьдралын нөхцөлийг хангах, (3) үе тус бүрийн хамгийн бага давуу талыг хүртэж байгаа нийгмийн бүлгийн итгэлийг тогтвортой нэмэгдүүлэх баталгааг хангах, (4) тэдний соёлыг хадгалах зэрэг болно.

Дээрх шударга ёсны бүтцийг хангахын тулд үндсэн капиталыг зөвхөн өнөө үеийнхэн бус, мөн дараа дараагийн олон үе хүртэх хуваарилалтын шударга ёсыг хангаж, үе үеийнхэн үндсэн капиталыг “шударгаар хадгалах” /just savings/ шаардлагатай хэмээн тэрээр үзжээ. Түүнийхээр үндсэн капитал гэдэг нь эрх чөлөө, боломж, орлого ба эд баялаг, өөрийгөө хүндлэх нийгмийн үндэс бөгөөд эдгээрийг эрдэмтэд байгалийн капитал /natural capital/, санхүүгийн капитал /artificial and financial capital/, соёлын капитал /cultural capital/, нийгмийн хамтын ажиллагаа, хувь хүн, бүлгийн хоорондын тогтвортой харилцаа, үнэт зүйл гэх мэт нийгмийн капитал /social capital/, эрүүл мэнд, боловсрол, мэдлэг, туршлага гэх гэх зэрэг хүний капитал /human capital/ гэх зэргээр ангилжээ.¹⁸

Үе хоорондын шударга ёсны асуудлыг тайлбарлахад улс төрийн байгууллагын эрх мэдлийн хууль ёсны байдалд илүүтэй хариулт өгдөг уламжлалт нийгмийн гэрээний онол хэт хязгаарлагдмал байгааг харгалзан тэрээр нийгмийн үндсэн бүтцийн асуудлыг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл зэрэг төрийн эрх мэдлийн үндсэн асуудлаас гадна эдийн засгийн тогтолцооны үндэс, түүний дотор эдийн засгийн үйлдвэрлэл, солилцоо, хэрэглээнд зайлшгүй хөндөх үндсэн асуудал болох өмч, түүнийг шилжүүлэх, дахин хуваарилалт, цаашлаад гэр бүлийн хүлээн зөвшөөрөгдөх хэлбэрийн асуудлыг хөндсөн. Түүнийхээр нийгмийн үндсэн институтийг бүрдүүлдэг тогтолцоо, хэм хэмжээг үнэлж, түүний зохион байгуулалт нь бидний нөхцөл байдал, зорилго, зан байдал, ирээдүйн хөгжилд хэрхэн нөлөөлдөг болохыг дүгнэхгүйгээр шударга ёсны асуудлыг хөндөх бололцоогүй бөгөөд эдийн засгийн үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээг хангахын тулд капитал, бараа бүтээгдэхүүн, баялгийг шилжүүлэх талаарх дүрэм журамгүйгээр тогтвортой, тэсвэртэй нийгмийг бий болгох боломжгүй юм.¹⁹

Тэрээр хүн төрөлхтний нэг үе нөгөө үедээ хандахдаа зохистой гэж хүлээн зөвшөөрөх боломжтой нөхцөл байдлуудыг цогц нэг үзэл баримтлалд нэгдэхийг эрэлхийлж нөхцөлт нийгмийн гэрээний /hypothetical contract/ “үндсэн байр суурь” /original position/ гэх ойлголтыг бий болгож нийгмийн гэрээний уламжлалт онолтой холбон тайлбарласан нь ирээдүй хойчийн өмнө хүлээх үүргийг тодорхойлоход чухал үүрэг

¹⁸ Joerg ‘Chet’ Tremmel, *Handbook of Intergenerational Justice*, 2006, 12.

¹⁹ Meyer, Lukas, “Intergenerational Justice”, *The Stanford Encyclopedia of Philosophy* (Summer 2021 Edition),

гүйцэтгэдэг. Өмнөх буюу өнгөрсөн үеийнхэн бидэнд хор хохиролтой, эсхүл ашиг тустай байж болох хэдий ч өнөө үеийнхэн өнгөрсөн үеийнхэнтэй харилцаж чадахгүй. Үүний нэгэн адил өнөө үеийнхэн ирээдүйн хойч үеийнхэнд эерэг, сөрөг нөлөө үзүүлэх хэдий ч тэдэнтэй бодитоор харьцаж чадахгүй.

Ийм нөхцөлд нийгмийн гэрээний “үндсэн байр суурь”-ийг хэрхэн тодорхойлох асуудалд хариулт өгөхийн тулд тэрээр “veil of ignorance” гэх үзэл баримтлалыг боловсруулсан. Энэ нь нийгмийн гэрээний оролцогч талууд “үндсэн байр суурь”-ийг тодорхойлж, тайлбарлахын тулд өөрийн хүйс, арьсны өнгө, үндэс угсаа, хөрөнгө чинээ, нийгмийн байр суурь, өөрийн авьяас чадвар, хувийн үнэт зүйл, ирээдүйд эдлэх эрх, хүлээх үүрэг зэрэг объектив, субъектив нөлөөлөл, эрх ашиг, хэрэгцээ шаардлага, нөлөөллөөс хамааралгүй, ангид байр сууринаас хандах шаардлагатай хэмээн тэрээр үзсэн. Өөрөөр хэлбэл бид нийгмийн үндсэн бүтцийн асуудлыг эрх тэгш байдлын /equality/ үүднээс авч үзэхдээ тухайн системд ямар байр суурьтай байх эсэх талаар ямар ч төсөөлөл, ашиг сонирхолгүй хандахыг шаарддаг.

Veil of ignorance нь аливаа нөхцөл байдлын үед оролцогч талууд өөрт бий болох давуу болон сул талыг тооцох, үнэлэх боломж болон өөртөө тохируулан шийдвэр гаргах, шийдэл боловсруулах, өөрт ашигтай зарчмуудыг хүлээн зөвшөөрөх боломжийг хааж өгдөг. Ийм нөхцөл бүрдсэн үед гэрээний талууд шударга ёсны үндсэн зарчим болох (1) хүн бүр үзэл бодолтой байх эрх чөлөө, сонгох, сонгуульд оролцох эрх чөлөө, хуульд заасан журмын дагуу үйл ажиллагаа явуулах эрх гэх мэт либерал эрхийг баталгаажуулсан зарчим, (2) хамгийн бага орлого, хөрөнгөтэй хүмүүст үр ашгийг хүртэх баялгийн хуваарилалтаас гадна эдийн засгийн боломжийн тэгш байдлыг хангасан байх зарчмыг хангах боломжтой болно.

Ирээдүй хойчийн хүний эрхийг хүлээн зөвшөөрөх олон улсын санаачилга

Ирээдүй хойчийн эрхийг хүлээн зөвшөөрөх, өнөө үеийнхний ирээдүй хойчийн өмнө хүлээх ёс суртахууны болон хууль зүйн үүргийг бодлого, эрх зүйн баримт бичигт баталгаажуулах олон улсын болон улс орнуудын санаачилга улс бүр нэмэгдсээр байна.

НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага (UNESCO)-ын 29 дэх удаагийн бага хурлаас 1997 оны 11 дүгээр сарын 12-нд баталсан “Өнөө үеийнхний ирээдүй хойчийн өмнө хүлээх үүрэг,

хариуцлагын тунхаглал” (Declaration on the Responsibilities of the Present Generations Towards Future Generations)²⁰ нь эрх зүйн хувьд заавал биелэгдэх шинжгүй хэдий ч чухал баримт бичигт тооцогддог. Уг тунхаглалд зааснаар өнөө үеийнхэн нь өнөө болон ирээдүй хойчийн олон талт ашиг сонирхол болон хэрэгцээг хамгаалах, хангах (нэгдүгээр зүйл), өнөө үеийнхэн болон ирээдүй хойчийн хүний эрх болон үндсэн эрх чөлөөнд зохих анхаарлаа хандуулж, улс төр, эдийн засаг болон нийгмийн эрхийг хангах олон талт сонголттой байж соёлын болон шашны онцлогоо ирээдүйд хадгалах боломжийг олгох (хоёрдугаар зүйл), ирээдүй хойчдоо хүний үйл ажиллагааны үр дүнд бий болсон нөхөж баршгүй хохирол учруулахаас зайлсхийх, байгалийн баялаг, экосистемийн хортой өөрчлөлтөөс хамгаалах, шинжлэх ухаан болон техникийн хөгжлийг ухамсартайгаар ашиглан дэлхийд хор уршиг учруулахгүй байх (дөрөвдүгээр зүйл), тогтвортой хөгжлийг эрхэмлэн дэлхийд амьдрах, оршин тогтнох нөхцөлийг бүрдүүлж байгаль орчны чанар бүрэн бүтэн байдлыг хангах, байгаль орчны бохирдлоос хамгаалах, ирээдүй хойчийн эрүүл мэнд эсэн мэнд орших байдалд аюул учруулах аливаа үйлдлээс татгалзах, хүний амьдрал, хөгжлийг тэтгэхэд шаардлагатай байгалийн нөөцийг ирээдүй үедээ хадгалан үлдээх, том хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ цаашид учирч болох эрсдэлийг тооцох (тавдугаар зүйл), хүний эрхэм чанарыг хүндэтгэж хүний генийг хамгаалах, шинжлэх ухаан, технологийн дэвшил нь хүн төрөлхтөн болон байгалийн төрөл зүйлд хор уршиг, нөхөгдөшгүй хохирол учруулахгүй байх (зургадугаар зүйл) гэх зэрэг энх тайван, аюулгүй байдал, байгаль орчны болон байгалийн баялгийн тогтвортой ашиглалт, хамгаалалт, эдийн засаг, нийгэм, улс төр, соёл, боловсрол, шинжлэх ухаан, технологийн олон салбарт ирээдүй хойчийн өмнө өнөө үеийнхний хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлсон.

2024 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 79 дүгээр тогтоолоор баталсан “Ирээдүйн төлөөх Пакт” (Pact for the Future)-д өнөө үеийнхний хүүхэд, залуучууд болон хүн төрөлтний дараа дараагийн олон үе хойчийн өмнө хүлээх олон талт үүргийн агуулгыг 56 бие даасан үйл ажиллагааны хүрээнд дахин баталгаажуулж, хавсралт I-ээр Даян дэлхийн дижитал компакт (Global Digital Compact), хавсралт II-оор Ирээдүй хойчийн тунхаглалыг баталсан.

²⁰ UNESCO, *Declaration on the Responsibilities of the Present Generations Towards Future Generations*, 2 November 1997, Paris, France <https://www.unesco.org/en/legal-affairs/declaration-responsibilities-present-generations-towards-future-generations> <https://docs.un.org/en/A/RES/79/1>

Ирээдүй хойчийн тунхаглалд ирээдүй хойч гэдэг өнөө бидний үед амьдарч байгаа хүүхэд, залуучууд төдийгүй дэлхийд хүн болж мэндлээгүй байгаа дараа дараагийн олон үеийг хамруулсан болохыг онцлон тэмдэглэсэн²¹ боловч хүн болж төрөөгүй байгаа ирээдүйн хойчийн “эрх” гэсэн хэллэгийг ашиглахаас зайлсхийж “хэрэгцээ”, “ашиг сонирхол” гэсэн нэр томъёог хэрэглэсэн.

Дээрх баримт бичиг ирээдүй хойчийн хэрэгцээ, ашиг сонирхлыг хангах үүрэг амлалтыг бүрэн, үр дүнтэй биелүүлэхийн тулд улс орнууд, холбогдох талуудын үйл ажиллагаандаа баримтлах 10 удирдах зарчим болон зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэлгэрэнгүй тодорхойлсон. Тэдгээр зарчимд энх тайван, аюулгүй байдал; хүний эрхэм чанарыг аливаа алагчлалгүйгээр хүндэтгэх, хамгаалах; тогтвортой хөгжлийн эрх тэгш боломжийг олгох; үе хоорондын хамтын ажиллагааг дэмжих; эрүүл-тогтвортой байгаль орчин; хариуцлагатай, ёс зүйтэй шинжлэх ухаан, технологийн ашиглалт, хөгжил; жендэрийн эрх тэгш байдлыг хангах; оролцооны эрх тэгш байдал; арьс үндэс, арсны өнгө гэх зэргээр үл алагчлах; нээлттэй, үр дүнтэй, олон талт хамтын ажиллагаа зэргийг хамруулсан нь ЮНЕСКО-гийн баталсан “Өнөө үеийхний ирээдүй хойчийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагын тунхаглал”-ын агуулгатай нийтлэг ижил юм.

Харин ирээдүй хойчийн эрхийг хүний эрх болохыг эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрч улс орнууд, бизнесийн байгууллага болон бусад холбогдох талуудын үүрэг, хариуцлагыг хууль зүйн агуулгаар тодорхойлох шаардлагатай гэсэн үзэл хандлагад зарим ахиц гарсаар байна. Үүний тодорхой илрэл нь шинжлэх ухааны байгууллагууд, эрдэмтэн, судлаачид, хүний эрхийн зүтгэлтнүүд, иргэний нийгэм, уугуул хүмүүс гэх зэрэг олон талт оролцогчдын олон жилийн хамтын үйл ажиллагааны үр дүнд бий болсон “Ирээдүй хойчийн хүний эрхийн талаарх Маастрихтын зарчмууд” (Maastricht Principles on The Human Rights of Future Generations) юм. Уг баримт бичиг ирээдүй хойч гэдгийг эдүгээ хараахан эх дэлхийн мэндээгүй байгаа хүн төрөлхтний олон үе хойч хэмээн тодорхойлсон бөгөөд эдгээрт, бодгаль этгээд, бүлэг, эсхүл ард түмэн байж болохоор тодорхойлсон.²²

²¹ *Summit of the Future Outcome Documents, September 2024, Pact for the Future, Global Digital Compact and Declaration on Future Generations, p.52. https://www.un.org/sites/un2.un.org/files/sof-pact_for_the_future_adopted.pdf*

²² *Maastricht Principles on The Human Rights of Future Generations, General Provision, 1 definition, <https://www.ohchr.org/sites/default/files/documents/new-york/events/hr75-future-generations/Maastricht-Principles-on-The-Human-Rights-of-Future-Generations.pdf>*

Хүний эрхийн олон улс эрх зүйн хэм хэмжээнд заасан хүний эрхийн хамгаалалт нь хүн төрөлхтний залгамж халаа болсон ирээдүй хойчид нэгэн адил хамаарах бөгөөд өнгөрсөн, одоо, ирээдүй хойч хүний эрхэм чанарын хувьд эрх тэгш бөгөөд хүний эрхийг бүрэн, эрх тэгш хэрэгжүүлэх эрхтэй болохыг тэмдэглэсэн.²³ Ирээдүй хойчийн эрх нь зөвхөн иргэний болон улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм, соёлын эрхээр хязгаарлагдахгүй бөгөөд цэвэр, эрүүл, тогтвортой байгаль орчны эрх, хөгжих эрх, энх тайван байх эрх, өөрийгөө тодорхойлох эрх зэрэг өргөн агуулгаар тодорхойлсон. Ирээдүй хойч үеийнхэн нь ялангуяа, үе хоорондын шударга бус байдал болох (i) хог хаягдал, сүйрэл, хүний амьдралын үндсэн хэрэгцээт нөөцийн тогтворгүй ашиглалт, (ii) өнөө үеийнхний хямралыг ирээдүй хойчид дарамт болгон шилжүүлэх, (iii) өнөө үеийнхний амьдралын ирээдүйн үеийнхний амьдралаас илүү үнэ цэнтэй гэж үзэх байдлаас ангид хамгаалагдсан байх баталгааг хангах,²⁴ ийм үр дагавар гаргахаас зайлсхийх, урьдчилан сэргийлэх нь холбогдох талуудын үүрэг болохыг дээрх зарчимд тодорхой заасан.²⁵

Удирдах зарчмын хоёрдугаар бүлэгт ирээдүй хойчийн хүний эрхийн хүндэтгэх, хамгаалах, хангах төрийн үүрэг, тэдгээр үүрэг тус бүрийг зөрчсөн гэж үзэх үндэслэлүүдийг нэг бүрчлэн нэрлэн зааж, мэдээлэл олж авах эрх, хил дамнасан хүний эрхийн зөрчлийг шийдвэрлэх асуудлыг нарийвчлан тодорхойлсон нь ирээдүйн хойчийн эрхийг хамгаалах төрийн хүний эрхийг үүргийг тодорхойлоход ихээхэн ач холбогдолтой юм. Улс орнууд ирээдүй хойч үеийнхний хүний эрхийг хөндсөн шийдвэр гаргахад үр дүнтэй оролцох боломжийг хангах үүднээс бүх түвшинд хүртээмжтэй байж чадах байгууллага, институци, тухайлбал омбудсмэн, хүний эрхийн үндэсний байгууллагын комиссар, парламентын зохих хороо, байгаль хамгаалах үндэсний шүүхүүд зэрэг байгууллага, институци, механизмуудыг бий болгоход анхаарах шаардлагатай²⁶ хэмээн үзсэн.

Харин гуравдугаар бүлэгт ирээдүй хойчийн эрхийг хангах чиглэлээр бизнесийн байгууллага, засгийн газар хоорондын олон улсын байгууллага, хувь хүн болон бусад бүлгийн хүлээн үүрэг хариуцлага, 4 дүгээр бүлэгт холбогдох талуудын хүлээх хариуцлага болон зөрчигдсөн эрхийг сэргээх арга, процедурын асуудлыг нарийвчлан тодорхойлсон.

²³ *Ibid*, article 5.

²⁴ *Ibid*, article 6.

²⁵ *Ibid*, article 9.

²⁶ *Ibid*, article 22(d).

III. Дүгнэлт

Эдүгээг чухалчлан ирээдүйг эзгүйчлэх төрийн бодлого, хүний хүчин зүйлийн нөлөөллийн улмаас хүн төрөлхтний үе хоорондын түгээмэл хэрэгцээ, ашиг сонирхол болсон энх тайван, дайн дажингүй байх, байгаль орчны болон экологийн сүйрлээс хамгаалагдах, биологийн олон янз байдлын хомсдолоос сэргийлэх, байгалийн болон соёлын өв уламжлал, ахуй амьдралын болон соёлын онцлог, ялгаа бүхий байдлаа тогтвортой хадгалах боломж улам бүр хумигдаж байна. Иймээс улс үндэстэн, олон улсын түвшинд ирээдүй хойчийн эрхийг хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрч аливаа бодлого, шийдвэр, үйл ажиллагааны тогтвортой, үр дүнтэй эсэхийг үнэлэх чухал шалгуур болгох хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Алс ирээдүй хойч үеийн эрх, ашиг сонирхлыг ёс суртахуун, хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй гэх уламжлалт үзлийн эсрэг ирээдүй хойчийн эрхийг хүлээн зөвшөөрөх үзэл хандлага нэмэгдэж, суурь онол, үзэл баримтлал зарим тохируулга хийх санаачилга аажим боловч тогтвортой эрчимжсээр байна.

Уур амьсгалын хямрал, улс орнуудын зэвсэгт мөргөлдөөн, байгалийн баялгийн хэт ашиглалтын бодлого зэрэг нь ирээдүй хойчийн өмнө хүлээх өнөө үеийнхний үүрэг, хариуцлага, үе хоорондын шударга ёсны үзэл санааг улам боловсронгуй болгож, институтийн түвшний цогц бодлого, стратеги, шийдлийг шаардаж байна.

IV. Ном зүй

- *Simon Caney, Justice and Future Generations, Annual Review of Political Science, 2018.*
- *Jens Saugstad, Moral responsibility towards future generations of people; Utilitarian and Kantian ethics compared, 2005*
- *De George, Richard, The Environment, Rights, and Future Generations, 1981,*
- *Wilfred Beckerman, The Impossibility of a theory of intergenerational Justice, Handbook of Intergenerational Justice, 2006*
- *Meyer, Lukas, "Intergenerational Justice", The Stanford Encyclopedia of Philosophy (Summer 2021 Edition)*
- *Parfit, Derek, Reasons and Persons, Oxford: Clarendon Press, 1984*
- *Dieter Birnbacher, Responsibility for future generations – scope and limits, Handbook of Intergenerational Justice, 2006*
- *Laura Leigh Birdwell, Environment, future Generations, and John Rawls, Philosophy Honors Thesis, 2003*

- *Joerg 'Chet' Tremmel, Handbook of Intergenerational Justice, 2006*
- *UNESCO, Declaration on the Responsibilities of the Present Generations Towards Future Generations, 2 November 1997, Paris, France*
- *Summit of the Future Outcome Documents, September 2024, Pact for the Future, Global Digital Compact and Declaration on Future Generations*
- *Maastricht Principles on The Human Rights of Future Generations*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Б.ПҮРЭВСҮРЭН

Судлаач, Хууль зүйн магистр

ДОРМЖЛОХ НЬ ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖГҮЙ ГЭЖ ДҮГНЭСЭН УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хураангуй: Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл Худал мэдээлэл тараах гэмт хэрэгт 2020-2024 оны эхний хагаст нийт 2260 хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн нь хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлахад томоохон нөлөөлөл үзүүлж байна. Глоб Интернэшнл төвөөс жил бүр гаргадаг Хэвлэлийн эрх чөлөөний тайланд 2022.05.01-2024.05.03-ны өдөр хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн хүчин төгөлдөр 45 шийдвэр байгаа талаар дурдсан. Үндсэн хуулийн цэцээс 2024 оны 8 дугаар сарын 1-ний өдөр Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг Монгол улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх асуудлаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх тухай 98 дугаар тогтоол гарсан. Худал мэдээлэл тараах гэмт хэрэгтэй холбоотой Улсын Дээд Шүүхээс 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр шийдвэрлэсэн дугаар 2024/ХШТ/110 тогтоол нь тус гэмт хэргийг хяналтын шатнаас шийдвэрлэсэн хамгийн анхны тохиолдол учраас тус шүүхийн шийдвэрийг сонгон авсан нь судалгаа шинжилгээ болон хууль хэрэглээний ач холбогдолтой хэмээн үзсэнээр сонгон авах үндэслэл болов. Эндээс үзвэл, гүтгэх, гутаах, доромжлох өөр хоорондоо харилцан адилгүй гурван тусдаа үйлдэлд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу худал мэдээлэл тараах гэмт

хэрэгт холбогдуулан ял шийтгэл хүлээлгэхгүй байхаар шийдвэрлэсэн нь практикт хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах түүхэн ач холбогдол бүхий шийдвэр болсон гэж дүгнэж болохоор байна.

Түлхүүр үг: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрх чөлөө, худал мэдээлэл тараах, доромжлох, гүтгэх, гутаах, гутаан доромжлох, илт худал мэдээлэл тараах гэмт хэрэг, гүтгэх зөрчил, худал мэдээлэл тараах гэмт хэргийн тоо баримт, хэвлэлийн эрх чөлөөний тайлан, бусдын нэр төр, нэр алдар, алдар хүндийг хамгаалах, олон нийтийн сүлжээнд, гутаан доромжилсон агуулгатай бус харин илт худал мэдээллийг олон нийтэд тараасан үйлдэл, гэмт хэргийн шинжгүй.

УДИРТГАЛ

Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд 13.14 дүгээр зүйл буюу “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийг шинээр хуульчилж, 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдөр “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдсэн.¹ Худал мэдээлэл тараах гэмт хэргийн тоо баримтын тухайд, Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл Худал мэдээлэл тараах гэмт хэрэгт 2020-2024 оны эхний хагаст нийт 2260 хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн² нь хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлахад томоохон нөлөөлөл үзүүлж байна.

/Доорх мэдээллийг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулагдсан Хэвлэл мэдээллийн эрх зүйн форумд хуульч Д.Оросоогийн тавьсан илтгэлээс авав./

Д/д	Он	Хэрэг бүртгэлийн хэргийн шийдвэрлэлт	Хэрэг бүртгэлийн хэргийн шийдвэрлэлт			Мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлт				
		Нийт хэрэг	Нэгтгэгдсэн	Хэрэг бүртгэлийн хэргийг хаасан	Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан	Нийт хэрэг	Хэрэгсэхгүй болгосон	Түдгэлзүүлсэн	Нэгтгэсэн	Шүүхэд шилжүүлсэн
1	2020	258	7	122	19	26	0	0	3	19
2	2021	388	5	227	25	44	10	0	7	22
3	2022	438	6	216	30	43	3	1	6	26
4	2023	622	9	286	47	64	1	1	9	40
5	2024 эхний хагас жил	554	2	197	23	47	1	0	8	26
6	Бүгд	2260	29	1048	144	224	15	2	33	133

¹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2020.02.13, №07/1109/ <http://parliament.mn/n/wzmy>

² Шүүхийн ил тод байдал төслийн хүрээнд Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагаас (IDLO) 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр хийсэн сургалтын үеэр тус статистикийг танилцуулсан.

Глоб Интернэшнл төвөөс жил бүр гаргадаг Хэвлэлийн эрх чөлөөний тайланд³ 2022 оны тавдугаар сарын нэгний өдрөөс 2024 оны 2022.05.01-2024.05.03-ны өдөр хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн хүчин төгөлдөр 45 шийдвэр байгаа талаар дурдсан. Үндсэн хуулийн цэцээс 2024 оны 8 дугаар сарын 01-ний өдөр Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг Монгол улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх асуудлаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх тухай 98 дугаар тогтоол гаргасан.

Худал мэдээлэл тараах гэмт хэрэгтэй холбоотой Улсын Дээд Шүүхээс 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр шийдвэрлэсэн 2024 /ХШТ/ 110 тогтоол нь тус гэмт хэргийг хяналтын шатнаас шийдвэрлэсэн хамгийн анхны тохиолдол учраас тус шүүхийн шийдвэрийг сонгон авсан нь судалгаа шинжилгээ болон хууль хэрэглээний ач холбогдолтой хэмээн үзсэнээр сонгон авах үндэслэл болов. Тухайлбал,

Б.Б нь 2023 оны 2 дугаар сарын 12-ны өдөр цахим орчинд “... Нам дагаж хоолоо олж иддэг, эрх мэдэлтнүүдэд үйлчилдэг тавиул гөлөгнүүд мөнгө, эрх мэдлийн төлөө юу ч хийхэд бэлэн болжээ. 2024 оны УИХ-ын сонгуулиас өмнө ... Х бөгс долоогч, ... дарга Д, ... асан Б шоронгийн манаач ... дарга Б, ... гишүүн Б нарыг зайлуулж байж Ардчилсан сонгууль зохион байгуулах талаар ярих боломжтой” гэсэн худал мэдээ тараасан гэмт хэрэгт холбогджээ.

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шүүгдэгч Б.Б-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 500 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 500.000 төгрөгөөр торгох ял шийтгэж, уг ялыг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон үеэс 90 хоногийн хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар торгох ялыг шүүхээс тогтоосон 90 хоногийн хугацаанд биелүүлэхгүй бол торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солихыг сануулж шийдвэрлэсэн байна.

Харин Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгч Б.Б-ын давж заалдсан гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

³ “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан-2022-2023” Глоб Интернэшнл төв ТББ, 31 дэх тал. Дэлгэрэнгүйг эндээс үзнэ үү. https://www.gic.mn/public/docs/freedom_report/media_freedom_report_2022_2023_mn.pdf

Энэхүү шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийе.

Б.Б-д холбогдох Худал мэдээлэл тараах гэмт хэрэг. Улсын Дээд Шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 02 ны өдрийн дугаар 110 тогтоол⁴. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл.

1/ Гэмт хэргийн шинжийн талаар:

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл /Худал мэдээлэл тараах/-ийн 1 дэх хэсэгт зааснаар “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” бол 450,000–аас 1,300,000 төгрөгөөр торгох, эсхүл 240–720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1-3 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Энэхүү зохицуулалтаас харахад, дараах ойлголт гарч ирж байна. Үүнд:

- хүний “нэр төр”, “алдар хүнд”,
- хуулийн этгээдийн “ажил хэргийн нэр хүнд”
- “илт худал мэдээлэл”
- “олон нийтэд тараах”

Хяналтын шатны шүүхэд шүүгдэгч Б.Б гаргасан гомдолдоо “... Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийн хувьд “... Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” заасан байх бөгөөд тус гэмт хэрэг нь “нэр төр, алдар хүндэд халдсан, илт худал мэдээлэл тараасан” байхыг шаардах бөгөөд иргэн Б.Б-ын хийсэн үйлдэл нь хохирогч нарын нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээлэл байсан эсэх эргэлзээтэй обьектив шинж бүрэн хангагдаагүй байхад давж заалдах шатны шүүх иргэн Б.Б-ыг гэмт хэрэг үйлдсэн хэмээн ял оногдуулсан үйлдэл нь хууль зүйн хувьд үндэслэлгүй байна. Мөн түүнчлэн, давж заалдах шатны шүүхийн магадлалын тодорхойлох хэсэгт “... Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “ худал мэдээлэл тараах” гэмт хэргийг нэмэлтээр оруулсан бөгөөд энэ гэмт хэрэг нь “нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” гэж обьектив талын шинжээр нь тодорхойлогдсон, “илт худал мэдээлэл” гэсэн ойлголтод зарим тохиолдолд тодорхой

⁴ Тус тогтоолыг бүрэн эхээр нь эндээс үзнэ үү. https://shuukh.mn/single_case/3628?-daterange=2024-10-01%20-%202024-12-31&id=3&court_cat=2&bb=1

үйл баримт, болсон үйл явдалд үнэлэлт дүгнэлт өгсөн, шүүмжилсэн, тодорхой үндэслэл бүхий боловч ингэх явцдаа нэр хүндийг гутаасан, түүнд халдсан, бодит баримтыг бүрэн гүйцэд бус, алдаатай мэдээлэл тараасныг хамруулан ойлгоно” хэмээн дүгнэсэн. Гэтэл иргэн Б.Б-ын хэлсэн зүйлс нь хохирогч нарын “нэр алдар хүндэд халдсан, илт худал мэдээлэл тараасан” үйлдэл биш бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх үедээ залуу хүний омголон зангаар хэтрүүлж хохирогч нарыг доромжилсон өнгө аясаар л хэлсэн зүйлс бөгөөд энэ нь гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хангахгүй юм хэмээн гаргасан гомдолдоо дурдсан.

Эндээс үзвэл доромжлохыг гэмт хэрэгт хэрхэн тооцож ирсэн талаар товч дурдах нь зүйтэй юм. Тухайлбал, Монгол Улсын үе үеийн Эрүүгийн хуульд доромжлох, гүтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцож хуульчилж ирсэн. Ингэхдээ бусдын нэр төр, нэр алдар, алдар хүндийг хамгаалах зорилгоор юм. Ял шийтгэлийн хувьд 1942, 1961, 1986 оны Эрүүгийн хуульд зааснаар торгох, донгодох, албадан ажил хийлгэх хэлбэртэй байсан. Харин 2002 оны Эрүүгийн хуульд торгохоос гадна баривчлах шийтгэлтэй болсон бөгөөд хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэснээс хүнд хор уршиг учирсан бол хорих шийтгэлтэй байхаар заасан. Энэ уламжлал 2017 оноос ялимгүй өөрчлөгдөж, Эрүүгийн хуулиас гүтгэх, доромжлох үндсэн гэмт хэргийг хассан ч “жижиг гэмт хэргийн хууль” гэгддэг Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад 6.21 дүгээр зүйл буюу “Гүтгэх” зөрчлийг оруулж “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан⁵ нь 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд 13.14 дүгээр зүйл буюу “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийг шинээр оруулсан хүртэлх хугацаанд буюу хоёр жил хагасын хугацаанд үйлчилж байв. Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 6.21 дүгээр зүйлд заасан Гүтгэх зөрчил 2018 онд 496 гарснаас хялбаршуулсан журмаар 10 зөрчлийг шалган шийдвэрлэж, зөрчлийн 486 хэрэг нээн шалгаж, 76 хүнд шийтгэл оногдуулсан. 2019 онд 520 гарснаас хялбаршуулсан журмаар 10 зөрчлийг шалган шийдвэрлэж, зөрчлийн 512 хэрэг нээн шалгаж, 101 хүнд шийтгэл оногдуулсан. 2020 онд 95 гарснаас хялбаршуулсан журмаар таван зөрчлийг шалган шийдвэрлэж, зөрчлийн 90 хэрэг нээн шалгаж, 35 хүн шийтгэл оногдуулж⁶, хууль хэрэгжиж байсан хугацаанд

⁵ Л.Галбаатар, “Доромжлох гэмт хэргийг дахин сэргээх нь зөв эсэх асуудал”, Улаанбаатар хот, 2023 он.

⁶ Нээлттэй нийгэм форум, “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан

нийтдээ 1111 зөрчил гарснаас, 212 хүнд шийтгэл оногдуулсан байна.

Цаашилбал, иргэн Б.Б өөрийн үзэл бодлоо илэрхийлсэнтэй холбоотойгоор гомдолдоо тайлбарласан. Үүнд,

1. “Нам дагаж хоолоо олж иддэг”,
2. “Эрх мэдэлтнүүдэд үйлчилдэг”,
3. “... тавиул гөлөгнүүд”,
4. “... эрх мэдлийн төлөө юу ч хийхэд бэлэн болжээ ...”,
5. “... .. У.Х бөгс долоогч ...дарга Д...”,
6. “... Х.Б шоронгийн манаач СЕХ-н ... дарга Б ...”,

7. “... Хохирогч нарыг зайлуулж байж ардчилсан сонгууль зохион байгуулах талаар ярих боломжтой...” гэх зэргийг дурдсан. Мөн нотолбол зохих асуудлын талаар өөрийн байр суурийг шүүх хуралдааны үеэр илэрхийлэхдээ, үзэл бодлоо илэрхийлсэн үү, эсхүл худал мэдээлэл тараасан уу гэдгийг тогтоосны дараа энэ нь ажил хэргийн нэр хүнд, алдар хүндэд нь яаж нөлөөлсөн болохыг тогтоох ёстой байхад аль аль хийгдээгүй байхад намайг гэмт хэрэг хийсэн гэж үзэн ял оногдуулж байгаа өөрөө хууль зүйн хувьд үндэслэлгүй гэж үзсэн байна.

2/ Нотлох баримт, нотолбол зохих байдлын талаар:

Прокурор Б.Мөнгөншагайгийн шүүх хуралдаанд хэлсэн хууль зүйн дүгнэлтэд дурдагдсан дараах нотолбол зохих асуудлуудыг авч үзвэл:

- Мөрдөн шалгах ажиллагаагаар тухайн албан тушаалд хэзээ, хэрхэн томилогдсон болохыг шалгаж тогтооход хуульд заасан үндэслэл журмын дагуу томилогдсон, болзол шаардлагыг хангасан төрийн хаагчид байсан.
- Тухайн албан тушаалд томилогдсоноор ямар эрх мэдэлтнүүдэд хэрхэн үйлчилсэн талаар баримт байхгүй байхад гүтгэсэн мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тараасан.
- Хэнээс мөнгө авч, ямар эрх мэдлийн төлөө юу хийсэн талаар тодорхой зүйл байхгүй байхад зохиомол зүйл ярьсан.
- Энэ гэмт хэргийн хувьд бөгс долоогч гэдгийг шууд утгаар нь бус тал засах, долигонох талаас нь авч үзнэ. Гэтэл ... ямар харилцаа холбоотой, хэрхэн тал зассан талаар баримт байхгүй.
- Мөн урьд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ажиллаж байсантай нь холбогдуулан “... .. асан Б шоронгийн манаач...” гэж

шийдвэрлэж буй практик”, 45 дахь тал, Улаанбаатар 2021 он.

доромжилсон мэдээллийг тараасан нь худал мэдээлэлд хамаарч байна.

- Сэдэлтийн хувьд Б.Б-ыг ажлаас нь гаргахаар хавчиж, шаардсан үйл баримт нотлогдоогүй. Харин ажил хэргийн хувьд таарамжгүй харилцаатай байсан ба Б.Б өөрийн хүсэлтээр ажлаасаа гарч, өс хонзон, хардалтын шинжтэй, олон нийтийн сүлжээнд тавигдсан тодорхой бус, цуу ярианд үндэслэсэн мэдээллийг нийтэд тараасан нь нийгмийн хор аюул их, ардчилсан сонгууль болохгүй гэдэг агуулгаар мэдээлэл тараасан

Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй, 4 дэх хэсэгт зааснаар энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална. Түүнчлэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялганд ашигтайгаар шийдвэрлэнэ. Тэгэхээр шүүхээс дээрх хэргийг шийдвэрлэхдээ хохирогчдын “нэр төр”, “алдар хүнд”, түүнд халдсан “илт худал мэдээлэл” гэх ойлголтыг заавал тайлбарлах ёстой байжээ. Харамсалтай нь, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжуудад илт худал мэдээллийг ангилан тайлбарласан эрх зүйн орчин бүрдээгүйгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч эрх бүхий этгээдүүд харилцан адилгүй ойлгож, хуулийг нэг мөр тайлбарлан хэрэглэхгүй байгаа нийтлэг зүй тогтол ажиглагдаж байна. Харин УИХ-д 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр өргөн барьсан⁷ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд⁸ дараах байдлаар авч үзсэн нь сайшаалтай юм.

Нөгөө талаас, хохирогч тус бүрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд харилцан адилгүй болох талаар дүгнэлт өгөх нь зүйтэй юм. Ийн дүгнэлт өгөөгүйн улмаас, Хөвсгөл аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 00112 дугаар шийдвэрт⁹ нийт төрийн албан хаагчдын нэр төр, алдар

⁷ <https://d.parliament.mn/tusul/d61259be-fafe-414c-923b-e980aa129a2e>

⁸ 4.1.9. “ташаа мэдээлэл” гэж бусдын сэтгэл санаа, бие махбодь, эсхүл хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хохирол учруулах зорилгогүйгээр түгээсэн бодит байдалд нийцэхгүй гэдгийг мэдээгүй, эсхүл мэдэх боломжгүй байсан алдаатай мэдээ, мэдээлэл, баримт сэлтийг; 4.1.10. “илт худал мэдээлэл” гэж хүн, хуулийн этгээд, улс оронд санаатайгаар хохирол учруулах зорилгоор түгээсэн ор үндэслэлгүй худал мэдээ, мэдээлэл, баримт сэлтийг.

⁹ Б.Пүрэвсүрэн, “Эрүүгийн хуулийн Худал мэдээлэл тараах гэмт хэрэгт

хүндийг адилтган авч үзэж, Эрүүгийн хуулийн 13.14 дэх хэсэгт заасан хүний нэр төр, алдар хүнд гэх ойлголтыг объектоор нь хүмүүсийн нэр төр, алдар хүнд гэж үзэн хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн хууль хэрэглээний ноцтой алдаа гаргаж байсан жишээ бий.

Монгол улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.4 дэх хэсэгт “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” нь Улсын Дээд Шүүхийн бүрэн эрхийн асуудал. Нөгөө талаас, аутентик тайлбар хийх субъект нь Монгол Улсын хувьд хууль тогтоох дээд байгууллага болох Улсын Их Хурал юм. Улсын Их Хурал баталсан хуулиуддаа албан ёсны тайлбар, тодотгол хийсээр ирсэн ба ихэвчлэн нэр томъёоны тайлбар, зарим заалтын тодотгол тайлбар зэргээр хязгаарлагдсан байдаг.

3/ Шүүхээс хэрэглэвэл зохих эх сурвалжийн талаар:

Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар ч мөн адил хамгаалдаг. НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2011 оны 07 дугаар сарын 11-29-ний өдөр хуралдаж 102 дугаар чуулганаар хэлэлцэн баталсан ИБУТЭТОУП-ын 19-р зүйлийн Ерөнхий тайлбар №34-ийн 42 дахь хэсэгт “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэгч, сэтгүүлчдийн гагцхүү Засгийн газар, эсхүл Засгийн газрын дэмжлэгтэй улс төр, нийгэм, хуулийн тогтолцоог шүүмжилсний төлөө шийтгэл ногдуулахыг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зайлшгүй хязгаарлалт гэж хэрхэвч үзэж болохгүй” тухай дурдсан. Мөн түүнчлэн тус тайлбарын 47 дахь хэсэгт “...нийтийн албан тушаалтнуудтай холбоотой тайлбар сэтгэгдлийн хувьд шийтгэх, санамсаргүй алдаа гаргаж, хорон санаа агуулалгүйгээр хэвлэн нийтэлсэн материалыг үнэн бус, хууль бус гэж үзэхээс зайлсхийвэл зохино” тус тус заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасныг үндэслэн олон улсын хэм хэмжээг баримтлах ёстой байна.

Шүүхээс дараах хэсгийг тодорхойлох хэсэгтээ удирдлага болгосон байна.

Б.Б-ыг “Худал мэдээлэл тараах” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаж чадахгүй байна.

шийтгүүлсэн анхны тохиолдолд хийсэн дүн шинжилгээ” Улаанбаатар хот, 2020 он. Энэхүү шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээг дараах линкээр үзнэ үү. <https://legaldata.mn/buteel/upd?id=839>

Худал мэдээлэл тараах гэмт хэрэг нь хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон агуулгатай бус харин илт худал мэдээллийг олон нийтэд тараасан үйлдлийг ойлговол зохино.

Олон нийтийн сүлжээ ашиглан тэднийг гүтгэж, гутаан доромжилсон шинжтэй мэдээллийг цахим орчинд тараасан үйлдлийг хоёр шатны шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг бүрэн хангасан гэж прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийн хүрээнээс хальсан дүгнэлт хийсэн нь учир дутагдалтайн дээр хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн хууль хэрэглээний ноцтой алдаа гэж үзнэ. 2002 оны Эрүүгийн хуулийн 110 дугаар зүйлд заасан “Доромжлох”¹⁰ гэмт хэргийн шинжийг агуулсан үйлдэл мөн боловч 2015 оны Эрүүгийн хуулиар дээрх үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй болсныг тодотгон тайлбарлавал зохино.

Өөрөөр хэлбэл, үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох эсэхийг тухайн гэмт хэргийг үйлдэх үед мөрдөж байсан хуулиар тодорхойлдог бөгөөд Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх, үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон хуулийг буцаан хэрэглэх нь хууль ёсны зарчимд харшлах хуулиар хориглосон үйлдэл юм.

Иймд шүүгдэгч Б.Б-ын гаргасан гомдлыг хангаж, “... Х бөгс долоогч, ... асан Б шоронгийн манаач” гэх зэргээр бусдыг гүтгэж, гутаан доромжилсон агуулгатай мэдээллийг цахим сүлжээ ашиглан олон нийтэд тараасан гэх үйлдлийг “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт тооцох боломжгүй тул Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэргийг гэмт хэргийн шинжгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгахаар хяналтын шатны шүүхээс шийдвэрлэлээ гэсэн байна.

/Доорх хүснэгтэн мэдээллээс гутаах, гүтгэх, доромжлохтой холбоотой тайлбарыг харна уу/

¹⁰ Улсын Дээд Шүүхийн 2007.10.29-ний өдрийн 40 дугаартай тайлбарт “... доромжлох ...” гэдэгт нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон ёс суртахууны шаардлагын хэм хэмжээ, үндэсний зан заншил, уламжлалд харшилсан, тухайн хүний нэр төр, алдар хүндийг санаатай гутаасан үйлдлийг хэлнэ. Энэ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, эрүүл мэнд, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, гадна төрх, хөгжлийн бэрхшээлтэй болон гэр бүлийн байдалтай нь холбогдуулан үг, үйлдэл, бичгээр, дохио зангаагаар, зураг дүрсээр гутаасан зэргээр илэрнэ гэж тайлбарласан.

“Худал мэдээлэл тараах” буюу гүтгэх гэмт хэргийн зүйлчлэл

	Зохицуулалт	Тайлбар	Илрэх хэлбэр
Халдлагын зүйл	Хүний нэр төр, алдар хүнд	Бусдаас болон өөртөө өгч буй үнэлэмж	Хүн бүрт харилцан адилгүй, өөр байна.
Зорилго	Гутаах	өш хонзон санах, үзэн ядах, уур хорслоо тайлах, атаархах, эр эмийн хардлага зэрэг атгаг санаагаа хэрэгжүүлэх гэсэн хувийн сэдэлт	Шүүмжлэх үйлдлээс ялгаатай
Үйлдэл	Гүтгэх	тухайн хүний нэр төр, алдар хүндийг санаатай гутаасан үйлдэл	илт худал мэдээллийг олон нийтэд тараасан
	Доромжлох		хүнийг хувийн байдалтай нь холбогдуулан үг, үйлдэл, бичгээр, дохио зангаагаар, зураг дүрсээр гутаасан

Эндээс үзвэл, гүтгэх, гутаах, доромжлох өөр хоорондоо харилцан адилгүй гурван тусдаа үйлдэлд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу худал мэдээлэл тараах гэмт хэрэгт холбогдуулан ял шийтгэл хүлээлгэхгүй байхаар шийдвэрлэсэн нь практикт хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах түүхэн ач холбогдол бүхий шийдвэр болсон гэж дүгнэж болохоор байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг шийдвэрлэсэн Улсын Дээд Шүүхийн тогтоол нь “Гүтгэх”, “Доромжлох” гэмт хэргийн шинжийг агуулсан үйлдэлд гэмт хэрэгт тооцохгүй хэмээн үзсэн нь цаашид хуулийг төсөөтэй байдлаар хэрэглэхгүй байх чухал ач холбогдолтой шийдвэр болсон.
2. “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийн үндсэн шинж болох “илт худал мэдээлэл”-ийг хууль тогтоомжид тайлбарлаагүй, хохирогчийн зүгээс тийнхүү худал мэдээлэл тараахаас сэргийлэх, худал мэдээллийг залруулах хангалттай арга хэмжээ авсан эсэхийг харгалздаггүй, иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу шийдвэрлэж болох иргэний гэм хорын асуудлыг эрүүгийн хуульд оруулсан (гэмт хэрэгт тооцсон) нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хувьд

- ухралт болсон гэж үзэж байна.
3. Эрүүгийн хуулийн “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг Иргэний болон Зөрчлийн тухай хуульд заасан нэр төр гутаах, худал мэдээлэл тараах зэрэг хууль тогтоомж дахь эрх зүйн бусад зөрчлөөс хэрхэн ялгаж тайлбарлах, зөв хэрэглэх талаар Улсын дээд шүүхээс тайлбар гаргах.
 4. УИХ-д өргөн барьсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд “илт худал мэдээлэл”, “ташаа мэдээлэл” гэж ангилан авч үзэж тусгасан нь хуулийг нэгдмэл нэг мөр ойлгож хэрэглэх ач холбогдолтой гэж үзэж байна.
 5. Гүтгэх, доромжлох үйлдлийнхээ төлөө шүүхээс худал мэдээлэл тараах гэмт хэрэгт холбогдуулан ял шийтгэл авсан иргэдийн тухайд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4-т заасан хуулийг илт буруу хэрэглэсний улмаас хүний эрх ноцтой зөрчигдсөн. Үндсэн хуульд заасан шударга шүүхээр шүүлгэх эрх, Монгол улсын Шүүхийн тухай хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хууль дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх, иргэний эрхийг хангах тухайд худал мэдээлэл тараах гэмт хэргийг шийдвэрлэж буй хуулийн байгууллага, төрд итгэх ард иргэдийн буюу хүний эрхийг зөрчсөн ойлголт гэж дүгнэхээр байна.
 6. Эрүүгийн хуульд гэмт хэргийн шинжийг төсөөтэй хэрэглэхийг хориглосон заалтын тухайд. Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 3-д “Энэ хуулийн тусгай ангид заагаагүй үйлдэл, эс үйлдэхүй, хохирол, хор уршиг, гэм буруугийн шинжийг төсөөтэй хэрэглэж гэмт хэрэгт тооцохгүй.” гэсэн заалтыг агуулгаар зөрчсөн ба өмнө нь үйлчилж байсан Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг төсөөтэй хэрэглэсэн байна. Үүнтэй төстэй өмнө нь Эрүүгийн хуульд байсан танхайрах (2002 оны Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйл) гэмт хэргийг “Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах” (Эрүүгийн хуулийн 20.16 дугаар зүйл) гэмт хэрэг гэж зүйлчлэх тохиолдол гарч байсан. Эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцоход өмнө нь шийдвэрлэж байсан гэмт хэргийн шинжийг төсөөтэй хэрэглэх эрсдэл гардаг бөгөөд нь энэ нь хууль хэрэглээний буруу жишиг тогтоох, гэм буруугүй хүнд эрүүгийн хариуцлага оногдуулах зэрэг онцгой үр дагавар үүсгэдэг.
 7. Жишгийн эрх зүйд гол эх сурвалж болох өмнө нь шийдвэрлэж байсан хэргийн жишиг шүүхийн шийдвэр нь Ром Германы эрх зүйн бүлд хууль хэрэглээний тогтсон практик, өмнө үйлчилж байсан гэмт хэргийн албан ёсны тайлбар зэрэгт тусгалаа олох

тохиолдол бий, иймээс өмнө үйлчилж байсан зарим гэмт хэргийн талаар УДШ-ийн тайлбар зэргийг тухайн субъект өөрөө хүчингүй болгож, байнгын зөвтгөл хийж байх.

8. Хуульчийн хэвшмэл хандлагад өмнө нь үйлчилж байсан хуульч хэрэглээний тогтсон мэдлэг, ур чадвар хамаардаг бөгөөд цаашид хуульчийн үргэлжилсэн сургалтад хандлага өөрчлөх, эрх зүйн философи буюу тухайн гэмт хэргийн онол суурь хэрхэн өөрчлөгдсөн тухай сургалтыг заавал төлөвлөн зохион байгуулж байх нь зүйтэй.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх

1. Глоб Интернэшнл төв, “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан-2022-2023” Улаанбаатар хот, 2024 он.
2. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2020.02.13, №07 /1109/
3. Улсын Дээд Шүүхийн тогтоол, Дугаар 2024/ХШТ/110, 2024.10.02
4. https://shuukh.mn/single_case/3628?daterange=2024-10-01%20-%202024-12-31&id=3&court_cat=2&bb=1
5. Л.Галбаатар, “Доромжлох гэмт хэргийг дахин сэргээх нь зөв эсэх асуудал”, Улаанбаатар хот, 2023 он.
6. Нээлттэй нийгэм форум, Судлаач Д.Оросоо, Ц.Цэлмэг, С.Дэнсмаа, Г.Туулнар. “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик”, Улаанбаатар 2021 он.
7. Б.Пүрэвсүрэн, “Эрүүгийн хуулийн Худал мэдээлэл тараах гэмт хэрэгт шийтгүүлсэн анхны тохиолдолд хийсэн дүн шинжилгээ” Улаанбаатар хот, 2020 он.
8. Улсын Дээд Шүүх, Эрүүгийн хуулийн Доромжлох гэмт хэргийг тайлбарласан 2007.10.29-ний өдрийн 40 дугаартай тайлбар
9. УИХ-д 2025.01.23-ний өдөр өргөн барьсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл
10. Шүүхийн ил тод байдал төслийн хүрээнд Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагаас (IDLO) 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр хийсэн сургалтаас
11. 2025.11.01-ний өдөр зохион байгуулагдсан Хэвлэл мэдээллийн эрх зүйн форумд хуульч Д.Оросоогийн тавьсан илтгэлээс

ФЕРНАНДА ПИРИЕ, ЭРХ ЗҮЙН АНТРОПОЛОГИ¹
FERNANDA PIRIE, THE ANTHROPOLOGY OF LAW, 2012ЁС СУРТАХУУНЫ ДЭГ ЖАЯГ: ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛ,
ҮЛГЭР ДУУРАЙЛ

Өмнөх бүлгүүдэд дэлхийн хамгийн боловсронгуй эрх зүйн уламжлалуудыг судалж үзсэн бол одоо овог, тосгоны хуулийн жишээнүүд авч үзье. Энэ нь легализмын ач холбогдол, сэтгэл татам байдлын талаар эргэцүүлэх, олонд танил болсон жишээний онцлог хэв маяг, дадал зуршлыг судлах зорилготой. Хэрэв хуулийг эрх мэдлийн төлөөх хэрэгсэл, эрх мэдлийн төлөөх тэмцлийн стратеги, эсвэл нийгмийн давхаргын үр дүнтэй хэм хэмжээ гэж итгэл төгс тайлбарлаж чадахгүй бол үүнийг өөрөөр хэрхэн ойлгох вэ?

Зарим хууль хамтын нийгэмлэгийн мэдрэмж, дотоод хүмүүсийг гадны хүмүүсээс ялгаж салгах арга барилтай, зарим нь хүчирхэг хөршүүдийн эсрэг бие даасан байдлыг баталгаажуулахтай холбоотой байдаг нь тодорхой. Илүү сайн хууль гаргагчдыг, эсвэл илүү боловсронгуй оюуны сэтгэлгээг дуурайх зэргээр эрх зүйн хэлбэр, тэр ч байтугай дүрэм журмын агуулгыг нутагшуулан авч болно. Ингэснээр хуультай ихээхэн холбогддог эрх мэдлийн харилцааг үгүйсгэх юм уу хайхралгүй орхихгүй. Гэхдээ уг харилцаанд гүйцэтгэдэг үүрэгт ямар нэг онцлог шинж чанар байна. Миний бодож буйгаар энэ онцлог шинж чанар эрх зүйн хэлбэрээр илэрхийлж, эшлэсэнтэй холбоотой: уг эрх зүйн хэлбэрийн идеал ба хүсэл эрмэлзлийг хүрээлэн буй эрх мэдлийн динамик, практиктай хамт судлах ёстой.

ОВОГ, ТОСГОД, ЁС СУРТАХУУНЫ ДЭГ ЖУРАМ

Овгийг харьцангуй тэгш эрхт дотоод харилцаатай, удирдагчид нь төрийн тэргүүнүүдээс илүү даргатай төстэй тусдаа бүлгүүд гэж үзэж болно (Хури ба Костинер 1990). Төвлөрсөн засаглалгүйгээр тэд ерөнхийдөө аливаа хуулийг шууд хэрэгжүүлэх арга хэрэгсэлгүй боловч овгийн хуулийн жишээнүүд байдаг. Ийм хуулиуд нь хууль тогтоомжийн амлаж болох янз

¹ Монголын Криминологичдын холбооноос санаачлан Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Археологи, антроплогийн тэнхим, Монголын Антроплогийн холбоо хамтран хэрэгжүүлж байгаа «Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн хууль зүйн антроплогийн судалгаа» хэмээх төслийн хүрээнд “Fernanda Pirie, The Anthropology of Law, Clarendon Law Series, Oxford university press, 2013” хэмээх номын орчуулгыг цувралаар хүргэж байна. Энэхүү номыг дараах холбоосоор орж үзнэ үү. https://books.google.mn/books?id=SbbDAQAAQBAJ&printsec=frontcover&source=gbs_ge_#v=onepage&q&f=false

бүрийн хэв журмын алсын хараа, дэвшүүлдэг практик зохицуулалтын талаар асуух боломж олгодог.

ЗҮҮН ТӨВД

Төвдийн өндөрлөг нутгийн зүүн хойд хэсэгт орших Амдо гэж нэрлэгддэг өтгөн өвс ургамал бүхий тал нутаг нь хонь, сарлаг хариулдаг малчин овог аймгууд, угсаатан бүхий төвд хүмүүс болон Их хөлгийн буддизмыг дагалдагсдын өлгий нутаг юм. 1958 оноос Хятадын засгийн газар томоохон өөрчлөлтүүд оруулах хүртэл эдгээр овог аймгуудын олонх нь, ялангуяа зүүн өмнөд хэсэгт орших Голок орчимд орших овог аймгууд удам дамжсан эрх баригч гэр бүлүүд болох хомбогийн дор автономит шинжийг хадгалан үлджээ. Тэд чөлөөт холбоо байгуулсан боловч хоорондоо ихээхэн зөрчилдөж, хөршүүдтэйгээ үе үе дайтдаг байв. Голок овог аймгууд хүчирхийллээрээ түүхэнд алдартай байсан бөгөөд энэ алдар цуу хорин нэгдүгээр зууны эхэн үе хүртэл хадгалагдсаар байна (Pirie 2008). Роберт Экваллын 20-р зууны эхэн үеийн тэмдэглэлүүд эдгээр овог аймгуудын хоорондох дайсагнал, эвлэрүүлэн зуучлалын хэв маягийг дүрслэн харуулдаг: овог хоорондын зөрчил гарсан тохиолдолд өндөр статустай зуучлагчдыг, бусад овог аймгуудын дарга нарыг, Буддын шашны лам нарыг, эсвэл нэртэй уран илтгэгчдийг дуудахыг шаарддаг байв. Тэдгээр нь мэтгэлцэх, ятгах, аргадах, нэр төр, хувийн ашиг сонирхлыг нь уриалан дуудах ур чадвараа ашиглан талуудыг хүчирхийллийн оронд нөхөн төлбөр хүлээн авахыг уриалдаг байлаа. (1964: 1140; 1968: 77-80). Маргаан таслагч шийдвэр гаргаж, ял шийтгэл оногдуулах дүрэм журамтай холбоотой асуудал гардаггүй байв: эвлэрүүлэн зуучлал болон тохиролцсон нөхөн төлбөрөөр дамжуулан тохиролцоонд хүрэх л ёстой байсан (1968: 76).

Хорин нэгдүгээр зууны эхээр явагдсан хээрийн судалгааны үеэр Хятадын төр уг тал нутагт засгийн газрын бүтэц, нэгжүүд, зэвсэгт хүчнээ нэвтрүүлж байсан ч гэсэн хэрүүл маргаан, зуучлах үйл ажиллагаа нь Экваллын тодорхойлсонтой ижил зарчмаар үргэлжилсээр байгааг олж мэдсэн юм. Буддын шашны өндөр зэрэг дэвт лам юм уу эрх баригч гэр бүлийн нэрт зуучлагч хөндлөнгөөс оролцож, тохиролцоонд хүргэхгүй бол хэрүүл маргаан хурцадвал хэдэн арван жил үргэлжилж магадгүй юм. Эквалл тодорхойлсны дагуу зуучлах үйл явц нь оролдлогын шинжтэй бөгөөд зуучлагчийн ятгах ур чадвараас хамаарна. Тэд санал болгож буй шийдлээ хүлээн авхуулахын тулд талуудыг айлган сүрдүүлэх эсвэл аргадаж ятгах ёстой, эс тэгвээс эцсийн шийдэл гарахгүй (Pirie 2008). Энэ нь Чзетт (1970)-ийн дундад зууны эхэн үеийн Франц

дахь шүүхийн практик үйл ажиллагааны талаарх тодорхойлолтыг санагдуулах бөгөөд хууль болон хууль ёсны шүүхийн шийдвэрийг эш татахаас илүүтэй бахархал, нэр төрд уриалан дуудсан шинжтэй байлаа.

Тиймээс түүхэн хуулийг өнөөг хүртэл эш татдаг болохыг олж мэдсэн нь ихэд гайхшруулсан юм. Өөр бүтээлд дурдсанчлан (Пири 2009) уг хуулийг тухайн бүс нутгийн түүхийн нэг хэсэг болгон дахин хэвлэсэн.² Үндсэн хэсгүүд нь нэгдүгээрт, дайтахад овог аймгийн удирдагчид хүчээ хэрхэн зохион байгуулах, жанжнаа сонгохыг онцолсон шинжтэй ерөнхий болон чиглүүлэх дүрэм журмууд, хоёрдугаарт, энх тайвныг тогтоох дэлгэрэнгүй, тодорхой заалтууд буюу аллага, гэмтлийн дараа төлөх нөхөн төлбөрийн хэлбэр, хэмжээ болно. Эдгээр хуулиудыг хэрэгжүүлж байсан нь хүртэл төсөөлшгүй зүйл юм. Нөхөн олговрын заалтууд нь хэтэрхий нарийн төвөгтэй бөгөөд заасан хэмжээ нь одоогоор олгосон дүнгээс хамаагүй ихийн сацуу ховор байсан байх бүрэн боломжтой мөнгөн зоос ашиглахыг шаарддаг байж. Түүнээс гадна орчин үеийн сурвалжлагчид ч, тухайн үеийн угсаатны зүйн мэдээллүүд ч зуучлалын үйл явц одоогийнхоос огт өөр хэлбэртэй байсан гэж үздэггүй.

Иймэрхүү үйл явцын талаар урт үг хэлэх явцад шашин шүтлэг, ёс суртахууны зарчим, уламжлалын нэр нөлөөг уриалан дуудахын адилаар дээрх хуулийг ч мөн эш татдаг байсан болов уу. Голокийн ард иргэд өөрсдийн хуулиудыг эртний, өөрчлөгдөшгүй, тусгаар тогтнолын бэлэг тэмдэг хэмээн үздэг байсан гэх түүхэн баримтууд бий. Оросын нэгэн судлаач өөртөө итгэлтэй, сөргөлдөх дуртай омгийн хүний сайрхлыг тэмдэглэн авчээ: Далай Ламын хүлцэнгүй сэдвүүдээс ялгаатай нь тэрээр ‘бид эрт дээр үеэс өөрсдийн хууль тогтоомжийг л дагаж мөрддөг байсан, бидний өөрсдийн итгэл үнэмшлээс бусад нь ... хэзээ ч өөрчлөгдөөгүй’ хэмээсэн байна (Козлофф 1908: 522-28). Тийм бол хуулиудыг баримтлах нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үеэр уран ярианы хэрэгсэл болон ашиглагдаж болох боловч үүнээс илүүтэйгээр уг хуулиуд овгийн нийгмийн үзэл баримтлалын хувьд чухал хэмээн үзэгдсээр ирсэн бололтой. Тэдний онцлог байдал, нөхөн олговрын аргаар тогтоосон нарийн хэмжээ нь дүрмээр тогтолцоо, дэг журмыг бий болгодог гуравдугаар бүлэгт дурдсан хуулиудаас харагдана. Голокийн хувьд эдгээр заалтууд нь нэр төр, өшөө авах, үнэнч байх, гэр бүл, овог аймгийн эв нэгдлийн үзэл санааг ч мөн багтаасан байна. Жишээлбэл, малыг бэлчээрээс бус, хуаран дотроос хулгайлсан тохиолдолд нөхөн олговрын хэмжээг нэмэгдүүлэхээр заажээ. Уг зарчмыг орчин үеийн

² Уг өгүүлийн хэлэлцүүлгийг дараах хэсэгт нэгтгэн дүгнэсэн болно.

эвлэрүүлэн зуучлах ажиллагааны практикт ч мөн анзаарсан юм (2008:227). Хамгийн гол нь эдгээр заалтууд овог аймгуудын эрх баригч гэр бүл болох хомбо нарт үнэнч байх хэрэгтэйг удаа дараа баталдаг.³

Зөрчилдөөн нийтлэг, тодорхой хэмжээнд бишрэгддэг байсан нийгэмд овгийн харилцаа амьдрал дээр үргэлж тогтворгүй байсаар ирсэн. Дайн байлдаан явуулах, энх тайвныг тогтоох зэрэг зарчмуудыг тодорхойлсон бичвэр нь Голок овгийн хүмүүс хэдийгээр хуваагдмал, ихэвчлэн эсрэг тэсрэг боловч ёс суртахууны нэгэн хүрээлэлд багтдаг болохыг харуулж байна. Долдугаар зууны Төвдийн эзэн хаан Сонгцан Гампогийн хуулиудын бичвэрийн оршил хэсгийг эш татсан нь уг хуулийн хүсэл эрмэлзлийн шинж чанарыг бэхжүүлдэг. Сонгцан Гампог Буддын шашныг нэвтрүүлсэн хэмээн Төвдийн бүс нутаг даяар өргөн хүндэтгэдэг бөгөөд Төвдийн хууль тогтоомж түүний бүтээсэн хуулинд үндэслэсэн гэж үздэг. Эдгээр нь Голок хууль зохиогчдод урам зориг өгдөг байсан байх бүрэн боломжтой. Уг хуулийг Сонгцан Гампогийн хууль тогтоомжид үндэслэсэн хэмээдэг бөгөөд дараагаар нь Голок омгийнхон өвөрмөц, хараат бус зүйлс оруулж өгсөн байдаг. Хууль зохиогчид өөрсдийн ёс суртахуун, шашны хувьд эдлэх өндөр нэр нөлөөнд тулгуурлан Буддын соёл иргэншлийн нэг хэсэг болох овог аймгаа төлөөлж, Сонгцан Гампогийн өв залгамжлагчид хэмээгдэн Далай ламын төлөөлсөн түүхэн ёс суртахууны ертөнцөд хамрагдаж байв.

Орчин үеийн хээрийн судалгаагаар уг хууль Голок хүмүүсийн хувьд түүхэн дурсгал бөгөөд овгийн үнэт зүйлсийн мөнхийн бэлгэ тэмдгийн ач холбогдолтой хэвээр байгаа нь тогтоогдсон юм. Уг хуулийн нарийвчлал, оновчтой хэллэгүүд нь үнэнч байдал, өшөө авах зарчмуудыг баталж, үндсэндээ нэгдмэл үнэт зүйлсээс өөр зохицуулалтгүй байсан овгийн харилцааны хэсэгчилсэн зураглалыг гаргаж өгдөг. Эдгээр үнэт зүйлс нь Хятадын төрийн бүтцийн нөлөөнд л автсанаас бус орчин үеийн ертөнцөд ч дагаж мөрдөгдсөн хэвээр байна. Зохицуулалт агуулаагүй боловч түүхэн уламжлалаар зөвшөөрөгдсөн шашин, ёс суртахууны зарчмууд дээр үндэслэсэн овгийн нийгмийн байгууллын хүсэл эрмэлзэл, туйлын зорилгыг илэрхийлсэн гэж хэлж болохоор юм.

³ Сонирхолтой нь тэд дайны кампанит ажилд оруулах хувь нэмэр, гэмтлийн хохирогчид төлөх нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлохын тулд нийгмийн статусыг - өндөр, дунд, доод түвшинг олон удаа дурдсан байдаг. Ийм статусын ялгааг бодит байдал дээр хомбогийн жижиг ангиас доош тэмдэглэж байсан тухай нотолгоо байхгүй байна. Зэрэг цол, статусыг тодорхойлох нь Англо-Саксон болон эртний Ирландын хууль тогтоомжийн онцлог шинж байсан бол овгийн нийгэмд энэ нь тийм ч түгээмэл биш юм.

ОВГИЙН ИЕМЭН

Паул Дреш (2006) -ийн судалсан өөр нэгэн багц хууль Йемений хойд хэсэгт орших Баратын овгуудаас олдсон байдаг. Уг хуулиуд үүссэн 18-р зууны сүүл үед Касими улс аль хэдийн байгуулагдсан байсан боловч Барат нь үндсэндээ захирагчдынхаа хяналтаас гадуур оршин тогтнож байв (2006: 60-63).⁴ Ерөнхийдөө овог аймгуудын хоорондын харилцаа зөрчилдөөн, хүчирхийллээр тодорхойлогдсон, тогтворгүй, тодорхой бус байсан боловч нэр төр, өшөө авалт, хамгаалалт, баталгаа, нөхөн олговрын зарчмууд уг харилцааг хэлбэржүүлж байсан хэмээн дээрх баримт бичгүүдэд тусгажээ. Дрешийн тодорхойлсноор (2006: 6-7) Арабын ертөнц даяар хамгаалалт, нөхөн олговор, тохиролцооны хэлбэртэй холбоотой зарчмууд давтагддаг бөгөөд үүнийг ерөнхийдөө зан заншил буюу үрфтэй холбон тайлбарладаг. Овог аймгууд нь бусдаас ялгардаг - боол, зарц, эмэгтэй, насанд хүрээгүй хүмүүс бол хамааралтай, хамгаалалтад байх, 'үнэ төлбөргүй' (2006: 35) хүмүүс бөгөөд тэдний дунд зөрчлийг өс хонзон, нөхөн төлбөрөөр шийддэг. Нөхөн төлбөрийн албан ёсны хэмжээ нь Баратын баримт бичигт байхтай адилаар тэгш байдлын утга санаа илэрхийлдэг (2006: 8-9). Хамгаалалт, баталгааны тохиролцоо болон туршлагауд тэгш бус харилцаа үүсгэх магадлалтай боловч үүнийг буцаан залруулах боломжтой байсан; аливаа хүн хамгаалагч, хамгаалуулагчийн аль аль нь байх бололцоотой. Төр хууль ёсны эрх мэдлийн дангаар ноёрхох эрхийг тогтоож, эрх баригчдад дуулгавартай байхыг шаардахын сацуу овог аймгууд хооронд шаталсан бус тэгш хэмт харилцаанд суурилсан өөр ёс журам баримталж байсан (2006: 70-72).

Дрешийн тодорхойлсноор Барат хуулинд гарын үсэг зурагсад тархай бутархай, олон янзын хүмүүсээс бүрдэж байсан бөгөөд уг хууль гарын үсэг зурсан хүмүүсийн үүрэг хариуцлагыг тодорхойлж, нөхөрлөлийн юм уу ахан дүүсийн гэрээний шинжтэй байв (2006: 2). Тэд өшөө авах хэлбэрийн хязгаарыг тогтоож, гэмтэж бэртсэн, нас барсан тохиолдолд төлөх нөхөн төлбөрийн төрлүүд, эвлэрлийн гэрээ байгуулах, ял эдлэхээс зугатаж буй этгээдэд зохих хоргодох байр олгох нөхцөл байдлын талаар нарийвчилсан зохицуулалтуудыг багтаасан. Үйлдэл нь ичгүүр, гутамшиг, эсвэл зүгээр л эд хөрөнгийн хохирол учруулсан эсэхээс хамаарч гэм бурууг нөхөн төлүүлэхтэй холбоотой шууд зарчмуудад үл хамаарах зүйл заалт бүхий нэмэлт дүрмийг дагаж мөрддөг байв

⁴ *Үнэн хэрэгтээ Барат нь Йемен болон түүний ойролцоо нутгуудаас экологийн хувьд хараат байсан тул бүхэлдээ тусгаарлагдаагүй байсан бөгөөд нүүдэлчин, суурин оршин суугчдын холимог омгийн хүмүүс өргөн тархсан байв; гэсэн хэдий ч овог аймгийн баримт бичгүүдэд Барат, Йемен хоёрыг газарзүйн хувьд нэлээд тусдаа байсан юм шиг тэмдэглэдэг.*

(2006: 119-21). Иймээс эвлэрлийн харилцаа, баталгаа, үргэлжилсэн хөндлөнгийн шүүхээр маргаан шийдвэрлэх харилцаа нь овог аймгууд болон тэдгээрийн хэсгүүдийн хооронд холбоо үүсгэж байв (2006: 98).

Баратын баримт бичгүүдийн гол зарчим нь хувийн хамгаалалт болон түүнийг хангах гэр бүл, овог аймаг, тэдгээрийн хэсгийн хамтын үүрэг хариуцлага байв, - Уг хамгаалалтыг овгийн бүрэн статустай хүмүүст санал болгож байв (2006: 75–77). Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн нэгэн адилаар зочид, аяллын хамтрагчид, дүрвэгсдийг мөн хамгаалдаг байв (2006: 82). Хуулийн дагуу зах зээлийг мөн хамгаалж байв. Овгийн үйл ажиллагааны цөм болохын хувьд нийтийн зах чухал байв: энэ нь хүчирхийллийг хориглосон, хамтын асуудлаар гэрээ хэлэлцээр байгуулж, олон нийтэд зарлан тунхаглах ёстой цор ганц дундын орон зай байв. Үүнийг хамгаалах нь овог аймгууд болон тэдгээрийн хэсгүүдийн эв нэгдлийг хадгалах хэрэгсэл байлаа (2006: 25-26). Хүчирхийлэл нь нийтлэг байдлын үнэт зүйлсийг үгүйсгэдэг бол хуулийн дагуу захыг ариун орон зай хэмээн үздэг байв.⁵

Гэрээ нь гарын үсэг зурагчдаас ёс суртахууны уялдаа холбоог шаарддаг нь үр дүнтэй байж, хүн тус бүр бусдын эрх юу болох, тэдгээрийг хэрхэн хүлээн зөвшөөрөх ёстойг зөвшөөрч байсан (2006: 124). Бодит байдал дээр гарын үсэг зурсан талууд өшөө авахын төлөөх нэгдмэл нэгдэл болж, хамтын өр төлбөрт хувь нэмэр оруулах үүрэг хүлээж байв, Үүнээс татгалзах нь хамгаалалтын эрхээ алдахад хүргэдэг байлаа (2006: 126). Энэ нь болзолгүй эв санааны нэгдлийг бус ёс суртахууны тэнцвэрт байдлыг илэрхийлж, овог аймгийн ялгарлаар илэрхийлэгдэх бөгөөд тус бүр нь бусад овог, хэсгийн эсрэг нэр хүндээ хадгалж үлдэх ёстой байв (2006: 129). Гэрээ нь удам угсаа, нэгэн өвөг дээдсээс гаралтай байж, хамтран оршин суух үүргээс хальсан бие хүний мэдрэмж үүсгэсэн байж болох юм; энэ нь ‘шинэчлэгдсэн’ ангилал, тодорхойлолтыг нийтээрээ хүлээн зөвшөөрсөн болохыг илэрхийлж байсан (2006: 132-33). Ийнхүү овгийн хүмүүс Дрешийн тодорхойлсноор (2006: 289–90) хуулийн нийгэмлэг гэх зүйлийг бий болгосон хууль, гэрээ хэлэлцээрүүд нь хараат хүмүүсээс бусад хүмүүст ёс суртахууны хувьд харилцан бие биеэ хүлээн зөвшөөрч амьдрах боломж олгодог байв.

Эдгээр бичвэрийг Ромын номлол, нийтлэг эрх зүйн шүүхийн шийдвэрийн хэв маягт нийцүүлээгүй. Хэдий тийм ч тэд хүн хэзээ эрх эдэлж, нөхдөөсөө тусламж хүсч болох вэ гэдгийг легалистик хэллэгээр тодорхойлсон. Дрешийн (2006: 295) тодорхойлсноор улс төрийн

⁵ Энэ нь Дуркгеймийн (1912) ариун дагшин орон зайн тухай ойлголт, түүний дагалдагчдыг нэгэн ёс суртахууны нийгэмд нэгтгэдэг итгэл үнэмшил, зан үйлээр тэмдэглэснийг санагдуулна.

байгууллагагүйгээр, нэг гэрээнд 150 хүн гарын үсэг зураагүй бол тэдгээрийн дүрэм журмыг хэрэгжүүлэх төвлөрсөн эрх мэдэл үүсдэггүй байв. Үнэн хэрэгтээ хууль, гэрээ нь ерөнхий дэг журам тогтоохгүйгээр нөхөн төлбөр, баталгаа, хамгааллын талаарх олон бодит шийдвэрийг илэрхийлж байв. Түүний хэлснээр статистик эсвэл захиргааны зүй тогтлын дараалал бус харин ангилал, тодорхойлолтын дараалалтай байв. Голок хуулийн талаар мөн ижил зүйлийг хэлж болно. Баратын нэгэн адил хойшлуулах, зуучлах явдал нь маргааны хэв маягийг эмх замбараагүй болгож, хэрүүл маргаан дэгдэх үеэр тэмцэгчдэд саад учруулах магадлал бүхий хөршүүд зайгаа барьдаг байв. Гэхдээ Дрешийн (2006: 295-97) хэлсэнчлэн хуулиар төлөөлүүлсэн ‘зан заншил’ шударга зохицуулалт гэж үнэлэгдэж байв. Энх тайван байдлыг шударга ёсны үр дүнд бий болгодог гэсэн ерөнхий санаа байсан боловч үүнийг хангах хамтын арга хэрэгсэл байхгүй байв. Тиймээс хуулиуд нь тодорхойгүй ертөнцийн хувьд ёс суртахууны алсын харааг бий болгодог бөгөөд улс төрийн гэхээсээ илүү ёс суртахууны шинж чанартай холбогддог. Бусад хууль, Европын эртний хуулиуд, Ирландын эртний хуулиуд, эсвэл бүх зүйлийг зохицуулах зорилготой Исландын гар бичмэлүүдийн адилаар Түвд, Йемений хуулиуд нь ёс суртахууны хувьд дүрэм журмаар зохицуулагддаг байсан нь эсрэг тэсрэг омгийн харилцаанд илэрдэг хоёрдмол байдлыг тайлбарладаг. Зүгээр л хууль байсан, үргэлж байдаг байсан гэдгийг хүлээн зөвшөөрөх нь хамгийн чухал байв (Дреш 2006: 301).

Хилийн зурвас ба хил хязгаар

Голок хуулийн адил Барат овог аймгуудын хуулиуд улс төрийн байгууллагагүй ертөнцийг бий болгох ёс суртахууны алсын харааг харуулдаг. Барат овгийн хуулиуд нь хязгаарлагдмал бүлгүүдээс бүрдээгүй, бусад овог аймгууд ч хамрагдаж болох нэгдмэл ойлголтоос бүрдсэн хязгааргүй өргөн ёс суртахууны талбартай холбогддог. Дээрх хоёр зохицуулалтын аль аль нь хамгаалагдсан орон зайг бий болгодог: Голокийн малчид ба Йемений захад тодорхой дүрэм журмууд үйлчилдэг нь тэднийг ялгаж салгасан боловч энэ нь газар нутаг, цаг хугацааны хувьд тогтоогдоогүй болно.

Роберт Томсон Армены хууль тогтоомжийг судалснаар хууль, чухамдаа хууль тогтоох үйл ажиллагаа нь улс төрийн хувьд тархай бутархай хүмүүсийн дунд үндсэрхэг үзлийг бий болгосон арга замыг дүрслэн өгүүлсэн. XI зууны үед Селжүкийн довтолгоонд Армен ноёд улс төрийн хяналтаа алдаж, хүн амын дийлэнх нь Лалын эмирүүдийн хяналтад орсон байв. Тэдний шашны удирдагчид өөрсдийн хуульгүй, маргааныг Лалын шүүхээр шийдвэрлүүлж, улмаар Арменчууд Исламын хууль

тогтоомжид захирагдаж байгаад санаа зовниж байв. Армен тахилч, багш Мхитар Гош арменчуудад үл итгэгчдийн шүүхээс зайлсхийх боломж олгох зорилгоор Армений зан үйлд илт үндэслэсэн хуулийн эмхтгэл гаргасан. Номтой байх нь тэдэнд ямар нэгэн нөхцөл байдалд тохирсон зөв хуулийг эргэн санах боломжийг олгож, гадаадынханд ‘бид хууль тогтоомжийн дагуу амьдардаг тул тэд биднийг дахиж зэмлэх учиргүй гэдгийг илэрхийлнэ хэмээжээ (2000: 22). Чухамдаа түүний хуулийн эмхтгэлийн агуулгыг Хуучин Гэрээнээс, Армен Канонагиркийн канонуудаас, мөн XII зууны эхэн үеийн шийтгэлийн тухай хуулиас авсан боловч нутгийн зан заншлыг тусгах эсвэл каноникийн заалтыг өөрчлөх зорилгоор зарим нэг нэмэлт материал оруулсан байдаг.

Сүсэг бишрэлийн асуудал нь бичигдмэл хуулиас дээгүүрт тавигдах ёстой гэж тайлбарласан (2000: 34) бөгөөд зөвхөн удирдамж санал болгож байгаагаа хэд хэдэн удаа онцолж, шийтгэл ногдуулалтын нэгэн адил наманчлалын талаар авч үзэж байв. Уг бичвэрийг хуулийн эмхтгэл болгон танилцуулаагүй бөгөөд түүний зохицуулалтууд эртний зан заншлын хянан засварлалт, практик үйл ажиллагааны цогц удирдамжийн аль аль нь биш байлаа. Хэдий тийм ч энэ нь арменчуудыг лалын шашны шүүхэд татагдахаас зайлсхийх боломжийг олгох ёстой байв. Дараачийн зууны туршид уг хуулийн эмхтгэлийг өөрчилж, хялбарчилж, илүү системчилсэн байдлаар зохион байгуулснаар (Кови 1997: 299-300) XVI зууны Польшид армен нийгэмлэгүүдээр батлагджээ. Худалдаачдын хооронд үүссэн маргааныг нутгийн шүүгч Армен ахмадуудын хамт сууж, Мхитарын хуулинд үндэслэн (Кови 1997) хянан шийдвэрлэдэг байлаа. Урьдчилан боловсруулсан хуулийн эмхтгэл нь практикийн болон бэлгэдлийн шинжтэй байсан тул тархай бутархай ард түмний хууль, үндэстний мөнхийн тэмдэг болсон юм.

Орчин үеийн хууль тогтоомжийг нутаг дэвсгэртэй холбох нь бусад хэлбэрийн хуулийн талаарх бидний ойлголт, тайлбарыг тодорхойлж болохгүй. Хууль ёсны дэг журам ба ёс суртахууны нийгэмлэг нь тухайн нутаг дэвсгэр дээр, улс төрийн ямар ч хэлбэрийн дэг журам, тэр ч байтугай тодорхой зааглагдсан нийгмийн нийгэмлэгт цэгцтэй зураглал болдоггүй. Дундад зууны Орос улсад Франклин (2007) давхардсан эрх зүйн, улс төрийн, худалдааны болон шашны бүлгүүдийг дүрсэлсэн байдаг. Түүний тодорхойлсноор 1300 оноос өмнө нэгдмэл төрийн байгууламж гэж байгаагүй боловч хунтайжийн эзэмшил нутаг, хүн амын олон янз байдал нь орон нутгийн шатлал, бүс нутгийн ялгавартай байдлын дагуу ялгагддаг байв. Хуулийн эмхтгэлүүдийг Византиас оруулан ирж, сүмийн славян хэл рүү хөрвүүлсэн бол бусад баримт бичгүүдийг зүүн славян хэлээр бичсэн боловч тухайн бүс нутгийн эрх зүйн нарийн төвөгтэй байдал нь эдгээр ангиллаас

хавьгүй давж гарсан байлаа. Франклин оросуудын тухайн үед хүлээн зөвшөөрсөн гурван эрх мэдлийн эх үүсвэртэй холбоотой гурван төрлийн хуулийг ялгаж авч үздэг. Үүнд: ‘правда’ (орос. үнэн)-н эх сурвалж болох төрийн байгууламж, ‘обычай’ (орос. дэг жаяг)-н эх сурвалж болох нийгэм, ‘закон’ (орос. хууль)-ы эх сурвалж сүм хийд буюу бурханлаг чанар.⁶ Түүний санал болгосноор эрт үеийн эрх зүйн түүхийг тэдгээрийн хоорондох өөрчлөлтийн тохиргооны үүднээс авч үзэх хэрэгтэй (2007: 71). ‘Тэргүүн зэргийн Шастирын’ нэгэн адил өргөн цар хүрээтэй эрх зүйн баримт бичигт гурвууланг нь хүлээн зөвшөөрч болох бөгөөд Христэд итгэгчид нэг ‘закон’-той.

Түүний хэлснээр энэхүү олон тооны дүрэм журмууд нь олон тооны нийгмийн тохиргоо, холбоодтой холбоотой байж болох юм: орчуулсан хуулийн эмхтгэлүүд, захирагчийн дүрмүүд, бишопуудын практик асуултанд өгсөн хариултууд, худалдаачдын хоорондын харилцааг зохицуулсан журмууд, Византи болон бусад гадаад худалдааны түншүүдтэй байгуулсан гэрээнүүд, сүм хийдийн амьдралыг зохицуулсан дүрмүүд, Смоленскийн бишопын үүсгэн байгуулах баримт бичиг, эсвэл Новгород ба түүний хунтайж нарын хооронд байгуулсан гэрээнүүд. Ийм хууль, дүрмүүд нь ихэвчлэн ялгаатай, хааяа нэг давхацдаг, эсвэл хоорондоо зөрчилддөг байсан боловч тэдгээрийн хооронд шатлал байсангүй. Франклины дурдсанаар тэд нэг тогтолцооны хэсгийг бүрдүүлж байгаагүй бөгөөд бид өөрийн гэсэн дүрэм журамтай, салангид нийгэмлэгийн энгийн загвараар бодох ёсгүй. Жишээлбэл, ‘Русская правда’ (орос. Оросын үнэн)-ийн дүрэм журмууд нь эхэндээ хунтайжийн эргэн тойронд байсан хүмүүст оногдуулсан шийтгэлийн хэмжээнээс хэтэрдэггүй байсан боловч хожим нь зах зээл, хот суурин газрын оршин суугчид, тэдний солилцоо, мөнгө зээлэх харилцааг зохицуулах зорилгоор өргөжсөн. Хунтайж нар өөрсдийгөө бусдын удирдаж байсан дүрмийн тогтолцоотой холбож, хамтын нийгэмлэгийнхээ хамрах хүрээг өргөжүүлсэн: тэд тодорхой зан үйлийн эрх мэдлийг сүмд хуваарилж, Русь дахь гадаад худалдаачдын хоорондын маргааныг нийгэм өөрөө шийдвэрлэх ёстой хэмээн шаардаж байв.⁷ Үүний зэрэгцээ сүм хийдийн дүрмийг шинэ институтууд даган мөрдөж, худалдааны гэрээ нь - Йемений овгийн дүрэм журмын адилаар - гишүүнчлэлийн өөрсдийн нөхцөлийг тодорхойлж, шашны канонууд бишоп эсвэл санваартны гарт янз бүрийн эрх мэдэл эдэлж, худалдаачдын үйл ажиллагаа худалдааны гэрээ,

⁶ Франклин (2007: 70) тайлбарласнаар энэ хугацаанд ‘правда’ нь улс төрөөс үүдэлтэй дүрмийг бүдэг бадаг тэмдэглэсэн; ‘обычай’ нь хамтын нийгэмлэгээс үүдэлтэй дүрмүүд байв; ‘закон’ бол бурхан шүтээнээс зөвшөөрөгдсөн дүрмүүд байв.

⁷ Даймонд (1973: 324-25) тодорхойлсноор өргөн их хүсэл эрмэлзэлтэй захирагчид тушаахын төлөө ихэвчлэн зөвшөөрдөг байлаа.

хунтайжийн хуульд нэгэн зэрэг хамрагдах боломжтой байв. Франклин (2007: 77) үүнийг Русийн эхэн үеийн хууль олон янзын, давхцсан, огтлолцсон, ерөнхийдөө өргөжсөн бичвэрийн бүлгүүдэд үйлчилдэг хэмээн нэгтгэн дүгнэжээ.

Тиймээс хууль тогтоомж нь тухайн нутаг дэвсгэр дээр үргэлж цэгцтэй буудаггүй бөгөөд тогтоосон орон зайд нийгмийн харилцааг зохицуулахтай үргэлж холбогдоод байдаггүй. Хууль олон улсын хууль тогтоомж хэлбэрээр үндэсний хил хязгаараас давж тэлэх нь, эсвэл орчин үеийн *ius gentium*-ийн санаа нь гайхмаар, үл нийцэх зүйл биш юм (Валдрон 2012). Эдгээр нь наймдугаар бүлгийн цаашдын хэлэлцүүлгийн сэдэв болно. Энэхүү агуулгын хүрээнд бид Ромын *ius civile* бол анхандаа Ромын хувийн эрх зүй, Ромын иргэдийн өмч байсан бөгөөд энэ нь перегринүүдийн нийтлэг *ius gentium*-ээс ялгаатай байсан гэдгийг эргэн санах боломжтой. Эдгээрийн аль нь ч нутаг дэвсгэрийн хувьд тодорхойлогдоогүй бөгөөд Ромын иргэд Грек иргэдийн адилаар хуулиа харьяа нутгуудад хувийн давуу эрх маягаар нэвтрүүлсэн байдаг (Модрежевски 2005; Руппрехт 2005; Кантор 2012). Ромын дараах Европт л хувийн хуулиас нутаг дэвсгэрийн хууль руу шилжих ерөнхий өөрчлөлт гарсан (Ватсон 1985: 28); энэ нь зөвхөн XIX зуунд хууль ба төрт улс хоорондын ижилслээр бүрэн үр дүнд хүрсэн юм.

Хуулиуд нь олон тооны практик, бэлгэдлийн арга хэлбэрээр ашиг тустай байж, олон нийтэд үйлчилдэг дүрэм журам, стандартыг тогтоож, гэмт хэрэг, шийтгэл, зуучлах хэлбэрийг тодорхойлж, эрх мэдэл бий болгох, өргөжүүлэхийг эрмэлзэж, соёл иргэншил болон шашны тогтсон хүрээнд дэх оролцоог илтгэдэг. Олон ургалч үзэл баримтлалын дагуу дүгнэхээс илүүтэйгээр тэдний бий болгож буй ёс суртахууны ертөнц, бий болгохыг зорьж буй нийгмийн харилцааны талаар эргэцүүлэх хэрэгтэй юм.

ТОСГОНЫ НИЙГЭМЛЭГҮҮД

Хөдөө аж ахуйн тосгонд нүүдэлчин омог эсвэл тархай бутархай үндэстнээс ялгаатай нь хууль биет хил хязгаарын мэдрэмжтэй илүү тодорхой холбоотой байх боломжтой. Гэхдээ энд ч гэсэн хуулийн эмхтгэлүүд хүсэл эрмэлзэл, илэрхийллийн шинж чанартай байж болох бөгөөд утга, ач холбогдол нь практик эсвэл зохицуулалтын чиг үүргээ алдаагүй. Газар дундын тэнгисийн хоёр талын аль алин дээр явуулсан кэйс судалгааг жишээ болгон авч үзэх боломжтой.

Шийл (2008)-ийн олж судалснаар Алжирийн зүүн хойд хэсгийн бербер хэлээр ярьдаг Кабылия тосгоны хуулийн эмхтгэл үндсэндээ гадны хүмүүсийн эсрэг нийгэмлэгийг тодорхойлдог. Өмнө нь яригдсан омгийн хуулийн эмхтгэлийн нэгэн адилаар эдгээр нь орон нутгийн зохицуулалтын хэрэгслийн хувьд хэрэгжихгүй байсан боловч шударга

ёс, олон нийт, нийтийн орон зайн талаарх Кабылийн нийтлэг үзэл бодлын талаарх ойлголтыг өгдөг (2008: 898-201). Эдгээр нь шийтгэл, төлбөрийн жагсаалтыг агуулдаг бөгөөд дийлэнх хэсэг нь тосгонд хамтын үйл ажиллагаа явуулж, тосгоны чуулган болон тэдний төлөөлөгчдөд хүндэтгэл үзүүлж, албан тушаалтнуудын үйл ажиллагаанд санал дэвшүүлэхийг эрмэлздэг; дотоод зөрчилдөөнийг дарахыг эрэлхийлсэн хэсэг бас бий; хувийн зарлага зохицуулдаг хууль, инж, гэрлэлтийн зардал, гэр бүлийн бусад асуудлыг зохицуулах заалтууд байв; зарим нь тосгоны чуулганыг амьдралын мөчлөгийн зан үйлд хамруулахыг авч үзэж байсан бол бусад нь үл таних хүмүүст газар худалдах, гадныхантай харилцах харилцааг зохицуулдаг байв. Шийл (2008: 907) хууль тогтоомжийн нарийн төвөгтэй байдал, хийсвэр ангиллыг онцолсон нь оршин суугчид бие биенээ таньдаг, маргааныг хэлэлцээрээр шийдвэрлэж байсан тосгонд тохирохгүй байж магадгүй хэмээжээ. Исландын болон бусад эртний хуулиудын нарийн төвөгтэй байдлыг эргэн санагдуулсан мөнгөний нарийвчилсан зохицуулалтууд бас байв.

Уг хуулиудын хамгаалалт, нөхөн төлбөр, зөрчлийг нэр төр гутаасны хор уршиг, эд материалын хохирол, асрамжид байгаа хүмүүсийн хариуцлага, нийтийн баталгааны талаарх ойлголт нь Ойрхи Дорнод ба Хойд Африкийн бусад газрынхтай төстэй байв (2008: 914). Гэсэн хэдий ч Йемен овгийн баримт бичгүүдээс ялгаатай нь Кабылийн хууль тус бүр нь хүрээлэн буй орчноосоо ухамсартайгаар тусгаарлагдсан, нийтийн (тосгон) орон зайг бий болгохыг оролдож байсан мэт байдаг. Жишээлбэл, бэртэл гэмтэл авсан тохиолдолд хохирогчийн хохирлыг барагдуулахын сацуу тосгоны хуралд тодорхой хэмжээний мөнгийг өгөх ёстой байсан нь тосгон болон оршин суугчдын нэр төрд нийтээрээ ач холбогдол өгдөг байсныг харуулж байна. Ийнхүү хуулийн эмхтгэлүүд нь тосгоныг хил орчмын тосгоны хууль, муж улсын хууль эсвэл шариагийн хууль гэх мэт хил хязгаараас гадуур, гаднах ертөнцөөс ангид байх эрх зүйн орон зай, нийгэмлэг болгон тогтоосон. Гэвч зарим хуулийг Бурханы нэрээр тунхаглаж, нутгийн шашны эрдэмтдээс эш татдаг байлаа. Шийл (2008: 901-02) хэлснээр Кабыличууд хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулахыг оролддог хууль ёсны, шударга ёсны янз бүрийн давхаргатай байсан.

Сүүлийн үеийн хуулиуд Алжирын Бүгд Найрамдах Улс болон тосгоны чуулганыг хууль ёсны эх үүсвэр хэмээн нэрлэж болох боловч орчин үеийн исламизм гэх зэрэг ёс суртахууны гаднах тогтолцооны халдлагын эсрэг тосгоны бие даасан байдлыг бататгасан шинжтэй байна. Шийлийн хэлснээр хуулиуд нь нийгэмлэгийг ёс суртахууны хэм хэмжээний шинэ эх сурвалжууд, ялангуяа дайчин Берберизм ба улс төрийн ислам шашинтнуудын өмнө зарлан тунхагладаг. Хэдий тийм ч хуулиуд нь зөвхөн өөрчлөгдөх гэсэн эртний хариу үйлдэл төдий биш бөгөөд эртний түүхэн үе шигээ ёс суртахууны бүрэн эрхт байдлын талаарх орон нутгийн

ойлголтыг авч үздэг (2008: 911-13). Кабылия тосгонд хууль тогтоох үйл ажиллагаа нь практик үйл ажиллагааг дүрслэх эсвэл зохицуулах гэсэн төгс бус, бүтэлгүй оролдлого биш юм. Харин хууль тогтоох үйл ажиллагаа нь ёс суртахууны нийгэмлэг, олон нийт, түүний орон зайг хамгаалах хэрэгцээ, чадавхыг хамгаалах олон нийтийн шаардлагыг бүрдүүлдэг (2008: 914).

Газар дундын тэнгисийн нөгөө талд Испанийн хойд хэсэгт орших тосгод дор хаяж XVI зууны үеэс эхлэлтэй хууль тогтоодог уламжлалтай. Бехар (1986: 5) ийм нэгэн тосгоны угсаатан зүйн судалгаанд ихэвчлэн Ромын хэлбэрүүдээс санаа авсан, хаадын бүтээсэн хуулиудтай зэрэгцэн, өөрөөр хэлбэл эрх зүйн сэтгэлгээний ‘агуу уламжлал’ -тай зэрэгцэн өөрийн хурд, хэмнэлээр урсаж ирсэн нутгийн уламжлалыг тайлбарлажээ. Бичмэл захирамжууд нь бүс нутгийн тосгодод ижил төстэй хэлбэртэй байсан бөгөөд тосгоны иргэдтэй уулзаж, нийтийн ажилд ажиллах хүч өгөхийг шаардсан зохицуулалт агуулсан байдаг. Тэд шашин шүтлэг, ёс суртахууны асуудалд анхаарал хандуулж, оршуулгын ёслол, хүндэтгэлийн масс гэх мэт шашны арга хэмжээнд оролцохыг шаардаж, тэнэмэл ядуусыг орогноулахын тулд ээлжлэн авах үүргийг өрхүүдэд ногдуулж байв (1986: 162 дахь талаас).

Тиймээс Бехарын судалснаар тэд тосгоны зан заншлыг хадгалан үлдэхийн зэрэгцээ ёс суртахууны хэм хэмжээг сахин хамгаалах ухамсартай тохиролцоог төлөөлж байх боломжтой. XX зуунд, 1936 онд иргэний дайн дэгдсэнээс хойш ч гэсэн уг тогтоолуудыг шинэчлэх ажил үргэлжилж, Христийн зан заншилд сүсэглэх юмуу Христийн шашинт хүний мэдрэмжийг агуулдаггүй хүмүүст таниулах зорилгоор ‘илт Христийн шашны эртний зан заншлыг сэргээх гэсэн нийтийн итгэл үнэмшлийг дүрслэх юмуу Арменийн хуулийн эмхтгэлийг давтах байдлаар илэрхийлж байв (1986: 181–82, 280).

Энэ бүс нутагт тосгоны засаг захиргаа тосгоны иргэдийн чуулганы гарт байсан бөгөөд консехо зөвлөл нь тэргүүлэгчгүй төрийн байгууламжийн үүрэг гүйцэтгэж байсан. Бехарын тайлбарласнаар хувь хүмүүст зааврыг албадлагын хүчээр хүлээн зөвшөөрүүлдэг (1986: 7-р бүлэг) уг чуулган нь хуулийн болон ёс суртахууны нөлөөтэй байв. Хэдий тийм ч олон нийтийн үйл ажиллагаа дүрэмтэйгээ тодорхой хэмжээнд уялдаж байв. Хуулиудын цаана шударга ёс, ёс суртахууны үзэл баримтлал, эв нэгдэл, бие даасан байдлын мэдрэмж байсан. Жишээлбэл, тосгод шашны баярын өдрүүдээ өөрсдөө сонгодог байсан нь шашны довтолгооны эсрэг тодорхой бие даасан байдлыг баталж байв. Гэхдээ тосгоныхон яагаад ялангуяа бичиг үсэг тайлагдах чадвар хязгаарлагдмал, тосгод нь нягтлан бодох бүртгэлийн саваа ашиглан нийтийн санд оруулсан мөнгөн дүнгийн тооллого хийдэг байсан эрт цагт хууль санаачлахыг хүссэн юм бол хэмээн Бехар эргэцүүлжээ. Ладахи тосгонд олж мэдсэнээр улс

төрийн болон шашны хяналтын эсрэг бие даасан байдал, ёс суртахууны олон нийтийн мэдрэмжээ бичмэл хууль болон түүнтэй төсөөт зүйлгүй ч байсан хадгалж үлдэх боломжтой (Пири 2006). Үүнээс гадна, Шийл Кабылийн хуулийн эмхтгэлүүдийн тухай тайлбарласнаар бараг хүн бүр бусад бүх хүнийг мэдэж байгаа нөхцөлд хийсвэр ангиллын хувьд томъёолсон дүрмүүд шаардлагагүй байдаг. XIX зуунаас өмнө тосгоны ‘хамгийн сайн, найдвартай зан заншил’ -ыг хадгалахын тулд сэргээсэн хуучин бичвэрүүдээ байнга дахин боловсруулж байсан гэдгийг Бехар олж мэдсэн. Тэрбээр тосгоны оршин суугчид, тэдний тогтоосон дэг жаягийг ‘хүмүүсийн дурсамжид бичигдэн үлдсэн’ зан заншлын дагуу бий болгосон (1986: 277) хэмээжээ. XIX зууны II хагасаас эхлэн бичиг үсэг тайлагдсанаар шинэчлэлийн эргэлт гарсан боловч хуучин баримт бичгүүдийг дахин уншиж, нягтлан шалгаж, шинэчлэх нь голдуу байсан нь илт Христэд итгэгчдийн эртний уламжлалыг идэвхтэй байлгах гэсэн санаатай оролдлого байв.’ (1986: 280).

Угтаа Кастилийн хаад орон нутгийн хэмжээнд батлагдсан хуулиудтай болохыг шахаж шаардсаны хариуд уг тогтоолуудыг гаргасан байх магадлалтай. XIII зууны үеийн өвөг дээдэс нь Ромын хуулийн жишээнд суурилсан Сиегт Партидас нэртэй хуулийн номнууд хэвлүүлж байв (Стэйн 1999: 65-66). Уламжлал ёсоор зөвшөөрөгдсөн ёс заншил нь хууль ёсны хүчин төгөлдөр байх боломжтой гэх үзэл бодлын мөрөөр тариачдын зан заншлыг Европын бусад хэсэгт ‘зан заншлын хууль’ болгон хянан засварлаж байлаа (Бехар 1986: 274-75). Ийнхүү эмхтгэх ажиллагаа нь төр ба нутгийн нэгдлийн хамтын ажиллагааны харилцан үйлчлэлийн хүрээнд явагдаж, нутгийн нэгдэл хуулиа өөрөө боловсруулж, хэрэгжүүлэх бүрэн эрхтэй гэж үзсэн. Гэвч цаг хугацаа өнгөрөх тусам хуулийн эмхтгэлүүдийн хэмжээ томорч, хянахад хүндрэлтэй болсноор, уламжлалын ариун дагшин байдлыг төлөөлж, тосгоны оршин суугчдын мөрдөхийг эрмэлзэж байсан ёс суртахууны хэм хэмжээг илэрхийлж, улс төрчид, лам хуврагуудын ангид ёс суртахууны ертөнцөөс өөрсдийгөө ялгаж салгах болсон нь Бехарын тэмдэглэлээс илт харагдаж байна. Кабылийнхтай нэгэн адилаар энэ хуулиудыг дотоод зохицуулалтын хэрэгслүүдийн нэгэн адил ёс суртахууны нийгэмлэгийн илэрхийлэл хэмээн авч үзэх ёстой юм. Багахан хэмжээний үндсэн хуулиудын нэгэн адил тосгоны хуулиуд нь ислам юм уу христийн ертөнцийн хэсэг болохын хувиар тэдгээрт ёс суртахууны хувьд оролцдог болохоос биш нийгмийн амьдралыг зохион байгуулж, зохицуулж, бие даасан байгууллага гэх нийгмийн статусыг бататгадаггүй бололтой.

Тиймээс уг эрх зүйн хэлбэр нь албадан гүйцэтгэх механизм байхгүй нөхцөлд ч гэсэн хориглож, тусгаж, торгууль болон бусад шийтгэлийг

тусгайлан заах боломжтой. Эвлэрүүлэн зуучлах уламжлалтай, зөрчилдөөнд хувь хүний нэр төр, нөхөн төлбөрийн асуудал гэж ханддаг омгийн хүмүүс ч гэсэн хуулиа бичих боломжтой. Хууль бол зохицуулалтаас илүү их зүйл юм. Тосгон эсвэл овгийн хуулийг зүгээр л ‘бид юу хийх вэ’ гэх илэрхийлэл болгон унших ёсгүй юм; ёс суртахууны хамтын нийгэмлэгийн шаардлага нь шударга ёс, танин мэдэхүйн гүн гүнзгий мэдрэмж, гадаад ертөнцийн эсрэг бие даасан байдлын тунхаглал гэхийн сацуу ёс суртахуун, шашны илүү том үнэт зүйлд чиглэсэн уриалга хэмээн ойлгох хэрэгтэй.

ПРАКТИК, ЁС СУРТАХУУНЫ ДЭГ ЖУРАМ

Нөгөө талаас бид ийм хуулийн эмхэтгэл практик ач холбогдолгүй гэж үзэж болохгүй. Үүний оронд тэдгээрийг өөр өөр аргаар дурдаж, ашиглаж болох бөгөөд орон нутгийн зохицуулалтын стандартыг хангаж, харилцан адилгүй нийгэмлэгүүдийн хоорондох гэрээ, харилцаа холбоог тогтоож, оршин суугчдыг эв нэгдэлтэй, үүрэг хүлээсэн байхыг шаарддаг. Исламын Дагестаны Кемпер бүс нутгаас (2004) XVIII, XIX зууны үеэс буюу Оросын колоничлолын үеэс өмнө байгуулагдсан тосгон, тосгоны холбоотнуудын бий болгосон практик чиг баримжаатай орон нутгийн хуулиудыг олжээ. Ихэнхдээ тухайн бүс нутгийн олон орон нутгийн хэлний аль нэгээр бус араб хэл дээр бичигдсэн текстүүд нь ихэвчлэн адат буюу зан заншлын хууль гэж тодорхойлогддог зүйлийг агуулдаг; олонх нь янз бүрийн тосгод, эсвэл тосгод ба томоохон холбоотнуудын хооронд, эсвэл эдгээрийн аль нэг нь болон тухайн бүс нутагт улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхийг эрмэлзэж байсан хаадын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээр юм.

Эдгээр гэрээнд бичигдсэн адат заалтууд нь хүнийг алах болон хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох, бусдын бие махбодод хор хөнөөл учруулах, гэр бүлийн асуудал, гүтгэлэг, хулгай, галдан шатаах болон бусад байдлаар эд хөрөнгөд хохирол учруулах, өр төлбөр, залилан мэхлэх гэх мэт гэмт хэргүүдийг зохицуулдаг. Энгийн зөрчилд ногдуулдаг хамгийн энгийн торгуулийн зарим нь бодит хэргүүдийн бүртгэл дээр үндэслэсэн байдаг. Эдгээр нь тодорхой хэргүүдийн бүртгэлийг энгийн легализм, өөрөөр хэлбэл ерөнхий нөхцөлт мэдэгдэл болгон хувиргасан үйл явцыг төлөөлдөг байх боломжтой (‘үхэр хулгайлсан хүн ... өгөх ёстой’). Эдгээр баримт бичгүүдийг тосгоны шүүхэд ашиглахаар боловсруулсан бөгөөд Кемперийн хэлснээр ирээдүй хойч үедээ эрх зүйн туршлага дамжуулах хэрэгсэл болж байна (2004: 31-32). Тэд мөн тосгоны улс төрийн байгууллагад нийтийн нөөцийг ашиглах, хамгаалах зэрэг заалтуудыг тусгах хандлагатай байдаг. Олонх нь хоньчид үүргээ биелүүлэхээс татгалзсаны үр дагаврыг авч үздэг. Мөн

шашны үүрэг хэрэгжүүлэхийг эрмэлздэг бөгөөд ингэснээр Испани, Кабыль тосгоны хуулийн агуулгыг олон талаар тусгасан байдаг (2004: 123-24, 145-46). Нөгөө талаар тосгоны нэгдлийн өөр өөр гишүүдийн хооронд байгуулсан гэрээ нь илүү өргөн хүрээтэй байж болох бөгөөд бүс нутгийн түүх, газарзүйн талаарх хүүрнэлүүдийн дунд эрх зүйн дүрэм журмуудыг тэмдэглэж, янз бүрийн тосгон, суурин газруудын хооронд байгуулсан өөр өөр гэрээний талаар мэдээлж, зөрчлүүдийг зохицуулах, бие биенийхээ дайсанд туслахгүй байх хэлэлцээрийг бүртгэдэг (2004: 133-34).

Ийнхүү зарим тохиролцоо нь зарим тосгод дунд нэгдмэл холбоо байгуулах, эсвэл зээлдүүлэгчдэд гишүүдээс хураан авах үйл ажиллагааг хориглох замаар холбоо болон гадны хүмүүстэй харилцах харилцааг зохицуулдаг. Тэд мөн цэргийн батлан хамгаалах, олон нийтийн хамгаалалтыг хангаж, үнэнч байдал, хувийн мэдрэмжийг бэхжүүлдэг. Эдгээр нь олон талаараа Йемений овог аймгуудын байгуулсан гэрээнүүдийг эргэн санагдуулж, хуучин, овогт суурилсан байгууллагыг гэрчилж байх мэт; Кемперийн хэлсэнчлэн хэн нэгэн гэмт хэрэгт буруутгагдахад овгийн үнэнч байдал чухал ач холбогдолтой болсон. Хэдий тийм ч аливаа шүүх ажиллагааны үндсэн эрх мэдэл тосгоны хамт олонд хадгалагдаж байв. Нэг жил үйлчилж, олон нийтийн дэг журмыг хариуцах ахлагч эсвэл удирдагчдыг томилохын тулд бүхэл бүтэн нийгэмлэгээрээ, тодруулбал насанд хүрсэн эрчүүд тогтмол цуглардаг байв (2004: 139-40).⁸ Зэрэгцээ эрх мэдлийн бүтэц нь тосгоны холбоог тодорхойлдог боловч тэд ихэвчлэн хязгаарлагдмал эрх зүйн хариуцлага хүлээдэг байсан бөгөөд гэрээнүүд нь тосгод өөрсдийн эрх зүйн заалтуудыг хэрэгжүүлэхдээ бие даасан эрхтэй болохыг ил тодоор хүлээн зөвшөөрч байв: тосгоны адат нь холбооны адатаас илүү эрх мэдэлтэй байсан (2004: 147, 150).

Кемперийн тодорхойлсноор (2004: 149) эдгээр хэлэлцээрүүд нь олон нийтийн зарчмуудын хүчийг гэрчилж, гишүүдээсээ дайсагнагчдын эсрэг эв санааны нэгдлийг шаардаж, тэр байтугай орон нутгийн язгууртнуудтай дайсагналцаж байгааг илтгэнэ.⁹ Энд нэг асуулт гарч ирж байна. Испанийн тосгодын нэгэн адил Дагестаны тосгоныхон яагаад хуулиа бичих нь зүйтэй гэж үзсэнийг асууж болох юм. Томоохон

⁸ *Жилийн төгсгөлд эдгээр удирдагчид бүрэн эрхийнхээ хугацаа дуусахад Мустанг дахь тосгоны удирдагчид тангараг өргөснийг эргэн санаж, үүргээ зөв гүйцэтгэсэн гэж Куранд тангараг өргөх ёстой байв (Рамбл 2008).*

⁹ *Зарим нь шашны хишгийг захиран зарцуулж, Исламын татварыг цуглуулж тараадаг кадиг байллуулахыг хүлээн зөвшөөрдөг, эсвэл бүр шаарддаг байв. Гэсэн хэдий ч адатыг шариагийн хуулиар солих оролдлогыг эсэргүүцсэн (2004: 144-45).*

нэгжүүдийн хоорондох хэлэлцээрүүд нь бүлгүүдийн хоорондын харилцааг үнэнч байдал, хүчирхийллийн боломжийг хязгаарлах үүднээс тодорхойлдог. Кемпер тосгоны хэргийг, түүний дотор шашны үүргийг зохицуулдаг гэрээг юуны учир орон нутгийн хэлээр бус араб хэлээр бичдэг байсан юм бэ хэмээн эргэцүүлсэн. Хэлэлцээрүүд нь санваартны болон бусад нөлөөллийн эсрэг хараат бус байдал тогтоосон шинжтэй ч гэсэн хууль тогтоомж боловсруулахад үлгэр дуурайл үзүүлсэн Исламын шашин, түүний хэл, бичвэрүүдийн нөлөөг олж мэдэх боломжтой юм.

Кемпер Дагестаны хууль тогтоомжийн идэвхтэй шинж чанар, дүрэм журмын өөрчлөгдөж буй шинж чанарыг онцлон тэмдэглэв. Зөвхөн ховор тохиолдолд гэрээнүүд ‘өвөг дээдсийн’ жишээг дурддаг гэж тэр хэлэв; эртний, өөрчлөгддөггүй хуулийн үзэл суртлыг бид бусад газраас олж мэддэггүй. Адат журмыг хамтын шийдвэрийн сайн дурын үндсэн дээр байгуулсан; эдгээр нь эрх мэдэлтнүүд, ялангуяа язгууртнуудын өрсөлдөөний нэхэмжлэлтэй тулгарах үед бие даасан байдлыг баттай нотолгоо гэж үзэж болно.

Дүрмүүд нь дотоод журмын дагуу хийгдсэн тул Дагестаны тосгоны ахмадууд торгууль ногдуулалтаа зөвтгөх эсвэл дургүйцсэн тосгоныхныг журамд оруулахын тулд ашигладаг байсан байх боломжтой. Тосгоны иргэд Испанийн тосгоны консехо нь өөрсдийн хуульд мөн адил зүйл хийсэн байж магадгүй юм. Гэхдээ ямар ч тохиолдолд дүрэм журам тогтоох нь хуулийн оршин тогтнол, ач холбогдлыг бүрэн хэмжээгээр тооцож чадахгүй. Түвд зуучлагчийн үнэмшилтэй үг хэлэх үеэр тэднийг эрх мэдэл бүхий жишиг хэмээн уран үгсээр иш татсан байх; тэд үнэнч байдал, баталгаа, хамгаалал гэсэн цогц харилцааныхаа хүрээнд Йемен овгийн хүмүүсийн дунд гаргасан практик шийдвэрүүдийг тэмдэглэхэд үйлчилсэн; гэхдээ тэдгээрийн аль нь ч практик утгаараа баталгаатай дэг журамгүй мэт санагдаж байгаа бөгөөд хэрэгжилтийг хангах нотолгоо бараг байхгүй байна. Дрешийн хэлснээр (2006: 296) тэд тогтмол байдлын дарааллыг бус ангиллын дарааллыг авч үздэг. Эсвэл Кабыль тосгоны нэгэн адилаар тосгоны ёс суртахууны үндэс суурийг тодорхойлдог. Хуулиуд нь тоо томшгүй олон янзаар анхаарал татах боломжтой байдаг тул бид антропологичдын үзэж байгаагаар багц хууль практик ач холбогдолтой байхын тулд заавал хэрэгжсэн байх ёстой, эсвэл зохицуулалт, зүй тогтлын зорилго нь ач холбогдлоо алдсан гэж үзэж болохгүй.

Миний авч үзсэн хуулиуд утга төгөлдөр, бэлгэ тэмдэг бүхий байдаг ч эдгээр нь чухам ямар ач холбогдолтой вэ? Тэдгээртэй тодорхой холбогдсон нийгэмлэг төдийлөн байдаггүй. Тэд зан заншил, бурханлаг чанар, сансрын дэг журмын уламжлал, хувиршгүй байдлыг тэр бүр

тусгаад байдаггүй. Голок овгийн хүн Далай Ламын хуулиудтай адил эртний хуультай байсан гэж сайрхаж магадгүй бөгөөд Йемений овог аймгуудын хүмүүс Дрешийн (2006: 301) хэлснээр ‘хуультай байх нь байсан’ гэх ойлголттой байжээ. Хууль тогтоогчид уламжлал, эртний зан заншлын үл нийцлийг эш татах цар хүрээ өмнө тавдугаар бүлэгт дурдсанчлан хувьсаж байдаг. Дагестаны тосгоныхон Испанийн консехо шиг шинэ хуулиудыг шинэчлэн найруулж, боловсруулахад бэлэн байсан бололтой. Шийл (2008) нь Кабилияд хууль тогтоох үйлдэл нь өөрөө чухал ач холбогдолтой байсныг олж тогтоожээ. Зургадугаар бүлэгт дурдсанчлан бичмэл үгийн хүчин чадал мөн адил хувьсах шинж чанартай бөгөөд өөрийн гэсэн ариун дагшин чанарыг олж авсан юмуу эсвэл өөр эртний зүйлээс хагас дутуу эш татсан, үгүй бол энэ хоёрын аль аль нь байх боломжтой.

Үндсэндээ хууль ёс суртахууны хэм хэмжээг бий болгодог. Тэдгээрийг дагалдагчид – тосгоныхон, омгийнхон, тархай бутархай улсын иргэд - баримтлах зарчмын олон нийтийн тунхаглал хэмээн авч үзэх боломжтой. Тиймээс тосгоны хуулиуд нийтийн үйл ажиллагаа болон нөөцөд хувь нэмрээ оруулж, шашны үйл ажиллагаанд оролцохыг шаарддаг. Харин овог аймгийн хувьд үнэнч байдал, хамгаалалтай холбоотой оролцоо нь овгийн гишүүн байна гэж яахыг хэлж байгаа юм бэ гэдгийг тодорхойлж өгдөг. Чухам эдгээр ёс суртахууны хэм хэмжээ нь өөрийн хүнийг гадныхнаас, Голок овог аймгуудыг Далай ламын дэглэмийн хараат бус субъектүүдээс, Йемен овгийнхныг тэдэнтэй харилцан үүрэг хүлээгээгүй хүмүүсээс, Кабылийн тосгоны хүмүүсийг улс төрийн Исламын шашинтнууд ба тэмцэгч Берберизмээс, Испани, Дагестаны тосгоныхныг хөршүүдээс нь, арменчуудыг лалын шашингүй үзэлтнүүдээс ялгаж өгдөг.

Орчин үеийн үндэстний улс орнуудад ‘эрх зүйт ёс’ болон түүнийг сурталчлахад эшлэгддэг ёс суртахууны хэм хэмжээг хооронд нь харьцуулахад тийм ч их уран дүрслэл шаардахгүй. Соёл иргэншлийг хуулиар дамжуулан авчрах санаа нь колончлолын дараах ертөнцөд тэр бүр тодорхой байдаггүй ч ‘бид’ ‘тэднээс’ давуу талтай болохыг бататгах тохиромжтой аргыг бий болгож чаддаг. Их Британийн Ерөнхий сайд Маргарет Тэтчер 1989 онд ‘соёл иргэншилт нийгмийг харгислалаас ялган харуулдаг эрх зүйт ёс’-ыг хадгалах Европын нийтлэг үүрэг хариуцлагыг, мөн ‘Европчууд дэлхийн ихэнх хэсгийг судалж, колоничилж, соёлжуулсан’ нийтлэг өвийг хүлээн зөвшөөрч байв (Фицпатрик 1992: 117). Эрх зүй, хөгжил дэвшил, соёл иргэншлийн далд холбоог нео колоничлолын үйл ажиллагааг зөвтгөх зорилгоор хялбархан ашиглаж болно (Комаров ба Комаров 2006; Маттэй ба Надер 2008; вон

Бенда-Бекманн нарын хамтарсан бүтээл 2009). Фицпатрикийн хэлснээр хууль үндэсний ашиг сонирхлыг ерөнхий ашиг сонирхол болгон хэрэгжүүлдэг; энэ нь өвөрмөц байдлыг агуулж, үндэстний хязгаараас даван харуулдаг. Үнэн, шударга, хүлээн зөвшөөрөгдсөн, бодит байдлын үүднээс дэг журмыг харуулдаг (1992: 165). Эдгээр нь өргөн хүрээтэй нотолгоо боловч алс холын, түүхэн, омгийн жишээнүүд эрх баригч эсвэл олон нийтийн эрх мэдэл, нутаг дэвсгэрээс давсан ёс суртахууны дэг журмыг хууль хэрхэн хэрэглэж буйг тодруулдаг. Тэдгээр нь мөн хууль нутагшуулан авахтай холбоотой үзэгдлийг дүрслэх боломжтой.

НУТАГШУУЛАН АВАХ БОЛОН ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛ

Орчин үеийн эринд колончлолын нөхцөл байдлын адилаар эрх зүйн империализм юуг авч үздэг талаар олон жишээ авах боломжтой бөгөөд үүнд хоёрдугаар бүлэгт авч үзсэн Бентон (2002), Кон (1989), Чанок (1985) нарын бүтээлийг эш татаж болно. Хүмүүс шинэ эрх зүйн орчинд дасан зохицох ёстой гэсэн антропологийн баримт олон байдаг.¹⁰ Сүүлийн үед Надер (2005) ‘хууль нь үзэл баримтлалыг хууль ёсны болгох хэрэгсэл хэвээр байгаа’ хэмээгээд үндэстэн дамнуулж ижилсүүлсний үр дүнд бий болгосон хууль тогтоомжууд буюу ‘хуулийг америкчлах’ ойлголтыг шүүмжилсэн байна (2005: 199, 210). Гэвч давамгайлах загварт хэт хурдан хүрч, улс төр, соёлын хувьд хүчирхэг хүмүүс сул дорой эсвэл дарлагдсан хүмүүсийг албадахыг эрэлхийлэхэд хялбар байдаг. Чанокийн тэмдэглэснээр Африк дахь ‘зан заншлын эрх зүй’ нь колончлолын албадлагын сацуу уугуул элитийн нөлөөнд бүрэлдэн бий болж байв.

Ватсон (2001: 7-р бүлэг) энэ асуудлыг эсрэг талаас нь үр дүнтэйгээр хөндөж, олон нийт яагаад нутагшуулан авсан хуулийг хүлээн зөвшөөрдөг талаар судалсан. Тэрбээр ‘ойлгоход бэрх агуулгыг нутагшуулах нь ихэнх цаг үеийн ихэнх улсуудад өрнөдийн эрх зүй хувьсахад нөлөөлсөн хамгийн чухал хүчин зүйл болсон’ хэмээсэн (2001: 193). Ватсон (1974)-ы ‘хууль нутагшуулан авах’ талаарх бүтээл, эсвэл Валдрон (2012: 203–04)-ы илүү сонирхолтой байдлаар ‘хүний сониуч байдал’ хуулийг нутагшуулан авахад хүргэдэг хэмээн авч үзсэний дараагаар хууль, эрх зүйн хэлбэрийн тархалт, нөлөөний талаар түүхчид ихээр тайлбарлах болсон. Хэдий тийм ч дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүмүүс бие биеэсээ хууль нутагшуулан авах хандлагыг антропологчид судлах нь ховор байжээ.

Энэ бүлэгт хэлэлцсэн ихэнх хуулийг тогтсон, өргөн цар хүрээтэй эрх

¹⁰ Моник Нуитэн (2005)-ий хийсэн нарийвчилсан судалгааг энд үлгэрлэн үзүүлж болох юм.

зүйн уламжлалуудын хүрээнд боловсруулсан байв: Йемен овгийнхон Кабыле, Дагестаны тосгоны оршин суугчдын нэгэн адил Ислам ертөнцийн нэг хэсэг байв; Ромын эрх зүй сэргэж, өмнөд Европ даяар тархсаны дараа Испани тосгод Ромын эрх зүйн нөлөө бүхий хуулиудаа бичиж байв; Голок овгийнхон Төвдийн төв хэсэгт бүрэлдэн бий болсон хуулиудын талаар тодорхой мэддэг байсан; Мхитар каноны хуулиас ихээхэн нутагшуулж авсан; сүмийг өргөтгөснөөр Византийн хуулиудыг орчуулж, Орос улсад нэвтрүүлсэн байна. Эртний Грекийн тухай бас эргэцүүлж болох юм: Томас (2005: 49) нарын цохон тэмдэглэсэнээр Горгинд бичигдсэн Критийн хуулиудыг биширч, дуурайж, бусад газарт өргөн хуулдаг байсан бөгөөд Платон, Аристотель нар хүртэл энэ эрх зүйн уламжлалын ач холбогдлыг дурдаж байв. Хэсэг хугацааны дараа Энэтхэг эрх зүй зүүн өмнөд Азийн нутгаар тархжээ: одоогийн Тайланд, Бирм, Камбож, Явад бий болсон хуулиуд Энэтхэгийн эх бичвэрүүд болон сэтгэмжүүдээс үүдэлтэй.¹¹ Миний VIII бүлэгт тайлбарласнаар, дхарма шаштрууд Тайланд улс кастын систем хөгжүүлээгүй байхад Таммасат гэх Тайландын хуулийн эмхтгэлийн суурийг тавьсан (Хоокер 1978). Хятад улсын хуулийг Японд баталж, тэр нь Солонгост нөлөөтэй байсан бөгөөд Вьетнам ихэнх хэсэгт нь өөрчлөлт оруулалгүйгээр буулган авчээ (Жонсон 1979: 9). Эрх баригчид, эрдэмтэд, жижиг бүлгүүд, овог аймгууд бүгд өөр газраас эрх зүйн хэлбэрийг нутагшуулан авсан байдаг.

Ватсон гол анхаарлаа VI зуунд Гаулд суурьшсан герман овгуудаас эхлээд XVI зууны хүмүүнлэг үзэлтнүүдэд, XVII-XVIII зууны үед учир шалтгааны хуулийг сэргээн дэлгэрүүлж, Европт түгээсэнд хандуулж байв. Дундад зууны Европ дахь Ромын эрх зүйн талаар Виноградов (1961: 11) ‘Германчууд өөрсдийн үндэсний тогтолцоог үндэсний жишиг, өөрсдийн орны шаардлагад нийцүүлэн боловсруулахын оронд түүхэн жишгээсээ гажиж гадаадын эзэнт гүрний эртний сургаалыг буулган авсан нь юунаас эхтэй вэ?’ хэмээн эргэцүүлжээ. Улс төрийн ба соёлын империализм Ромын эрх зүйн дэлгэрэлтийн талаар маш бага тайлбарладаг. Ингэж нутагшуулан авсныг эрх зүйн империализмын нэгэн адил улс төр, соёлын хүсэл эрмэлзлийн үүднээс ойлгох шаардлагатай бөгөөд дараагийн хэсэгт авч үзэх, V-XI зууны хооронд боловсруулсан Германы хуулиудын тухай Вормалд (1999) -ын бүтээлд бичсэн байдаг. Харин хожуу үеийн жишээнүүдэд уг үзэгдлийн өргөн тархсан шинж чанарыг харуулсан: хаад, орчин үеийн улс гүрнүүд хүртэл хуулиа бие биенээсээ нутагшуулан авдаг байдаг.

¹¹ Хаксли (2006)-ийн тайлбарласнаар зүүн өмнөд Ази бичиг үсэгт тайлагдаж эхэлснээр хятадын идеографуудаас илүүтэйгээр Девангари цагаан толгойг нэвтрүүлэх санаатай сонголт хийсэн бөгөөд ингэснээр ойролцоох Хятадын зөөлөн хүчнээс илүү алс холын Энэтхэгтэй эвссэн байна.

ДУНДАД ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН ЕВРОП

Патрик Вормалд (1999) нь дундад зууны эхэн үеийн Европт бий болсон герман хэл дээрх бичвэрүүдийн талаар авч үзсэн. Тэдгээрт илэрхийлэгдсэн сэдэл нь бидний хууль тогтоомжуудаас хүлээх боломжтой зүйлс болох энх тайван, дэг журмыг дэмжиж, шударга бус байдлыг арилгаж, хүнд хэцүү хэргийг шийдвэрлэх явдал юм. Гэвч тэдний агуулгыг шударга ёс, төрийн хэрэгцээтэй холбон тайлбарлахад хэцүү. Тэдгэрийн заалтууд, ялангуяа хойд Европын хууль тогтоомжуудад ихэвчлэн ‘эмх замбараагүй, ‘маш ихээр шилж сонгосон’, ойлгомжгүй байдлаар хасаж танасан байдаг (1999: 11). Ихэнхийг нь нутгийн хүн амын дийлэнхэд танил биш байсан латин хэлээр боловсруулсан; зарим гар бичмэлүүд ямар ч илэрхий зарчим, зохион байгуулалтгүйгээр ял шийтгэлээс ял шийтгэл хүртэл бодлогогүй эргэлдсэн байх юмуу илт зөрчилдөөнтэй байдаг (1999: 14–15). Тиймээс энэ хууль тогтоомжийн ихэнх хэсэг нь ‘шүүх танхимд сууж буй шүүгчдэд үзүүлэх бодит үнэ цэнээс үл хамааран бичмэл хууль тогтоомж шиг харагдах зүйлийг буулгаж тавих л зорилготой байжээ’ гэсэн сэтгэгдэл төрүүлдэг (1999: 13). Хуулийг бодитоор хэрэгжүүлэхэд хаан эсвэл түүний албан тушаалтнуудын үг гол нөлөөтэй хэвээр үлдэж, шударга ёсыг тогтооход эшлэсэн бичиг баримт нь ач холбогдолгүй байв (1999: 23). Вормалд (1999: 18) хэлсэнчлэн бичвэрүүдийг дийлэнхдээ тухайн үед ноёрхож байсан эзэн хаант засаглалууд боловсруулдаг байсан бөгөөд тус хаант засаглалуудын байлдан дагуулал нь тэдэнд эзэнт гүрэн гэдгээ бататгах итгэлийг төрүүлж, энэ нь Ромын хамгийн алдартай ололт болох бичмэл хуулийн уламжлалыг даган дуурайхад нөлөөлсөн: ‘Хууль тогтоомж нь имиж бүрдүүлэхтэй холбоотой асуудал байсан байх боломжтой’ (1999: 25). Хамгийн алдартай нь Чарльмэн Франк ард түмний хуулиуд олон талын дутагдалтай байгааг тунхаглаж, бичигдээгүй хуулиудыг бичиглэхийг тушаажээ. Вормалдын тайлбарласнаар ‘Бичмэл хууль тогтоомж нь Ромын эзэн хааны үүрэг байсан учраас эзэн хааны сүр хүчний илэрхийллийн нэгэн хэсэг байсан.’ (1999: 29-30).

Мөн шашны нөлөөлөлтэй байв. Христийн шашин ном бүхий шашин байж, Библи нь тэнгэрлэг хаант улсын хуулийн ном нь байсан тул бусад хаад хуулиа Пентатех дээр үндэслэнээр өөрсдийгөө Христэд итгэгч удирдагч хэмээн тодорхойлох болмжтой байжээ. Вормалдын үзлээр Моисей, Солон болон бусад Грек, Ромын хууль тогтоогчид бүх ард түмэн өөр өөрийн lex-тэй байх ёстой гэсэн итгэл үнэмшлийг хөгжүүлэхэд нөлөөлсөн (1999: 31-33). Эдгээр хууль нь герман хаад, тэдгээрийн зөвлөхүүд өөрсдийгөө болон ард түмнээ хэрхэн дүрслэхийг

хүсэж байсан, тэр дүрслэлийн нотолгоо болно: ‘Хаан ба ард түмэн нь Ромын эзэн хаадын өв залгамжлагчид, Израилийн үр хүүхдүүдтэй хамтран зүтгэгчид, эсвэл омгийн өнгөрсөн үеийн уламжлалын хүрээнд холбогдсон хүмүүсийн дүр төрхийг бүтээхийг хүсэж байсны нотолгоо юм.’ (1999: 37-41).¹² Хууль нь ёс заншилд үндэслэсэн эсвэл домогт хууль тогтоогчоос үүдэлтэй нийгмийн өөрийгөө тодорхойлох хэрэгсэл байсан бөгөөд нийгэм өөрийгөө тодорхой тогтоосон, захирангуй өнгөрсөн үеийн өв залгамжлагч хэмээн ухамсарлаж байлаа (Кохэн 1993: 5-6).

Энэтхэг, Ром, Ирландад хууль нь мэргэжлийн хуульчдын харамлангуй хамгаалалтад байсан бол энэ цаг үед хууль тогтоох нь хаадын үүрэгт ажил байсан хэмээн Вормалд дүрсэлсэн байдаг. Германы хаадын цэргийн байлдан дагуулал нь мэргэжлийн ангиудын хамтрагчдыг устгаж, хууль журам, дэг журмын үндсэн хариуцлагыг хүлээх, эрх зүйн шинэ чиг үүргийг хэрэгжүүлэх боломжийг олгосон байж магадгүй гэж тэрбээр үзжээ. Хуулийг ихэвчлэн улс төрийн чухал мөчид боловсруулдаг байсан бөгөөд энэ нь зарим талаар эрх баригчид ба тэдний угсаа гарвалд үнэнч байдлыг баталгаажуулах зорилготой байв (1999: 35-37). Хэдий хууль тогтоох үйл ажиллагаа нь захирагчийн гарт байсан ч гэлээ шууд практикийн эсвэл захиргааны зорилготой, мөн үзэл суртлын эсвэл өргөн хүрээнд улс төрийн зорилготой байж болно.

ШАРИАГИЙН ЭРГЭН ТОЙРОНД

Исламын хуулийн түгээмэл шинж чанарыг бүгд мэддэг бөгөөд исламын эрдэмтэд нутгийн нөлөөг олж авсан газар бүрт эрх зүйн хэлбэр, шариагийн зарчмуудыг олох боломжтой. Улс төрийн болон шашны хүчтэй хяналт байхгүй тохиолдолд ийм хэлбэрийг зохих ёсоор нь орон нутгийн асуудал, нөхцөл байдалд нийцүүлэхийг эрэлхийлж магадгүй юм. Гэвч Шийл (2012)-ийн Алжирын баруун өмнөд хэсэгт орших Сахарын баян бүрдүүд болох Товатын судалгаандаа тодорхойлсноор бодит байдал дээр нутагшуулан авах нь функциональ тайлбар хийх оролдлогыг эсэргүүцэж болзошгүй.

Энд нийтийн усжуулалтын цогц систем нь экологийн хувьд нэн чухал юм. Түүхээс харахад төрийн хяналт сул эсвэл огт байхгүй байсан боловч XIX зууны үед үл хөдлөх хөрөнгийн ажил гүйлгээ, усжуулалтын зохион байгуулалттай холбоотой нутгийн хэрэг, баримт бичгийг бүрдүүлэхэд нэлээд ‘хуульчилж’ байв. Эдгээрийн ихэнх нь нутгийн байшингуудад

¹² Зарим эрдэмтэд энэхүү ‘хууль бол утга зохиол’ гэсэн хандлагыг үл тоомсорлож, хуулиудыг илүү практик хэрэглээтэй байлгах хэрэгтэй хэмээн маргадаг (МакКиттерик 1989: 39). Хэдий тийм ч Кохэн (1993: 5-6) -ы тэмдэглэсэнээр хууль тогтоомж нь утга зохиолын төрөл байсан ч гэсэн маш чухал үүрэг гүйцэтгэж байсан.

өлгөөтэй сагсанд дарагдан XXI зуун хүртэл хадгалагдан үлджээ. Баримт бичгүүдэд Исламын шашны эрх зүйн хэлбэр, ангиллыг ихэвчлэн ашигладаг бөгөөд энэ нь нутгийн хэллэгээр практик ач холбогдолгүй мэт санагддаг. Жишээлбэл, тэд цөлжсөн, эсвэл ус зайлуулах сувгаар урсаж байгаа ус нь лаг шавраар дүүрэх бүрэн боломжтой газар нутгийг үл харгалзан хөрөнгийг нарийвчлан тогтоосон байдаг. Бусад баримтжуулсан гүйлгээ нь хөрөнгийг нарийн хуваарилдаг байсан нь илжгийг хэсэгчлэн зарах гэх зэрэг гажиг үүсгэдэг.

Исламын эрх зүйн категориудыг батлах нь тодорхой бодит зорилгогүйгээр ихээхэн зардал, хүчин чармайлт зарцуулсан байх ёстой хэмээн Шийл үзэж байна. Энэ бол Ватсоны хууль ёсны элиттэй ижил төстэй төвлөрсөн муж эсвэл бусад байгууллага байхгүй тохиолдолд эргэлзээ үүсгэнэ. Зарим тохиолдолд Шийлийн тайлбарласнаар (2012: 223-24) бичих чадвар, эрх зүйн баримт бичгийг боловсруулах чадвар нь боловсролтой цөөн хэдэн хүмүүст бусдаас давуу боломж олгодог: Исламын хуулийг ашиглах, хэрэглэх чадвар нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааг удирдах, өмч хөрөнгийг хянах боломж олгоно. Гэхдээ энэ нь Товатын хуулийн нутгийн давж заалдах гомдол, мөн төвийг сахисан шинж чанарыг харгалзан үзэхгүй байна. Ёс суртахууны хэм хэмжээний хувьд үүнийг одоо байгаа эрчим хүчний бүтцийг хадгалах, шалгахын аль алинд нь ашигладаг байсан. Жишээлбэл, нутгийн хөдөлмөрийн гэрээ нь тухайн ажилтанд онцгой таатай нөхцөлийг зааж өгдөг. Бид ногдуулах, хэрэгжүүлэх, эсэргүүцэх загвараас илүүтэй сониучирхах, хүлээн зөвшөөрөх, хэлэлцээр хийхийн хүрээнд эргэцүүлэх хэрэгтэй (2012: 201).

Хуулийн сонирхол татахуйц байдлыг түгээмэл байдал, соёл иргэншлийн шаардлага, хүний төгс төгөлдөр болох гэсэн эрмэлзлээс харж болох юм. Исламын эрх зүйн ангиллыг ашиглана гэдэг нь тухайн нутгийг нийгэм, эдийн засаг, ёс суртахууны хувьд бүхэлд нь тайлбарлана гэсэн үг юм. Бедуча (2000)-ийн тайлбарласнаар Тунис улсад түүнтэй дүйцэхүйц эрх зүйн баримт бичигт усны хэмжээг нарийвчлан дурдаагүй тул дундуур нь улс орохоос сэргийлэн юуг хэмжиж, юуг хянахыг зан заншлын дагуу шийдвэрлэдэг. Үүний эсрэгээр, эдгээр баримт бичгийг бүтээх үед Товатын баянбүрдүүдэд төрийн хяналтын зүгээс аюул заналхийлэл байгаагүй. Тэдний оршин суугчдын гадаад ертөнцтэй харьцах харьцаа нь соёл иргэншил, цөлжилтийн үүднээс боловсруулагдсан байв. Баянбүрдийн амьдрал эмзэг байсан тул цөлийг ёс суртахуун, соёл иргэншил, экологи талаас нь байнга хамгаалж байх ёстой байсан бөгөөд энэ нь тэнгэрлиг хууль, дэг журмыг хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Бурханы зам буюу шариаг дагаж мөрдөх нь өдөр тутмын харилцан үйлчлэлийг

урьд өмнө нь бий болсон бөгөөд дэлхий нийтээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ёс суртахууны хэм хэмжээнүүд дээр загварчилж, гадна талуудтай холбоо тогтоож, байнгын болгохыг хэлдэг байв (2012: 226-27). Эрх зүйн хэлийг ашиглан тухайн нутгийг бүх нийтийн элемент болгон танилцуулж, илүү том бүхэл хэсэг болгон дахин бүтээж; энэ нь тогтвортой, тогтмол, хөдөлшгүй байдал, хүсэл эрмэлзлийг бий болгосон. Аливаа зүйлийг нотлох баримт нь уг газрыг гадна талтай холбож, соёлтой мөн чанарыг нь илтгэдэг учраас сагсанд хадгалсан эрх зүйн баримт бичиг нь үнэ цэнэ багатай байв.

РОМЫН ДАРАА

Ватсоны (1974) анхны ажлын сэдэв болох хожмын дундад зууны Европт хууль нутагшуулан авахтай холбоотой олон жишээ бий. XII зуунаас буюу Болонья дахь эрдэмтэд Ромын эрх зүйг ‘дахин нээсэн’-ээс хойш Юстинианы Дигест болон хуулийн хураангуй (summae), агуулгын тодотголын хамт бүтээж, хуулбарлаж, өргөн хүрээнд тарааж байв (Стейн 1999: 3-р бүлэг). Сумма хувийн баримт бичиг байсан хэдий ч олонд танигдсан тул ихээхэн хэмжээгээр хуулбарлагдсан: жишээлбэл, Ло Коди хэмээх уг хуулийн хураангуй агуулсан бичвэрийг Провенсальд 1149 оны орчимд туурвисан нь дор хаяж таван өөр хэлээр орчуулагдаж, олон тооны зан заншлын эрх зүй, хуулийн бүтээлийн цуглуулгад нөлөөлсөн (Ватсон 1974: 9-р бүлэг).

Ромын (иргэний) эрх зүйг техникийн хувьд давуу байдлаар нь биширдэг байсан бөгөөд Стейн (1999: 61) -ий дэвшүүлсэн саналын дагуу уламжлалт шүүхэд ашиглаж болох түгээмэл дүрмийн нэг хэлбэр болох үзэл баримтлалын хүрээг бий болгосон. XIII зууны үед ийм шүүхээс хэрэгжүүлдэг орон нутгийн буюу ёс заншлын хууль гэж үздэг байсан зүйлийг бичгээр, заримдаа хааны, ялангуяа Сицилийн эзэн хаан II Фредерикийн санаачилгаар, мөн Филипп де Бомануар, Боваисис дахь граф Клармонтын шүүхийн шүүгч Бомануар гэх мэт хувийн хүмүүсийн санаачилгаар гаргаж эхэлсэн. Энэ хоёр тохиолдолд хоёуланд нь иргэний хуулиар зохион байгуулалтын ангилал, зарчмуудыг тусгаж өгсөн. Стейн (1999: 64) -ий хэлснээр Ромын эрх зүйг нэмэрлээгүй хаант улс эсвэл бүс нутгийн хууль бүрэн хүчин төгөлдөр бус болно.

Чейетт (1970) энэ үеэрх шинэ хуулиудын үүслийг ойлгохыг эрэлхийлэхдээ Ромын сүнслэг нөлөөнд хэт их ач холбогдол өгөх ёсгүй гэдгийг сануулдаг: Ромын хуулиудыг эрдэмтэд хуулбарлаж, судлаад зогсохгүй мөн нутгийн орчин, шүүх хуралдааны танхимд яагаад нэвтрэх болсныг бид эргэцүүлэх хэрэгтэй. Эстер Кохэний хийсэн судалгаагаар (1993) Ромын нөлөө хүчтэй хэвээр үлдээгүй Хойд Европт XII зууны

үед эрх зүйн практик үйл ажиллагаа үндсэндээ аман хэлбэртэй болсныг тайлбарласан; энэ нь хамтын зорилгыг батлах боломжтой олон нийтийн үйл ажиллагааны асуудал байсан. Бичвэр нь хуулийн амин сүнс биш харин үг үсгийг илэрхийлж байсан бөгөөд нийтийн эрх зүйн мэдрэмжийн амьд, аман илэрхийллээс доогуур ач холбогдолтой байв. Түүний тодорхойлсноор (1993: 9) XIII зуунд аман уламжлалыг ‘заншлын хууль’ болгон бичих нь соёлын шинэ чиг хандлагыг илэрхийлж байв. Заншлын эрх зүй нь бичмэл хэлбэртэй байж болох ба эрх зүйн тогтолцоо нь бусад ажил үүргийн хүрээнээс ялгаатай байж болно гэсэн санаа нь канон болон Ромын эрх зүйн нөлөөг эсэргүүцэх оролдлогоос үүдэлтэйгээс гадна тэдний оюуны тулгуур, системчилсэн уялдаа холбоог дуурайж байв. Эстер Кохэний үзэж буйгаар энэ бол XIII зууны харьяаллын төлөөх тэмцэл байж, хуульчдыг өөрсдийн системийн уялдаатай бичмэл хувилбарууд гаргаж хил хязгаарыг тодорхой шугамаар тогтооход хүргэсэн (1993: 27).

Хамгийн эртний *customs* зан заншлын цуглуулгууд дагуу улс бүр өөрийн гэсэн ёс заншилтай байсан нь батлагддаг. Тэдгээр нь ерөнхийдөө хувийн гарын авлага хэлбэрээр бичигдсэн бөгөөд нутгийн ноёдод шударга ёс хэрэгжүүлэх, өөрчлөлтүүд гарахад уламжлалаа хадгалан үлдэхэд нь туслах үүрэгтэй байв (Кохэн 1993: 31-32). Тэдгээр нь ихэвчлэн тодорхой түүх, нөхцөл байдлыг хүүрнэн өгүүлдэг байсан (Блоч 1977: 4-5). Гэхдээ зохиогчид хааны эсвэл гүнгийн түшмэдийн хувьд өөрсдийн асуудлыг өсөн нэмэгдэж буй хааны ёслолын байгууллагатай нийцүүлэхийг хичээдэг байв. Кохэн (1993: 33)-ий дэвшүүлж буй үзэл санааны дагуу бичээчид Ромын эрх зүйг наад зах нь тодорхой хэмжээгээр мэддэг байсан бөгөөд Ромын эрх зүй бол ердийн хуулиас хавьгүй илүү нэр хүндтэй, дээд зэргийн тогтолцоо байсан гэх сэтгэгдэл дээр нэгдэж байсан бололтой. Хууль, шударга ёс, эрхийн хийсвэр ангиллууд, тодорхойлолтуудыг эмхтгэлүүдээс бараг бүхэлд нь үг бүрчлэн авсан байдаг. Жишээ нь зохион байгуулалтын загварыг ихэнхдээ Дигест эсвэл хууль тогтоомжоос нутагшуулан авч байв. Кохэн (1993: 36) -ий бичсэнээр тэд арвин их мэдлэг агуулсан, бичмэл тогтолцоонд ихээхэн хүндэтгэлтэй ханддаг байсан бөгөөд Ромын эх үүсвэрүүдийн бүтээл оюуны зүй тогтлын шинж төрх агуулж байв.¹³ Хяамс (2000: 64) -ын бичсэнээр өмнөд Европт, *le pays du droit écrit* (франц. бичмэл хууль бүхий улс болохын хувьд), Ромын эрх зүйн өв уламжлал нь Юстинианы төрөлжсөн хуулийг хүлээн авагч эрх зүйн

¹³ Түүний хэлснээр эдгээр бичээчид бие биенийхээ бүтээлийг мэддэг байсан бөгөөд жишээлбэл Боманоироос маш их хуулбарлан авсан боловч эдгээрийг огт эх сурвалж болгон дурдалгүйгээр Ромын хэлбэрийг ‘занишлын хувьд өнгөлөн далдлалт’ болгон ашигладаг байжээ (Кохэн 1993: 36).

схемд оруулахад бэлэн болсон, модульчлагдсан эрх зүйн хэлбэрүүдийн сан гэж үзэж болно. Альпийн нурууны хойд хэсэгт ч гэсэн шинэ droit coutumier (нийтлэг эрх зүй), заншлын хуулийг ихэвчлэн латинаар бичдэг байсан тул энэ нь Корпус Иурисын томъёололд анхаарал хандуулах нь дамжиггүй юм.¹⁴

Тиймээс нутгийн зан заншлын бүртгэл хэмээн толилуулж буй зүйл нь ихэд харийн уламжлалаас ихээхэн урам зориг авч, нутагшуулсан хэлбэр, ангиллуудтай байж болох юм. Заримдаа энэ үеийн түүхчид уламжлалт шүүхүүдийн хэрэглэдэг бичигдээгүй ‘заншлын хууль’ -ийг тэмдэглэсэн байх учиртай бичмэл хууль, зан заншлуудын салшгүй хэсэг гэж нэрлэдэг. Гэхдээ энэ ‘хууль’ гэгч нь чухам юу байсан бэ? Хууль тогтоогчид процессын, өөрчлөгдөж шинжтэй хэмээн хүлээн зөвшөөрдөг ‘зан заншлын эрх зүй’ болон нутгийн зан заншлын талаарх ойлголт хоорондоо нягт уялдаа холбоотой хэмээн таамаглахдаа бид маш болгоомжтой байх хэрэгтэй (Козэн 1993: 39-42). Бичмэл хууль нь нийгмийн зохион байгуулалтын эрс шинэ хэлбэрийг илэрхийлж болох бөгөөд Чейетт (1970) онцолж хэлснээр шүүхийн процессын шинэ хэлбэрийг хялбарчилсан байдаг.

Хууль нутагшуулан авах нь ихэвчлэн хүсэл эрмэлзэлтэй явагддаг бөгөөд ингэснээр соёл иргэншилтэй, боловсронгуй уламжлал гэж үздэг зүйл дээр тулгуурлаж, үүнд жигд байдалд хүрэх гэсэн энгийн хүсэл эрмэлзэл багтах боломжтой байна. Германд Ватсон (1985: 2-р бүлэг) XII зууны үед хууль тогтоомжийн хувийн цуглуулга болох Шпигель (шууд утгаараа ‘толь’)-д бичсэний хамгийн алдартай бөгөөд нөлөө бүхий нь Саксеншпигель байсан гэж тодорхойлдог. Энэ нь хувийн, эрүүгийн, үндсэн хууль, феодалын хуулиудыг агуулсан бөгөөд папын аравнайлах хэлбэрийг дагаж мөрдөж байсан боловч хууль ёсны болон шашны янз бүрийн эх сурвалж ашигладагт зөвхөн Ромын эрх зүй шууд бусаар нөлөөлж байв. Ватсон (1985: 30-31) бичсэнчлэн энэ нь хэдийгээр хувийн бүтээл байсан бөгөөд хууль тогтоох эрх мэдэлгүй байсан ч удалгүй Саксонийн хил хязгаараас давсан нөлөө бүхий хууль гэж үзэх болсон ба хэд хэдэн герман аялга руу хөрвүүлэгдснээс 200 гаруй гар бичмэл үлдсэн байдаг. Тийм учраас бүс нутгийн ач холбогдол бүхий бүтээл нь дор хаяж илүү ерөнхий хуулийг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзлийг илэрхийлсэн юм.

¹⁴ Хяамс (2000: 65) цохон тэмдэглэснээр эрх зүйн байгууллагуудын хувьд Ромын нэр томъёо батлагдсаны дараа хууль тогтоомжид илүү сайн суралцсан үе үеийн хуульчид олж авсан эрх зүйн ойлголтуудыг нутгийн хууль тогтоомжид илүү гүн гүнзгий нэвтрүүлэх боломжийг бүрдүүлдэг ius civile болон өөрсдийн зан заншлын хэрэглээ хоорондын зөрчилдөөнийг анзаарч, эргэлзэх магадлалтай байна.

Хууль нутагшуулан авсан талаар энэ үеийн өөр нэгэн жишээг хууль олж, тунхаглах үүрэгтэй хот бүрт байгуулагдсан Шоффены бүлэг иргэдийн үйл ажиллагаанаас харж болно. Ингэхдээ тэд хотын бичигдсэн ёслолууд, зан заншил, нутгийн хууль тогтоомжийг тунхагласан аливаа Шпигель болон өөрсдийн сайн санаанаас сэдэл авсан байх боломжтой (Ватсон 1985: 31-32). XIV зууны үед зарим хотуудын Шоффеныг бусад хүмүүс эрх зүйн дүгнэлт хийлгэхээр эрэлхийлж эхэлсэн бөгөөд тэдгээрийг ‘эх’, ‘охин’ хот гэж нэрлэснээр уг практик албан ёсоор батлагдсан. Энэ харилцаа нь Ватсоны онцолж хэлснээр улс төрийн ноёрхол, охин нь ‘ээж’ хотоо өөр хотоор сольж магадгүй юм. Гэхдээ гайхалтай нь, ээж Шёффен охиныхоо хууль ёс, ёс заншлыг судлах оролдлого хийхгүй бөгөөд асуултанд хариулахдаа өөрийн нутгийн ёс заншил, зөв мэдрэмжийн дагуу хариулт өгдөг байв (1985: 39). Гэсэн хэдий ч Шоффений тогтолцоо нь хууль тогтоомжийн талаарх нутгийн хяналтыг нэр хүндтэйгээр хүлээн зөвшөөрч, хүчирхэгжүүлсэн боловч Германы жижиг хотууд сайн дураараа бусад, магадгүй эрх зүйн хувьд илүү нэр хүндтэй, төв суурин газруудад өөрсдийн хууль ямар байх ёстойг хэлж өгөхийг хүсч байв.

Хууль нутаг дэвсгэрийн шинжтэй байсан ч эдгээр Германы хотууд эсвэл Францын хойд хэсгийн улсууд шиг, тэр ч байтугай хөршүүд эсвэл түрэмгийлж буй улсын эсрэг бие даасан байдлын баталгаа хэмээн үзэж болох ч ёс суртахууны эсвэл оюуны нэр нөлөөний томоохон хүрээнүүдтэй холбон авч үзэх хэрэгтэй. Хуулийн эх сурвалжтай ижил хамааралтай байх нь ногдуулах болон ноёрхохоос илүүтэй нутагшуулан авч, үлгэр дуурайлал үзүүлэх замаар тодорхойлогддог.

Овог, тосгоны оршин суугчид илүү том эрх зүйн тогтолцооны хүрээнд өөрсдийн хуулиа бий болгож буй жишээнүүд нь нутагшуулан авах, сүнслэг нөлөө үзүүлэх үйл явцын нарийн ширийнийг анхаарч үздэг. Зарим тохиолдолд илүү том тогтолцооны ул мөр нь мэдэгдэж буй албан ёсны стандарт эсвэл бичвэрийг дурдах, батлахад илт ажиглагддаг. Бусад дүрмийг улс төрийн шахалтын хариуд боловсруулж, автономит байдал, орон нутгийн иргэдийг баталж болно. Ийм динамикийг орчин үеийн тохиргооноос харах боломжтой.

БРИТАНИЙН ВИРЖИНИЙ АРЛУУДЫН ХУУЛИУД

Британийн Виржиний арлууд нь Карибын тэнгис ба Маурер дахь Британийн хараат нутаг дэвсгэрийг бүрдүүлдэг (1995) нь XX зууны хоёрдугаар хагаст тэнд байгуулагдсан улс үндэстний байгуулалтын үйл явц дахь эрх зүйн үүргийг тодорхойлсон байдаг. Арлын оршин суугчид хөршүүдээсээ өөрсдийгөө ‘хууль дүрэмтэй’ хүмүүс хэмээн

ялгадаг бөгөөд тэдний орлогын гол эх үүсвэрүүдийн нэг бол чинээлэг бизнес эрхлэгчид, хувь хүмүүст санал болгодог татварын диваажин юм. Тэдний үндэсний шинж чанарыг хуулийн үүднээс барьж байгуулах нь Европын хөгжлийн үндэсний түүхийг дуурайсан. Хэдий тийм ч практик дээр шинэ хууль бий болгоход хурцадмал байдал давтагдаж байна: ‘нутагшуулсан хууль’, ялангуяа Хамтын нөхөрлөлийн бусад улс орнуудад боловсруулж, Их Британийн Ерөнхий прокурор нутаг дэвсгэртээ дасан зохицох зорилгоор Британийн Виржинийн арлуудын хууль тогтоох зөвлөлд авчирсан асуудалд санаа зовниж байна: зарим арлын оршин суугчид өөрсдийн ‘өвөрмөц байдал’-ыг харуулахын тулд өөрсдийн хууль хэрэгтэй гэж үздэг. Гэвч практик дээр ийм хуулиуд зөвлөлөөр дамжин өнгөрдөг. Нутагшуулан авахад тав тухгүй байдал нь ямар нэгэн колончлолын засаглалын тасралтгүй шүүмжлэлийн нөлөөнд автуулаагүй.

Татварын диваажингийн байгууламжийг бий болгосон 1984 оны Олон улсын бизнесийн компаниудын тогтоол бол Британийн Виржинийн арлуудын анхны хууль тогтоомжийн хамгийн чухал жишээ юм. Шийлийн Кабилид олдсонтой харьцуулбал энэ нь хууль боловсруулах буюу зохиогчийн эрхийг чухалчилж байсан бөгөөд энэ нь арлын оршин суугчдад уг тогтоолыг ‘өөрсдийн’ хууль тогтоомж гэж үзэх боломжийг олгосон юм (Маурер 1995: 275–76). Хожим нь бусад бүтэлгүйтсэн татварын диваажинтай холбоотой дуулианы дараа газар нутгийн нэр хүндэд санаа зовсны улмаас Их Британийн Гадаад хэргийн яамны удирдамжийн дагуу шинэ хууль тогтоомж боловсруулахад хүргэсэн боловч АНУ-тай байгуулсан гэрээ нь холбооны мөрдөн байцаагчдад оффшор дахь санхүүгийн бүртгэлүүдээ нарийвчлан шалгах боломжийг олгосон. Маурерын хэлснээр Британийн Виржинийн арлуудын бие даасан байдлыг харуулж, ялгаатай байдлыг үүсгэж, хил хязгаарыг тогтоосон ‘өөрийн’ зарлиг нь Британийн Виржинийн арлуудыг дэлхийн эдийн засагт илүү хүчтэй нэгтгэж, АНУ-ын эдийн засгийн ноёрхолд оруулахад үйлчилсэн юм (1995:283).

Эдгээр динамик байдал нь эрх зүйн империализмын нөлөөг харуулах болон Дарьян-Смитийн (2000: 818) хэлсэнчлэн орчин үеийн барууны хууль тогтоомжийн хэт давамгайлсан жинг харуулахаас ч илүү төвөгтэй юм. Хуулийн засаглал, хараат бус шүүх засаглалтай, соёлтой, орчин үеийн гэж өөрсдийгөө харуулах нь бусад нийгэмд эзэн хааны эрх мэдлийг булаан авах боломжийг олгосон (Мэрри 2003) бөгөөд Британийн Виржинийн арлуудын хувьд албадлагаас илүү дуурайх үйл явц байсан бөгөөд үүнд эдийн засгийн зорилго, орчин үеийн дэлхийн эдийн засагт тодорхой байр суурь эзлэх хүсэл эрмэлзэл нөлөөлдөг.

Бутаны бас нэг жишээг дурдъя: энд орчин үеийн шинэчлэгдсэн муж өвөрмөц түүхээрээ бахархаж, шинэ эрх зүйн тогтолцоог хөгжүүлэхийн тулд Англи-Америкийн эрх зүйн үзэл баримтлал, уламжлалд ихээхэн анхаарлаа хандуулсан (Вайткросс 2009). Эдгээр үйл явдлыг тэгш бус хүч чадлын динамик талаас шинжлэх нь хууль нутагшуулан авах хүсэл эрмэлзэл, үзэл суртлын талууд, тэдгээрийн урт удаан хугацааны, дэлхийн хууль ёсны даган дуурайлтын түүхэн дэх резонансыг орхигдуулах юм.

ЁС СУРТАХУУН БА ИДЕАЛУУД

Хууль нь эдгээр жишээнээс харахад засгийн хэрэгслийн хэрэгсэл, зөрчилдөөнийг шийдвэрлэх хэрэгсэл эсвэл эрх мэдлийн техник хэрэгсэлтэй адил ёс суртахууны үнэт зүйлсийн илэрхийлэл болох боломжтой. Хуулиуд нь зуучлах ажиллагааны явцад давж заалдах үзэл санааг агуулж, илэрхийлж болох боловч ихэнх тохиолдолд тэдгээрийг шүүхийн шийдвэр гаргах зорилгоор хэрэглэж байсан нь илт харагддаггүй. Хуулийн эмхэтгэл нь овгийн үнэт зүйлсийн тухай мэдэгдэл эсвэл тосгоны оршин суугчдын ялгааг илэрхийлж болох юм. Эсрэгээр, нутагшуулсан хууль хэлбэрийг батлах нь шашин шүтлэг, ёс суртахууны хүрээнд өргөн хүрээтэй оролцох, шариатын үнэн эсвэл Христийн шашны жаяг, Ромын оюун санааны хэлбэрийн соёл иргэншил, эсвэл орчин үеийн дэлхийн эдийн засаг дахь санхүүгийн захирамжийн 'хууль, дэг журам' билэг тэмдгийг илэрхийлж болно.

Эдгээр тохиолдол бүрд хууль тогтоох үйл ажиллагаа, эсвэл зүгээр л хуультай болох мэдрэмж нь өөрөө чухал ач холбогдолтой бололтой. Хуулиар илэрхийлсэн зүйл нь чухал ач холбогдолтойн адилаар шударга ёсны болон ёс суртахууны дээд дэг журмыг батлах далд амлалт ч чухал. Эрх зүйн хэлбэр нь зөвхөн илүү өндөр үнэт зүйлсийн багцыг төдийгүй илүү том, магадгүй илүү боловсронгуй эсвэл дэлхийн дэг журамд оролцох мэдрэмжийг илэрхийлэх хэрэгсэл болох нь онц сонирхолтой. Энэ нь хууль тогтоогчдод халдаж, хүсэл зоригоо тулгах хүмүүсээс зай барих, эсвэл түүнтэй дүйцэх байдлыг нотлоход үйлчилж магадгүй юм.

Мэдээж хууль нь ёс суртахууны үнэт зүйлийг илэрхийлдэг гэж хэлэх нь түүнийг төвлөрсөн засгийн газар эсвэл дарангуйллын хэрэгсэл болгон ашиглах боломжгүй гэсэн үг биш юм.¹⁵ Үнэхээр ч

¹⁵ Түүхэн жишээ олон бий. Кланчигийн (1979: 25) хэлсэнчлэн, Домесдэй ном нь байлдан дагуулсан ард түмнийг бичгийн хуулийн засаглалд оруулах зорилготой байсан бол Бонте (2000) XIX зууны Мавританид шашины овог аймгууд олон тооны тариалангийн талбай, дал модны төглийг хэрхэн эзэмшиж амжилтад хүрснийг тайлбарласан. Учир нь тэд цаасан дээр буулгасан үг, эрх зүйн эрдэм мэдлэг, шүүх ажиллагааны монополь эрхийг барьж байв. Түүнээс гадна нэг

хууль ‘авалтаа хууль ёсны болгох’ (Надер 2005: 199), юмуу ‘харгис хүчийг хууль ёсны угаалгад оруулах’ (Комаров ба Комаров 2006: 31) боломжтой; тэд нутгийн динамикийг танил бус ангилалд оруулж, хувь хүмүүсийг ‘юмс’ -аас багахан хэмжээнд л илүү мэт харагдуулж болзошгүй (Фокс 1993: 184; Стратерн 2004: 233). Гэхдээ энэ нь хуулийг бүхэлд нь илтгэхгүй бөгөөд ноёрхол, хүч чадал, хяналтын загварууд гэрэлтүүлснээсээ илүү бүрхэж магадгүй. Фицпатрик (1992) хуулийг эрх мэдэлтэй адилтгахдаа хууль ба бүрэн эрхт байдлын тэгшитгэлээс эхлэхийг санал болгосон. Хуулийн хууль ёсны хүчийг орчин үеийн домог гэж үзэж, түүхэн нөхцөлд нь хамаатуулан ойлгох хэрэгтэй. Энэ бүлгээс харахад хууль эрх мэдлийн төлөөх тэмцэл, засгийн газар, дээрэм тонуулыг хууль ёсны болгохоос илүү их зүйлд хамаатай. Энд хэлэлцэгдсэн тохиолдлын аль ч тохиолдолд хуулийг шууд байдлаар албаддаггүй. Энэ нь захирагчийн үйл ажиллагааны нөлөөгөөр бий болсон, эсвэл олонд танигдсан, өндөр үнэлэгдсэн загваруудаас их хэмжээний нутагшуулан авсан байж болох ч ихэнх тохиолдолд дуурайх түлхэц нь дотоод шинж чанартай байсан. Хууль, эсвэл эрх зүйн хэлбэрийг нутагшуулан авах гэдэг нь тэдний эрх мэдэл өөр газар, ядаж хэсэгчлэн үндэслэдэг болохыг, хууль өөрөө захирагчийн эрх мэдлээс ангид буюу давж гарч болохыг хүлээн зөвшөөрөхийг шууд утгаар илэрхийлдэг.

Үүний үр дүнд захирагчийн эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, түүнчлэн захирагчаар бүтээгдэх боломж нь хууль, эрх баригчид, төрийн хоорондох нарийн төвөгтэй харилцаанд хүргэдэг. Эдгээр асуудалд дараагийн бүлэгт хандах болно.

*Орчуулсан: Монголын Криминологичдын холбооны ахлах судлаач
С.Номынбаясгалан, гэрээт судлаач О.Анударь, З.Тамир*

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

нийгэмлэгийн ёс суртахуун нь нөгөө нийгэмлэгийн ёс суртахуунаас өөр байж магадгүй юм: эмэгтэйчүүд, хүүхдүүд овог аймгийн бүрэн гишүүд биш байсан Йемений ертөнц орчин үеийн баруун зүгийн жишигт нийцэхгүй байгаа бол Голук овог аймгууд эхнэрүүдээ олон талаар дорд үзсэн хэвээр байдаг.



Х.МӨНХЗУЛ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн

АХМАДЫН ЭРХИЙН КОНВЕНЦ БАТЛУУЛАХ ТҮҮХЭН ҮЙЛ ЯВЦЫГ УРАГШ АХИУЛАХАД МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛЖ ЧАДЛАА

Хурдацтай өсөн нэмэгдэж буй насжилтын асуудал улс, үндэстнүүдийн онцлог, ялгаатай байдлаас үл хамааран нийгэм, эдийн засаг, соёл, хүн ам зүйн олон сорилтыг үүсгэж, дэлхий нийтийн тулгамдсан асуудлын нэг болоод буй. Тиймээс ахмад настны эрхийн талаар ХЭҮК-ын гишүүн Х.Мөнхзултай ярилцлаа.

ХЭҮК-оос санаачилж, тэр дундаа та манлайлан ажиллаж “Идэвхтэй насжилт: ахмадад ээлтэй нийгмийг бүтээх нь” Ази Номхон далайн бүсийн орнуудын форумыг зохион байгууллаа. Форумыг зохион байгуулах зорилго нь юу байв?

Насжилтыг халамж гэдэг утгаар ойлгож зөвхөн энэ чиглэлд анхаарал хандуулж, хүний эрх талаас нь асуудалд хандаагүйн улмаас хүний эрхийн зөрчлүүд үүссээр байна. Тэдний талаарх “халамж хүртэгчид, тэтгэврийн хөгшин хүмүүс” гэх ойлголт, хандлага нь ахмад настан үл хайхрагдах, ялгаварлан гадуурхалтад өртөх, төрийн бодлого шийдвэрийн гадна үлдэх суурь шалтгаан болдог. Нас ахиснаар хүний эрх нь бүдгэрэх, эрхээ эдэлж чадахгүйд хүрэх байдал ганц манай улсад гэлтгүй, дэлхий нийтийн түвшинд байгаа үзэгдэл. Тиймээс ахмад настан ч бусад хүнтэй ижил эрх эдэлдэг, нийгмийн тэгш эрхт гишүүн гэж хүлээн зөвшөөрөх, ахмадуудын нийгмийн амьдралд оролцох оролцоог нь хангаж, ээлтэй орчин, нөхцөлд бие даан шийдвэр гаргаж амьдрах боломжийг нэмэгдүүлэх замаар идэвхтэй насжилтыг дэмжихэд ахмадын эрхийн бие даасан конвенц зайлшгүй шаардлагатай болоод байгаа юм. Тиймээс энэхүү форумыг

зохион байгуулах болсон хамгийн гол зорилго нь Ахмадын эрхийн конвенц батлуулах ажлыг урагшлуулахад Монголын Хүний эрхийн Үндэсний Комисс хувь нэмрээ оруулах, бүс нутагтаа манлайлах явдал байлаа.

Ахмадад ээлтэй нийгэм бүтээхэд конвенц ямар үүрэгтэй байх вэ?

Сүүлийн жилүүдэд насжилт эрчимтэйгээр нэмэгдэж, 2050 он гэхэд Монгол Улсын таван хүн тутмын нэг нь ахмад настан болох хүн амын хэтийн тооцооны дүн гараад байгаа. Дэлхийн нийт хүн амд ч ахмад настны эзлэх хувь нэмэгдсээр 25 жилийн дараа гэхэд 1.6 тэрбумд хүрэх тооцоо бий. Ийнхүү ахмад настны тоо эрчимтэй өсөж буй нь нөхөн үржихүйн бууралт, хотжилт, шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлт, тэтгэврийн асуудалд нөлөөлж уламжлалт халамжийн тогтолцоог сулруулахад хүргэснээр насжилттай холбоотой нийгэм, эдийн засгийн томоохон сорилтуудыг улс орнуудын өмнө бий болгоод байна. Тиймээс энэ асуудлыг урьдчилан төлөвлөх, угтан шийдэх бодлогын арга хэмжээг одооноос төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлага дэлхийн улсуудын өмнө тулгарсан. Түүнчлэн ахмад настны эрхийг олон улсын хууль эрх зүйн хүрээнд баталгаажуулах, ахмадын эсрэг насаар ялгаварлан гадуурхалттай тэмцэх, ахмадын амьдралын чанарыг дээшлүүлэх шаардлагатай. Гэтэл өнөөгийн байдлаар ахмад настны эрхийг бүрэн баталгаажуулсан бие даасан олон улсын гэрээ, конвенц алга. НҮБ-ын Насжилтын асуудлаарх нээлттэй ажлын хэсэг байгуулагдаад 14 жил болсон ч төдийлөн амжилт ололгүй өдийг хүрсэн. Харин Хүний эрхийн болон иргэний нийгмийн байгууллагуудын олон жилийн шаардлага, дуу хоолой, нөлөөллийн үр дүнд энэ 2025 оны гурав, дөрөвдүгээр сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл чуулганаараа хэлэлцээд 58/13 дугаар тогтоолыг батлан, ахмадын эрхийн талаарх олон улсын заавал биелэх хэм хэмжээ бүхий баримт бичиг, өөрөөр хэлбэл конвенцын төслийг боловсруулж Хүний эрхийн зөвлөлд өргөн барих мандат бүхий Засгийн газар хоорондын ажлын хэсэг байгуулахаар болсон. Конвенцтой болсноор төрийн үүрэг оролцоо тодорхой болж, хариуцлагыг нэмэгдүүлж, Засгийн газрууд бодлого боловсруулж, ахмадын асуудлаар дорвитой арга хэмжээ авахад чиглүүлдэг. Түүнчлэн бие даасан конвенцтой болсноор ялгаварлан гадуурхалт буурах, ахмад настны эрхийг дэмжих замаар нийгмийн амьдралд тэгш оролцуулах, нийгмийн баялгаас ижил тэгш хүртэж, илүү ээлтэй орчин бүрдэх ач холбогдолтой.

Иргэдийн дунд конвенцын талаар ойлголт муу байна. Хүний эрхийн Конвенц гэж юу юм, конвенц баталчихаар бүх юм сайхан болчих юм уу гэх зэрэг асуултыг тавьдаг.

Конвенцыг энгийнээр тайлбарлавал, улс орнуудын хүний эрхийн талаарх чиг үүргийг зохицуулах зорилгоор гаргасан олон улсын гэрээ. Олон улсын түвшинд хүний эрхийг Хүний эрхийн түгээмэл тунхаглал, олон улсын нийгэм соёлын эрхийн факт, иргэний болон улс төрийн эрхийн факт зэрэг хүний эрхийн чиглэлийн конвенцууд байдаг ч насаар ялгаварлан гадуурхахаас хамгаалах ухагдахуун өдий хүртэл байдаггүй. Тэгэхээр конвенц батлагдсанаар Засгийн газрууд үүрэг хүлээж эхэлснээр эдийн засгийн өсөлт хөгжлөөс үл хамаарч улс орнуудад ахмад настнуудыг ялгаварлан гадуурхалт буурах боломжтой. Мөн хууль тогтоомжоо конвенцын агуулгад нийцүүлэх, конвенцын хэрэгжилтийг тодорхой давтамжтайгаар НҮБ-ын Конвенцын хороонд тайлагнаж, цаашид авч хэрэгжүүлэх, анхаарах асуудлаар зөвлөмж авах зэрэг чухал ач холбогдолтой. Тухайлбал Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдрал, нөхцөл байдлыг ил гаргахад чухал нөлөө үзүүлсэнтэй адил, ахмадын Конвенц батлагдвал ийм өөрчлөлт бий болгох боломжтой гэж харж байна. Ахмад настны эрхийн асуудлыг бодлого, төлөвлөлтөд үл үзэгдэх, үл ойшоогдох, үл тооцогдох байдалтайгаар үүнээс цааш бид үлдээж болохгүй.

Форумын үеэр онцолж ямар асуудлыг хэлэлцсэн бэ?

Мэдээж хэлэлцсэн асуудал бүр чухал байсан. Форумын үеэр хоёр салбар хуралдаан болж, нэгдүгээр салбар хуралдаанаар халамж эмзэг байдлаас хүний эрхэд суурилсан арга барилд шилжих талаас асуудлыг хөндөж ярилцсан. Өөрөөр хэлбэл, ахмадын эрхийн асуудлын цаана хүний эрхийн ямар, ямар зөрчил үүсээд байгааг хэлэлцсэн. Мөн Ази Номхон далайн бүсэд хурдацтай өсөж буй насжилтын асуудал нь нийгэмд, тогтолцоо, бодлогод ямар ямар сорилт, бэрхшээл асуудлыг авчирч буйг шинжлэн ярилцсан. Нөгөө салбар хуралдаанаар, ахмадын эрхийн конвенцыг батлуулахын тулд бид ямар стратегитай, хэрхэн ажиллах вэ. Яаж дуу хоолойгоо хүргэж, конвенцын асуудлыг урагшлуулах вэ гэдэг талаар ажил хэрэгч яриа өрнүүлж байр сууриа нэгтгэсэн. Мөн олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааны талаар туршлага хуваалцаж, цаашид хамтран авч хэрэгжүүлэх шийдлээ тохирсон гэх мэтээр бүтээлч, үр дүнтэй яриа хэлэлцүүлгүүд өрнөсөн гэж хэлж болно.

Үр дүнг оролцогч бүр өөр өөрөөр дүгнэж байж магадгүй. Монгол Улсын хүний эрхийн үндэсний байгууллагын хувьд форумын үр дүнг хэрхэн дүгнэж байна вэ?

Юуны өмнө, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл 58/13 дугаар тогтоол гаргасан нь ахмадын эрхийг баталгаажуулж хамгаалах заавал биелүүлэх

эрх зүйн цогц хэм хэмжээ бий болгох шаардлагыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн түүхэн мөч байсан. Энэхүү түүхэн мөчийн үргэлжлэл болж энэхүү форумыг зохион байгуулсан нь онцгой ач холбогдолтой үйл явдал юм. Өөрөөр хэлбэл, конвенц батлуулах түүхэн үйл явцыг урагш ахиулахад Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс хувь нэмрээ оруулж чадлаа. Форумд оролцогчдын зөвшилцлийн үр дүнд “Улаанбаатарын уриалга”-ыг гаргаж НҮБ-ын гишүүн улсыг конвенц батлуулахад идэвхтэй, шийдвэр төгс байхыг уриалж, ялангуяа хүний эрхийн үндэсний байгууллагууд болон хөгжлийн түншлэгчид цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээ нэн тэргүүнд бүсийн хэмжээнд тодорхойлон гаргаж, оролцогч талууд нэгдсэн ойлголтод хүрч чадсан нь чухал юм.

Конвенц батлуулах үйл явц цаашид ямар байдлаар өрнөх бол?

Засгийн газар хоорондын нээлттэй ажлын хэсэг конвенцын төсөл боловсруулах ажлыг эхлүүлж, конвенцын төсөлд тусгасан заалтуудыг Засгийн газруудад танилцуулж, ойлгуулах, саналаа илэрхийлэх, төслийг өргөн барих ажил үргэлжилнэ гэж найдаж байна. Тиймээс энэ чухал мөчид хүний эрхийн үндэсний байгууллагууд бүх талуудтай нэгдэн ажиллаж, идэвхтэйгээр дуу хоолойгоо илэрхийлж хүргэх нь чухал.

Ахмадын эрхийн асуудал зөвхөн конвенц батлагдаад, Засгийн газар шийдвэр гаргаснаар хангагдахгүй, ахмадын эрхийг хангахын тулд бүх нийтийн оролцоо чухал. Ялангуяа залуу үеийнхэн болон үр хүүхдүүд нь, ахмад настан өөрсдөө ч бодол, хандлагаа өөрчлөх ёстой байх, тийм үү?

Тийм ээ, бүх нийтийн оролцоо, хамгийн гол нь нийгмийн хандлагын өөрчлөх асуудал нэн чухал. “Би 55, 60 нас хүрчихлээ, одоо тэтгэвэрт гаръя, ахмад болчихлоо” гэж үзэх хүн байна. Гэтэл зарим нь өөрийгөө ахмад гэж хүлээн зөвшөөрөхгүй ч байж болно. Гаднын улс орнуудад автобусанд өөрийг нь ахмад настан гэж үзэн суудал тавьж өгөхөд дургүйцдэг хандлага байдаг. Цаг үе хувьсан өөрчлөгдөж байна, ахмад настан гэхээр л тэтгэвэр авагчид, нийгмийн эмзэг бүлэг гэж үзэж болохгүй. Конвенцын төсөл боловсруулахад хэнийг ахмад гэж үзэх вэ гэдэг асуудал маш чухлаар хөндөгдөх байх. Одоо бол улс орнууд нийтлэг байдлаар ерөнхийд нь 65-аас дээш насны хүмүүсийг ахмад гэж үзэж байгаа.

Манай өнөөгийн нийгэм бол хүнийг ахмад нас руу нь бараг түлхээд оруулчихаж байна. 55-60 нас хүрэх үү үгүй юү “Тэтгэвэртээ гар” гэж

ажлын байрнаас нь шахах асуудал нийтлэг ажиглагддаг.

ХЭҮК 2023 онд Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлдээ Монгол Улсын ахмад настны эрхийн асуудлыг тусгаж УИХ-д танилцуулж хэлэлцүүлсэн. Илтгэлд хэд хэдэн асуудлыг хөндсөний нэг нь ажил олгогч ажилтнаа тэтгэвэрт гарахыг шаарддаг зохицуулалтыг эргэж харах, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг санал зөвлөмжүүдийг гаргасан. Заавал ажлын найман цагаар бус тухайн хүний онцлог ялгаа, хэрэгцээнд нь таарсан ажлын байруудыг бий болгож, тохирсон цагаар ажиллуулах, ахмад настнуудад зориулсан ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжүүдийг дэмжих, тэтгэврийн насандаа хүрсэн ч тухайн хүн өөрөө хүсээгүй бол тэтгэвэрт гарахыг шаардахыг хориглох зэрэг Комиссын хүргүүлсэн зөвлөмжийн хүрээнд хэд хэдэн томоохон өөрчлөлтүүд хуульд орсон.

Ахмадад ээлтэй нийгэм гэдгийг та хэрхэн тодорхойлох вэ. Нийгэм нь ахмадаа ээлтэй, авч хэрэгжүүлдэг бодлого нь хамгийн сайн улс орны жишээнээс дурдвал?

-Ахмадад ээлтэй нийгэм гэдэг нь тэднийг нийгмийн тэгш эрхт гишүүн хэмээн хүлээн зөвшөөрч тэдний ялгаатай хэрэгцээ онцлог хэрэгцээнд суурилсан бодлого, үйл ажиллагааг авч хэрэгжүүлдэг, нийгмийн харилцаанд тэгш оролцож, нийгмийн баялгаас тэгш хүртэх боломжийг бий болгосон байхыг хэлнэ. Ахмад хүн бүр хоорондоо өөр, тиймээс ялгаатай хэрэгцээтэй. Тухайлбал ганц бие, харж хандах үр хүүхэдгүй, хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвар, эрүүл мэндийн байдал гээд өөр өөр нөхцөл байдалд амьдарч байгаа. Гэтэл төрөөс аливаа шийдвэр гаргахдаа тэдний ялгаатай хэрэгцээ, онцлог байдлыг төдийлөн харгалздаггүй ерөнхийд нь “ахмад” гэдэг нийтлэг байдлаар асуудалд ханддаг нь ахмадуудад ээлтэй байж чаддаггүй. Манай улсад ч ахмад настан нийгмийн амьдралд оролцоод явахад маш олон саад бэрхшээлтэй тулгардаг. Хамгийн ойрын жишээ гэхэд, ахмадуудад ээлтэй орчин дэд бүтэц бүрдээгүйн улмаас ахмадууд осол гэмтэлд өртөх тохиолдол олон. Осол гэмтэл авч эмнэлгийн тусламж авсан ахмад настны 62.7 хувь нь унаж гэмтсэн гэх Гэмтэл согог судлалын үндэсний төвийн мэдээлэл бий. Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2022 онд “Улаанбаатар хотын гэр хороололд амьдарч буй ахмад настны эрх, хамгаалал” сэдвээр судалгаа явуулсан. Судалгаагаар үр хүүхдээ хүлээгээд өдөржин гэртээ өнжиж, ганцаарддаг. Үеийн хөгшчүүлтэй уулзаад суух орчин байдаггүй гэж ихэнх оролцогч хариулт өгсөн байсан. Харин ахмад настнуудад ээлтэй, авч хэрэгжүүлдэг бодлого нь хамгийн сайн улс орны жишээ гэвэл Япон, Австрали улсыг нэрлэх байна.

Ялангуяа Япон улсын асаргааны даатгалын системийг судлах нь зүйтэй. Хүн өтлөхийн цагт хэн нэгний асрамжид орох нь ойлгомжтой. Тэр үед нь гэрийн нөхцөлд асрах уу. Асрах үр хүүхэд, ойр дотнын хүнгүй бол яах вэ гэдэг асуулт гарна. Тиймээс олон хувилбарт асаргааны үйлчилгээ, асаргааны даатгалын тогтолцоог одооноос бий болгох шаардлагатай байна. Өнөөдрийн байдлаар манай улсад зайлшгүй асаргаа шаардлагатай хүмүүсийн ердөө нэг хувь нь л асаргааны үйлчилгээг авч чадаж байна гэсэн судалгаа гарсан. Гэтэл зарим улс оронд, үр хүүхдэдээ дарамт үүсгэхгүй байхыг хүссэн, эсвэл үеийн хүмүүстэйгээ найзалж, нөхөрлөж, чөлөөтэй бие даан амьдрахыг нь дэмжиж гэрээ нүүлгээд очиж амьдрах орчныг нь бүрдүүлж өгсөн байдаг. Манай улс ч цаашид ахмадуудын онцлог, ялгаатай байдалд нь тохирсон олон хувилбарт асаргааны үйлчилгээ бий болгох, ингэснээр ахмадууд өөрт тохирохыг сонгож үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

Сүүлийн асуултаа танд үлдээе.

Монголчууд бол нүүдэлчин соёл иргэншилтэй, эцэг эх, үр хүүхэд, ач зээ гурван үеэрээ нягт холбоотойгоор бие биесээ хүндлэн дээдэлж, асарч хамгаалж аж төрдөг соёл уламжлалтай ард түмэн. Сүүлийн үед суурин иргэншилд шилжиж энэ соёл алдагдаад байна уу гэж эмзэглэдэг. Ахмадуудыг насаар нь ялгаварлан гадуурхаж, эрхийг нь зөрчдөг байдал гарсаар байна. Үе болгон өөр өөрийн гэсэн онцлогтой, төрж өссөн нийгмийнхээ тусгал нь байдаг шүү дээ. Гэтэл ахмад үе нь ч “одоогийн хүүхэд, залуус болохгүй байна” гэх хандлага гаргадаг бол хүүхэд залуучууд ахмад настнуудаа “хөгшин, үеэ өнгөрөөсөн” гэх мэтээр үе хоорондын зөрчилтэй асуудлууд ажиглагддаг. Иймд, үе хоорондын онцлогоо хүлээн зөвшөөрч, харилцан хүндлэл, ойлголцол дунд зэрэгцэн амьдрах ёстой гэж бодож явдаг.

Цаг зав гарган хүний эрхийн чиглэлээр судалгаанд суурилан нээлттэй ярилцсан танд баярлалаа. Таны цаашдын эрдмийн их ажилд нь амжилт хүсье.

*Ярилцсан: ХЭҮК-ын олон нийттэй харилцах асуудал хариуцсан
мэргэжилтэн М.Алтанцэцэг*

ТЭМДЭГЛЭЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

